



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ШУДАРГА ЁС ТОГТООЦГООЁ

Алтны үнэ өртгийг тооцох нь

ДЧХКША-ийн тайлан

DDC
622.342 2
Ш-903

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-314857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@soros.org.mn

Орчуулсан: Г. Батбаяр
Хянан тохиолдуулсан: Ц. Гомбосүрэн
Н.Дорждарь

Энэхүү номын монгол орчуулгыг Нээлттэй Нийгэм Форумаас эрхлэн хийсэн ба орчуулгын зохиогчийн эрхийг Нээлттэй Нийгэм Форум эзэмшинэ.
© 2007

ISBN 99929-0-191-8

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

Гарчиг

Орчуулгын үг	4
Талархал	5
Өмнөх үг	6
Оршил	7
Ерөнхий хураангуй	9
1. Алт дэлхий дахины бараа болох нь	12
2. Их Британи дахь алт	18
3. Хөгжиж байгаа орнуудын алтны үнэ өртгийг дэнслэх нь	25
4. Жишээ судлал: Гондурасын хувьд алтан боломж уу?	44
5. Жишээ судлал: Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь алтны хясланг арилгах нь	62
6. Өөрчлөлт хийх санал зөвлөмжүүд	75
Тайлбар, ишлэл	78

Орчуулгын үг

Байгалийн нөөц баялаг хишиг үү, хяслан уу? Эрдэмтэн мэргэд энэ асуултад нэгдсэн нэг хариу өгч чадаагүй байгаа билээ. Гагцхүү байгалийн баялаг бүхий улс оронд зөрчил тэмцэл, ядуурал газар авсан баримт даанч олон байдаг. Гэхдээ байгалийн баялгаа зөв зохистой ашиглан, хөгжилд хүрч чадсан улс орон ч байдаг ба Монгол орон чухам хөгжлийн энэ замаар явахын тулд бусдын туршлагыг судалж, дүгнэлт хийх нь чухал билээ.

Энэхүү номыг орчуулан, эрхэм танд толилуулах болсон учир нь чухам алт хөгжил авчраагүй гадны орнуудын гашуун туршлагыг тайлбарлаж, нөөцийн хясланг тойрч гарахад шаардлагатай арга замыг тодорхойлон зөвлөсөн нь эрдэс баялгийн зохистой удирдлагыг бий болгохыг эрмэлзэж буй манай улсын бодлого боловсруулагчид, түүнчлэн алтнаас хамаарч амьдарч буй жирийн иргэдэд нэгийг бодогдуулж, хоёрыг сануулна гэсэн итгэл үнэмшил юм.

Номыг орчуулсан Г.Батбаяр, хянан тохиолдуулсан Ц.Гомбосүрэн нарт гүн талархал илэрхийлж байна.

П. Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал

Талархал

Энэхүү тайланг Анне Линдсэй, Жералдин МакДональд нар судалж бичсэн бөгөөд Саараа Финч хянан тохиолдуулав. Цаг зав, мэдлэг, туршлагаа харамгүй зориулсан манай түнш байгууллагууд, түүний дотор Гондурасын Арквидиосесанагийн Каритасын Педро Ланда, Роза Гирон, Хуан Пабло Дюрон нар, Гондурасын ASONOG-н ажилтнууд, БНАКУ дахь Буниагийн Каритас, Гомагийн Каритасын ажилтнуудад маш их талархаж байна. Бас чухал санал шүүмжлэл, санаа оноо хэлсэн дараахь хүмүүст талархал илэрхийлж байна: Карлос Амадор, Флор Андерсон, Родолфо Артеага, Тара Бүрке, Антонио Кабрал, Мартин Круз, Ребекка Еванс, Алисон Фенний, Жорж Гелбер, Паул Холлесен, Гарри Ламберт, Кэрис Линкольн, Карен Лайкикс, Алисон Маршалл, Францис МакДонаг, Ричард Мурфи, Жеофф Неттлетон, Филип Ньюман, Луйс Нортон, Хенри Пэрхам, Софий Плагерсон, Радхика Сарин, Кейт Слак, Саараа Смит-Пийрс, Грег Валерио, Аннеке Ван Уүденберг, Эдуардо Виллакорта, Дебби Вайнврайт, Хелен Вольфсон. Алдаа мадаг байх аваас зохиогчид хариуцна.

Бид энэхүү тайлангийн талаар санал хүсэлт хүлээж авахдаа баяртай байх болно. Анне Линдсэйтэй alindsay@cafod.org.uk гэсэн хаягаар холбоо барихыг хүсье.

ДЧХКША буюу **Далайн Чанад дахь Хөгжлийн Католик Шашны Агентлаг** бол Англи, Уэлсийн Католик сүмийн хөгжил, тусламжийн асуудал хариуцсан олон улсын албан ёсны агентлаг бөгөөд 40 гаруй жилийн турш хөгжиж байгаа орнуудын ядууралтай тэмцэж байна.

ДЧХКША нь Католик шашны тусламж, хөгжлийн байгууллагуудын дэлхий дахины сүлжээ болох Олон Улсын Каритасын Холбооны гишүүн байгууллага юм.

Мөн ДЧХКША нь Европ, Хойд Америкийн 15 хөгжлийн байгууллагыг нэгтгэсэн CIDSE байгууллагын гишүүн билээ.

© CAFOD (ДЧХКША) 2006 оны 5 дугаар сар

Хаяг:
CAFOD
Romero Close
Stockwell Road
London SW9 9TY
Утас: 020 7733 7900
Факс: 020 7274 9630

www.cafod.org.uk
Буяны байгууллагын бүртгэлийн дугаар 285776

Өмнөх үг

Алт хүмүүсийг олон зууны турш хүчирхэг соронзон мэт татаж ирсэн. Алт байлдан дагуулал, мөргөлдөөнийг өдөөж, түүнийг олж эзэмшихийн төлөөх амь өрссөн аянд баян, ядуугүй мордоцгоож байна. Алт эд баялаг, зэрэг зиндаа, моод маяг, сэтгэл татах увдисын бэлэгдэл болж бидний амьдралд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ. Түүнчлэн алт дэлхий дахины эдийн засгийн гол элемент хэвээр байна.

Гэвч манай энэ олон тансаг гудамжинд алт хэрхэн хүрч ирдэг талаар бид тэр болгон боддогсон бил үү? Ганцхан Их Британид л гэхэд 2005 онд 20 сая орчим өндөр сорьцтой алтан эдлэл борлогдсоны олонх нь хайр дурлал, үүрэг амлалтыг бэлэгдсэн байв. ДЧХКША-ийн энэхүү тайланд алт олборлолтын бодит өртгийг тооцохын хамт алтны уурхайн ойр орчимд амьдардаг хүмүүст алт гай болдог уу, буян болдог уу, алтны үнэ хэдийд хэт өндөр болдог вэ, түүний үнэ өртгийг хамгийн эмзэг бүлгийхэн төлдөг явдлаас хэрхэн зайлсхийх вэ зэрэг асуултад хариу өгч байна.

Баян орнууд ядуу доройгоо өөд татаж, нэг нь нөгөөгөө золиосолж хөгждөггүй дэлхийн хамтын нийгэмлэг байгуулахад нь туслах үүрэгтэй гэж ДЧХКША үздэг. Католик шашны нийгмийн сургаалыг үндэс болгон ДЧХКША нь, уул уурхайн компаниуд ядуу буурай орнуудад үйл ажиллагаа явуулахдаа дан ганц хувийн ашиг сонирхолд хөтлөгдөлгүйгээр ажиллаж, тухайн улсад илүү сайн сайхан нийгэм бий болгоход хувь нэмрээ оруулах ёстой гэж үздэг.

Алтны уурхайн хор уршгийг шийдвэрлэх бодит боломж одоо бий болоод байна. Үүнд уул уурхайн компаниуд, үнэт эдлэлийн газрууд, баян, ядуу орны засгийн газрууд, банк, санхүүгийн байгууллагууд бүгд үүрэг гүйцэтгэх ёстой. Түүнчлэн бид бүхэн ч алт хэрэглэгчийнхээ хувьд нутгийн ард иргэдийн хэрэгцээ шаардлага, эрхийг хүндэтгүүлэх талаар алтны уурхайн компаниудад шахалт үзүүлэхэд нэмэр болж чадна.

Чухамдаа энэ бол манай “Шударга ёс тогтооцгооё” кампанит ажлын тавьсан зорилго юм.



Крис Бэйн

ДЧХКША-ийн захирал

Оршил

ДЧХКША-аас “Ядуурлыг түүх болгоцгооё” байгууллагатай хамтран зээл тусламжийг нэмэгдүүлж сайжруулах, өрийг хүчингүй болгох, худалдааны шударга ёс тогтоохын төлөө кампанит ажил явуулсан. Уул уурхай нь “санхүүгийн тусламж”-ийн нэгэн адил ихээхэн эрэлт хэрэгцээтэй байдаг “хөгжлийн санхүүжилт”-ийн нэг эх үүсвэр болж чадна. Гэвч хөгжиж байгаа зарим оронд газрын тос, уул уурхайн орлого төр, засгийн байгууллагуудад авилга болон шингэж байна. Түүнчлэн бас бусад зарим орны хувьд, ирээдүйд орж ирэх орлогын хэтийн төлөв нь уул уурхай ба газрын тос олборлолтын жинхэнэ өртөг зардал ба үр ашгийн талаарх засгийн газруудын үзэл бодлыг бүдгэрүүлж байж болно. Өнөөдөр үнийн өсөлтөөс гадна урьд хожид байгаагүй үр ашигтай технологиудын хүчээр өмнө нь ашиггүйд тооцогдож байсан орд газруудыг сонирхол татам ирээдүйтэй орд болгон хувиргаж чадаж байгаа учраас уул уурхайн компаниуд хөрсөн доор хаана л ашигт малтмал, газрын тос байна түүнийг хайж олборлохыг эрмэлзэх болжээ. Үүний нөгөө талд уул уурхайн үйлдвэрлэлийн цочир өсөлтөд нэрвэгдэх ард иргэд, байгалийн эмзэг асуудал байгаа бөгөөд уул уурхайгаас болж буурай орны ядуу ард иргэд, нийгмийн бүлгүүд дэлхийн хамгийн хүчирхэг компаниудын заримтай ширүүхэн тулж, тэр ч бүү хэл мөргөлдөөн үүсгэж байна.

Ядуусын илүүд үзэх сонголт буюу дэлхийг орвонгоор нь эргүүлж, бүхнийг ядуу, доройчуудын нүдээр харах шийдвэр нь энэхүү харилцаанд маш болгоомжтой хандаж, тэдний хэлж ярих зүйлийг анхааралтай сонсож, шударга ёсны төлөө эв нэгдэлтэйгээр хамтран ажиллах үүрэг хариуцлагыг бидэнд ноогдуулж байна. Ийм ядуу, дорой хүмүүс бол уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд автаж хохирол амсах хүмүүс төдийгүй, хэрэв засгийн газар нь уул уурхайгаас олох орлогоо ухаалгаар зарцуулбал түүнээс хожиж ч болох хүмүүс юм. Баян орнууд хөгжиж буй орнуудтай эв нэгдэлтэй байж, зарим нэг нь бусдыгаа золиосолж хөгжилд хүрдэггүй дэлхийн илүү хүмүүнлэг хамтын нийгэмлэг байгуулах үйлсэд нэгдэн орох ёстой¹ гэж Католик шашны сүм хийд сургадаг билээ. Томоохон бизнесийн концернуудын төлөөлөгчдөд хандан хэлэхэд, тэд хөгжиж байгаа орнуудад “бизнесийн үйл ажиллагаа эрхлэхдээ амин хувийн явцуу ашиг сонирхолд автах биш”², нийгмийн хөгжил, хүний сайн сайхныг эхлэн санаачлагчид байх ёстой билээ.

Өнөөгийн уул уурхайн үйлдвэрлэлээс байгаль орчинд учруулж буй хор хөнөөлийг төсөөлөхийн аргагүй бөгөөд хэдхэн унц алтны төлөө цианидийн хүчил асгаж цацан бүхэл бүтэн уул толгодын өвс ургамлыг хуйхлаж байна. Гэвч байгаль дэлхий гэдэг бол зүгээр нэг өнөөдрийн биднийх шиг дураараа ашигладаг зүйл биш. Үүнийгээ бид тэтгэн тордож, хүндэтгэж, ирээдүй хойч үедээ өвлүүлж байх

¹ *Sollicitudo Rei Socialis*, 1987. Para 9

² *Populorum Progressio*, 1967. Para 70

Шударга ёс тогтооцгооё

ёстой. “Бүтээгчдээс хүн төрөлхтөнд олгосон ноёлох эрх бол хэмжээгүй эрх мэдэл биш бөгөөд түүнийг “ашиглах эсвэл буруугаар ашиглах” эсвэл дуртай зүйлээ хаяж устгаж байх эрх чөлөөний талаар бид ярьж болохгүй юм”³. Харин бид ёс суртахууны болон байгалийн хуулийг олж харж, хүндэтгэж байх үүрэгтэй бөгөөд хэн ч түүнийг цээрлэл хүлээхгүйгээр зөрчиж чадахгүй.

ДЧХКША-ийн “Шударга ёс тогтооцгооё” кампанит ажил нь компаниуд тухайн улсын засгийн газар, нутгийн ард иргэдтэй харилцахдаа бизнесийн өндөр хэм хэмжээ, ил тод байдлын зарчим баримталж, сахих явдлыг хөхиүлэн дэмжихийг эрмэлзэж байна. Түүнчлэн ДЧХКША нь өнөөгийн даяаршсан дэлхий ертөнц дээр сайн дурын дүрэм журам хэрэглээд нэмэргүй гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ компаниудад ёс зүйн өндөр хэм хэмжээ сахиулах хууль, эрх зүйн зохицуулалт гаргах талаар Гондурас улсын тавьж буй хүчин чармайлтыг дэмжиж байна.

Жорж Гелбер

Олон нийтийн бодлогын тэргүүн

³ *Sollicitudo Rei Socialis*, 1987. Para 34

Ерөнхий хураангуй

Алт бол эд баялаг, эрх мэдлийн бэлэг тэмдэг, гэвч хөгжиж байгаа орны үй олон хүний хувьд алтны уурхай ядуурлыг бууруулахад хувь нэмэр бага оруулж байна. Уул уурхай нь орлого, ажлын байр бий болгож чадна. Түүнчлэн ард иргэд, байгаль орчинд урт удаан үргэлжлэх хор хохирол учруулж ч чадна. Алтны уурхай бас зөрчил мөргөлдөөнтэй нягт холбоотой байдаг. Байгалийн үнэт баялгийг хяналтандаа авах гэсэн тэмцэл ч бай, уул уурхайн нөлөөгөөр ард иргэдийн дотор үүссэн хуваагдал ч бай ийм зөрчилд тооцогдоно. Эрдэс баялгаас хамааралтай хөгжиж байгаа орнууд авилга, муу засаглалаас болж зовж шаналах магадлал ч илүү их байдаг.

Энэхүү тайланд алтыг хөгжиж байгаа орнуудын ард иргэдэд хяслан биш, хүслэн болгож хувиргахын тулд юуг өөрчлөх шаардлагатай вэ гэдгийг авч үзнэ. Хойшлуулушгүй арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм. Дэлхийн алтны үйлдвэрлэлд хөгжиж байгаа орнуудын үйлдвэрлэлийн эзлэх хувь өссөөр байна. Олон алтны уурхай нилээд хязгаарлагдмал буюу арваас хорин жилийн настай байна. Иймд ашигт малтмалын нөөцийг газрын тос, байгалийн хий гэх мэт бусад сэргээгдэхгүй нөөцийн нэг адилаар ухаалгаар ашиглах нь онцгой чухал.

ДЧХКША дотоодын түнш байгууллагуудын хамтаар алтны уурхайн салбар нь хөгжлийнхөө шийдвэрлэх цэгт яваа хоёр өөр орныг авч үзэж байна.

Гондурас улсад 1990-ээд оноос хойш алтны уурхай цар хүрээгээ тэлжээ. Тус улс уул уурхайн олон улсын компаниудын эзэмшдэг цөөхөн том уурхайтай бөгөөд эдгээрт цөөн тооны ажилчид авч ажиллуулдаг. Тэд цаашид нилээн хэдэн гэрээт талбайд эрх олгуулахаар тус улсын засгийн газарт шахалт үзүүлж байна. Харин иргэний нийгмийн бүлгүүд уул уурхайн хуулинд Гондурасын ард түмний ашиг сонирхлыг илүү сайн тусгахуйц шинэчлэл хийхийн төлөө ажиллаж байгаа юм.

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад уул уурхайн компаниуд хэдэн жил үргэлжилсэн тогтворгүй байдал, мөргөлдөөнөөсөө дөнгөж салж байна. Алт олборлолтын бүс болох Итуригийн бүс нутагт гадны хөрөнгө оруулалтаас уул уурхайд авчрах өөрчлөлтүүдийн талаар их зүйлийг хүлээж байна. Одоо явуулж байгаа олборлолтын үйл ажиллагаанд гар аргаар олборлогчид болон бага хэмжээний алтны үйлдвэрүүд зонхилж байна. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжиж, цаашдын зөрчил мөргөлдөөнөөс зайлсхийхийн тулд олон улсын компаниуд нутгийн ард иргэдтэй нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Алтны уурхайн компаниуд дэлхийн хамгийн ядуу дорой хэсэг хүмүүсийн амьдралд асар их нөлөө үзүүлж байдаг. Хөгжиж байгаа орнуудын засгийн газар гадаадын хөрөнгө оруулалт, мэдлэг туршлагыг дотогш татан оруулах эрмэлзэлтэй байдаг. Иймээс уул уурхайн олон улсын компаниуд татварын хөнгөлөлтөөс ашиг

олж, нилээдгүй улс төрийн нөлөө үзүүлэх нь олонтаа. Уул уурхайн салбарын хүрээнд алтны уурхайтай холбоотой хүндрэл бэрхшээлүүдийг мэддэг болсон нь уул уурхайн тогтвортой үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих олон янзын санаачилга гарахад хүргэж байна. Стандартыг сайжруулах чиглэлд сайн дурын санаачилгууд тодорхой үүрэг гүйцэтгэж болох боловч тэд зохицуулалтыг орлож чадахгүй юм. Компаниуд үйл ажиллагааныхаа практикийг сайжруулах арга хэмжээ авч ажиллахаас гадна дараахь өөрчлөлтийг хийх шаардлагатай байгаа болно:

- **Олон улсын компаниудад зориулсан заавал дагаж мөрдөх стандартууд болон ард иргэдэд учирсан хохирлыг нөхөх үр нөлөөтэй арга хэрэгсэл боловсруулах.**
- **Үндэсний уул уурхайн хуулиудад өөрчлөлт оруулах.** Үндэсний хууль тогтоомж, татварын дэглэмүүд нь хөрөнгө оруулалтыг татах хүсэл сонирхлыг хүн амын дээд зэргийн ашиг сонирхолтой нягт уялдуулж, уул уурхайн компаниудад заавал биелүүлэх стандартуудыг, түүний дотор байгаль орчны болон нийгмийн хамгааллын зохих стандартууд тогтоож өгөх шаардлагатай. Мөн эдгээр хууль тогтоомжийг үр нөлөөтэй сахиулах хэрэгтэй.
- **Нутгийн уугуул иргэд болон хохирсон ард иргэдийн дуу хоолойг илүү хүчтэй болгох.** Алтны уурхайгаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө маш тодорхой, нэн ялангуяа түүний шууд нөлөөнд өртөж буй ард иргэдэд илэрхий харагддаг ч эдийн засгийн ашиг тусыг нь олж харахад хэцүү байдаг. Алтны уурхайн үйл ажиллагаанаас олсон олз ашиг цөөн тооны хүмүүсийн амьдралыг эрс дээшлүүлэх боловч хүн амын илүү өргөн хүрээнийхний хөгжилд дорвитой сайжралт гарахгүй байх нь олонтаа. Ард иргэд уурхайнуудтай холбоотой мэдээллийг тодорхой хэлбэрээр олж авч, уул уурхайн төслүүд цаашид үргэлжлэх эсэх, түүнээс олсон орлогыг хэрхэн ашиглах талаар үгээ илүү их хэлдэг байх шаардлагатай.
- **Уул уурхайн үйл ажиллагаа, орлогын талаарх мэдээллийг илүү хүртээмжтэй болгох.** Алтаар баян хөгжиж байгаа орнуудын ард иргэдэд алтны уурхайн өртөг зардал ба ашиг тусын талаар үнэн зөв мэдээлэл хэрэгтэй. Ашиглалтын гэрээнүүд, байгаль орчин, нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөний үнэлгээ, байгаль орчны хяналт шинжилгээний тоо баримтууд, үйлдвэрийг хаах төлөвлөгөө зэрэг нь бүгд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тавигдсан байх шаардлагатай. Компаниуд болон засгийн газрууд татварын орлого, төлсөн төлбөрүүдөө задлан гаргаж нийтлэдэг байх ёстой. Энэ нь алтны уурхайгаас ямар нөөц баялаг бий болж, хэн үүнээс ашиг олж, олсон ашгаа яаж зарцуулж байгааг мэдэж авах, энэ тухайн ойлголтыг дээшлүүлэхэд тустай.
- **Алтны уурхайн төслүүдийн санхүүжилтэд тавих шалгууруудыг чангатгах.** Алтны уурхайн салбар нь уурхайг амьдрах чадвартай байлгахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг, эрсдлийн даатгалтай байхын тулд олон улсын санхүүгийн байгууллагууд, экспортын зээлийн газрууд болон банкуудаас хамааралтай байдаг. Иймд эдгээр байгууллага уул уурхайн төслүүдэд зориулан олгох бүхий

л санхүүжилтийнхээ урьдчилсан болзол болгож байгаль орчны дээд зэргийн стандарт мөрдөх, хүний эрхийг хүндэтгэх нөхцлийг хангах, түүний нөлөөнд өртөх ард иргэдээс зөвшөөрөл авах, орлогын төлбөрүүдээ ил тод болгохыг шаардах ёстой.

- **Алтны жижиглэн худалдаалагчид ба хэрэглэгчдээс тавих шаардлага.** Жил бүрийн олборлож буй алтны ихээхэн хэсгийг үнэт эдлэлийн салбар авч ашигладаг. Жижиглэн худалдаалагчид болон хэрэглэгчдийн хувьд, компаниуд тухайн улсын ард иргэд, ажилчдын эрхийг хүндэтгэж, байгаль орчинд учруулах хор хохирлыг доод зэрэгт хүргэн, улмаар өөрсдийн олборлож зах зээлд нийлүүлж байгаа алтаа “Алтан дүрэм”-д нийцүүлж ажиллахыг уул уурхайн компаниудиаас шаардах замаар өөрчлөлт гаргах үйлсэд тусалж чадна.

Бүлэг 1

Алт дэлхий дахины бараа болох нь

Дэлхий нийтийн эдийн засгийн систем, бидний өдөр тутмын амьдралд алт нэгэн гол үүрэг гүйцэтгэдэг. Алт олон зууны турш эд баялаг, эрх мэдэл, хайр сэтгэлийн бэлэг тэмдэг болж ирсэн билээ.

2004 оны сүүлч гэхэд газар дээр олборлон гаргасан алт 153,000 тонн байлаа¹. Үүний талаас жаахан илүү хувийг хөгжиж байгаа болон хөгжилтэй орнуудын хэрэглэгчид үнэт эдлэлийн хэлбэрээр ашиглаж байдаг. Алтан эдлэлийн хамгийн хүчирхэг зах зээлийг Энэтхэг, АНУ, Хятад улсууд төлөөлдөг.

Дэлхийн алтнаас 17,700 тонн орчим нь үнэт эдлэлээс өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглагджээ. Энэ хэрэглээний хамгийн чухал нэг салбар бол электроникийн салбар бөгөөд алтыг компьютер, автомашин, гар утасны цахилгаан хэлхээнд зориулсан холбогч утас, ялтсууд хийхэд ашигладаг байна. Өндөр хөгжилтэй орнуудад нилээд их хэмжээний алтыг (2004 онд 64.2 тонн) шүдний эмнэлэгт ашигладаг². Тэр ч байтугай 24 каратын хальсан алтыг зарим нэг тансаг хоол хүнс, гоо сайхны бүтээгдэхүүнд хэрэглэдэг байна.

Төв банкуудын алтны нөөц гэх мэт албан ёсны нөөц сангууд ба хувийн хөрөнгө оруулалтын хэмжээ нийлээд 2004 онд 53,200 тонн орчим алт байв. Энэ нь дэлхий дээрх нийт алтны гуравны нэг орчим хувь юм³. Хөрөнгө оруулалтын байгууллагууд, ялангуяа эрсдлээс хамгаалах сангууд Нью Йорк, Торонто, Лондоны бараа, түүхий үдийн биржээр дамжуулан нилээд хэмжээний хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хариуцан явуулдаг. Бараа, түүхий эдэд оруулах

хөрөнгө оруулалт нилэнхүйдээ өссөний үр дүнд сүүлийн таван жилд алтны үнэ тогтмол өсч байна. Газрын тосны хомсдол, улс төрийн тогтворгүй байдал зэрэг сэтгэл түгшээсэн асуудлуудаас үүдэн алтанд оруулах хөрөнгө оруулалт ч нэмэгджээ. 2006 оны 2 дугаар сарын 2-нд алтны үнэ сүүлийн 25 жилд байгаагүй өндөр үнэ буюу 575.35 ам.долларт хүрсэн бол, 4 дүгээр сарын 19-нд 626.75 ам.доллар болж өссөн байна⁴.

Харин дэлхийн хэмжээгээр 48,000 тонн орчим алтны нөөц олборлогдоогүй, хөрсөн дор оршиж байна гэсэн тооцоо гарчээ⁵.


Алт олборлолт ба хөгжиж буй ертөнц

Дэлхийн алтны нөөцөд хөгжиж буй орнуудын алт олборлолтын эзлэх хувь өссөөр байна.

Алтны хамгийн том хоёр ил уурхай хоёулаа хөгжиж буй ертөнцөд байгаа нь Баруун Папуагийн Грасберг, Перугийн Янакочагийн уурхай хоёр юм. Энэ нь, “том дөрөв”-ийн (Өмнөд Африк, АНУ, Австрали, Канад улсууд) үйлдвэрлэсэн алтыг дэлхийн бусад хэсгийн алттай харьцуулсан хувь урт хугацаанд буурах хандлагатай байгаагийн нэг жишээ юм. Нэг талаас энэ байдал нь орд газруудыг ашиглаж дууссантай холбоотой төдийгүй нөгөө талаас зарим аж үйлдвэржсэн орнуудад байгаль орчны шаардлагыг хангаж ажиллахад илүү хэцүү, хөдөлмөрийн зардал илүү өндөр байдагтай холбоотой⁶. Одоо дэлхийн алтны үйлдвэрлэлийн 70 гаруй хувийг хөгжиж буй орнуудад явуулж байна⁷.

Филиппин, Перу гэх мэт зарим нэг хөгжиж байгаа оронд нилээд тооны хүмүүс өөрсөддөө зориулж алт олборлож байна. 2002 оны байдлаар дэлхийн алтны үйлдвэрлэлийн 20 орчим хувийг гар аргын болон бага хэмжээний алт олборлолт эзэлж байгаа тооцоо гарчээ⁸. Алт бол өндөр үнэ цэнэтэй, маш бага боловсруулалт шаарддаг учраас ялангуяа энэ төрлийн бага хэмжээний уурхайн үйл ажиллагаанд сайн тохирдог байна.

2004 оны дэлхийн тэргүүлэх алт үйлдвэрлэгч орнууд



Дэлхийд эзлэх байр	Алтны үйлдвэрлэл, тонноор	Дэлхийд эзлэх байр	Алтны үйлдвэрлэл, тонноор
1. Өмнөд Африкийн БНУ	343	11. Гана	58
2. Америкийн Нэгдсэн Улс	262	12. Танзани	48
3. Австрали	258	13. Бразил	42
4. Хятад	217	14. Мали	39
5. Оросын Холбооны Улс	182	15. Чили	39
6. Перу	173	16. Филиппин	29
7. Канад	129	17. Аргентин	28
8. Индонези	114	18. Зимбабве	24
9. Узбекистан	84	19. Мексик	24
10. Папуа Шинэ Гвиней	75	20. Колумб	24

Хувийн хэвшлийн үүрэг

Албан ёсны алт олборлолтын үйл ажиллагаанд голдуу АНУ, Канад, Өмнөд Африк, Австрали, Их Британиас гаралтай үндэстэн дамнасан компаниуд ноёрхдог бөгөөд тэд өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулах чадавхитай байдаг. Мөн бусад салбарын нэг адил энэ салбарын компаниудын нэгдэх дүр зураг сүүлийн арав гаруй жилийн турш ажиглагдаж байна. 2004 оны байдлаар алтны олборлолтоор тэргүүлэгч таван компаний үйлдвэрлэл нийт үйлдвэрлэлийн 32 хувийг эзэлж байв. Дэлхийн хэмжээний томоохон үйлдвэрлэгчдээс гадна хязгаарлагдмал тооны уурхайтай хэд хэдэн дунд хэмжээний компаниуд байдаг нь голдуу тодорхой нэг газар зүйн бүсэд төвлөрсөн байдаг.

2004 оны тэргүүлэх 10 алт үйлдвэрлэгч компани

		Үйлдвэрлэлийн гарц, тонноор
1. Ньюмонт	АНУ	211.8
2. АнглоГолд Ашанти	Өмнөд Африк	188.2
3. Баррик	Канад	154.2
4. Гоулд Фийлдс Лимитед	Өмнөд Африк	128.5
5. Плэсер Доум	Канад	113.6
6. Хармони	Өмнөд Африк	101.5
7. Навой Металс энд Майнинг	Узбекистан	58.3
8. Сиа Де Минас Бюенавентура	Перу	51.3
9. Кинросс	Канад	49.5
10. Рио Тинто	Их Британи	48.3

Эх сурвалж: *GFMS Алтны судалгаа 2005, хуудас 37*

Асар олон тооны алт олборлогч “багачууд” судалгаа шинжилгээний шатанд идэвхтэй ажиллаж байна. Арай жижиг эдгээр компани өндөр эрсдэл хүлээх, тухайлбал улс төрийн байдал тогтворгүй газар ажиллах, алтны нөөц олж тогтоох эрсдлийг хүлээх зэрэг зовлонтой тулгарах нь олонтаа. Тэд дараа нь эрх авсан гэрээт талбайгаа жинхэнэ олборлолт явуулах уул уурхайн томоохон компаниудад зарах явдал байнга тохиолддог.

Алт олборлолтын үйл ажиллагааны санхүүжилт

Томоохон хэмжээний алт олборлолтын үйл ажиллагаатай холбоотой зардал ба эрсдэл нь компаниудад багагүй хэмжээний гадаад санхүүжилт, даатгал шаардлагатай байдаг гэсэн үг. Үүнийг улсын ба хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагуудын аль аль нь хангаж ирсэн уламжлалтай. Тэдний дэмжлэггүйгээр том хэмжээний олборлолтын үйл ажиллагаа хол явахгүй юм. Энэ нь, дэлхий дахинд буй алтны уурхайн төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэхэд нөлөөлөх тухайд багагүй хөшүүргийг зээлдүүлэгчдэд олгодог.

Экспортын зээл олгогч газрууд

Ийм газрууд нь хилийн чанадад үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулж чадсан дотоодын компаниуддаа санхүүгийн дэмжлэг үзүүлдэг засгийн газрын агентлагууд юм. Эдгээр агентлаг нь баталгаа гаргаж өгөх, даатгалаар хангах замаар компаниудыг экспортлосон бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг авч чадахгүй байх эрсдлээс хамгаалж өгдөг. Тэдний хувьд татвар төлөгчдийн мөнгийг хувийн хэвшлийнхнийг дэмжихэд зарцуулж байгаа бодит байдлыг нь эс тооцвол, хийж буй олон зүйл гүйлгээнийх нь талаар мэдээлэл олж авахад хэцүү байдаг. Экспортын зээл олгогч газрууд нь уул уурхайн салбарт арилжааны банкууд болон олон талт байгууллагууд хоёрын олгодог зээлийн нийлбэр дүнгээс ч ихийг зээлдүүлдэг учраас энэ салбарт чухал оролцогч байдаг⁹. Тэд мөн улс төрийн эрсдлийн даатгалын нэг амин чухал эх үүсвэр байдаг. Энэ нь, хөгжиж буй ертөнц дэх улс төрийн тогтворгүй байдал, гэрээ цуцлагдах айдас зэргээс болж өндөр эрсдэлтэйд тооцогддог төслүүдийг аль нэг зээл олгогч газар хариуцан даатгаж байна гэсэн үг.

Олон улсын санхүүгийн корпорацн (ОУСК)

Үндэстэн дамнасан уул уурхайн компаниудаар дамжуулан гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн үндэсний хуулиудаа либеральчилахыг Дэлхийн Банк хөхиүлэн дэмждэг. Дэлхийн Банкны Групп дотроо уул уурхайн салбарыг дэмжих чиглэлд ОУСК чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. ОУСК 1993-2001 оны хооронд 681 сая ам. долларын хэмжээтэй 33 уул уурхайн төслийг санхүүжүүлсэн байна. Энэ нь дээрх төслүүдийн нийт зардлын дөнгөж 18 орчим хувийг эзэлж байсан хэдий ч ОУСК-аас үзүүлсэн дэмжлэг санхүүгийн бусад эх үүсвэрийг татан оруулахад шийдвэрлэх үүрэгтэй байдаг¹⁰. Саяхан ОУСК-аас Гватемал дахь Марлиний алтны уурхайд дэмжлэг үзүүлсэн байна. Мөн Дэлхийн Банкны Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны газраас Баруун Папуагийн Грасберг, Перугийн Янакоча, Киргизстаны Кумтор, Папуа Шинэ Гвиней улсын Лихир зэрэг уурхайн алт олборлолтын төслүүдэд улс төрийн эрсдлийн даатгал олгож байна¹¹.

Саяхан ОУСК санхүүжилт олгох шалгуур тогтоодог хамгаалалтын бодлогодоо үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Тус корпорацийн шинээр авч хэрэглэсэн гүйцэтгэлийн стандартуудад, ялангуяа уул уурхайн төслүүдэд ихээхэн хамааралтай олон нийттэй зөвлөлдөх ба нүүлгэн шилжүүлсэн ард иргэдэд газар олгох асуудалтай холбоотой стандартуудад ухралт гарсан байна¹² гэж зарим бүлэглэл санаа зовж байна. Нэн ялангуяа, ОУСК-ийн нийгмийн ба байгаль орчны стандартуудыг хувийн банкны салбар ба экспортын зээл олгогч газрууд суурь жишиг болгон ашиглаж ирсэн учраас бүр ч санаа зовоож байна.

Хувийн хөрөнгө оруулагчид

Томоохон уул уурхайн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх чадвартай банкуудын тоо буурч байгаа нь тэд уул уурхайн салбарт олон нийтэд түгээмэл болсон элдэв хүндрэлтэй асуудалтай нэр холбогдохоос санаа зовсонтой (нэр хүндийн эрсдэл) болон сүүлийн үед санхүүгийн ашиг орлого нь буурч байгаатай холбоотой¹³. Харин сүүлийн гурван жилд алтны үнэ ихээхэн өссөн нь энэ байдлыг өөрчилж болох юм.

Алт олборлолтын хэд хэдэн шинэ залуу компани хайгуулын ажлын хөрөнгө хуримтлуулах үүднээс Лондоны Хөрөнгийн Бирж (ЛХБ)-ийн Альтернатив хөрөнгө оруулалтын зах зээл (АХОЗЗ)-ийг ашигласаар байна. АХОЗЗ нь жижиг компаниудад зохицуулалтын шаардлага багатай зах зээлд нэвтрэх боломж олгосноороо тэдний хувьд харьцангуй хялбар байдлаар хөрөнгө санхүү бүрдүүлэх нэг арга болдог. Энэ аргыг хэрэглэдэг газрын тос, байгалийн хий, уул уурхайн 200 гаруй компани байгаа нь уг салбарыг АХОЗЗ-ийн хамгийн чухал боловч ороо бусгаа салбарын нэг болгож байна. Хайгуулын үйл ажиллагааны эрсдэлтэй холбоотойгоор, хөрөнгө оруулагчид хангалттай мэдээлэл авч байгаа эсэх талаар 2005 оноос санаа тавьж эхэлсэн. 2006 оны 3 дугаар сард ЛХБ-ээс газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбараас АХОЗЗ-д хамрагдах хүсэлтэй компаниудад тусгайлан зориулсан тайлагналын нэмэлт заавруудыг гаргасан байна.

Бүлэг 2

Их Британи дахь алт

Их Британи улс дэлхийн алтны зах зээлд чухал үүрэг гүйцэтгэдэг. Лондон хот бол Мелбурн, Торонто хотуудын нэг адил алтны уурхайд зориулж хөрөнгө мөнгө бүрдүүлэх томоохон төвийн нэг юм. Уул уурхайн хамгийн том компаниудын хоёр нь болох Рио Тинто, Англо Американ Групп гэсэн хоёр компани Их Британид төвтэй байдаг. Санхүүгийн төвөөс гадна Лондоны алтны зах зээлийн эх нутаг болохын хувьд Их Британи улс экспорт, импортын өндөр түвшин бүхий их хэмжээний гулдмай тээвэрлэлтийн дайран өнгөрөх цэг болдог. Жишээлбэл, 2003 онд Их Британи улс 1402 тонн боловсруулаагүй алт импортлосон бөгөөд түүний ихэнх нь банк хоорондын гүйлгээнд ашигладаг цэвэршүүлсэн алтан гулдмай байлаа¹⁴. Их Британид гулдмайн экспортоор тэргүүлдэг орнууд бол АНУ, Канад хоёр юм.

Алтны үйлдвэрлэл


Европын ихэнх орны адил Их Британи улс дэлхийн бусад өнцөг булангаас олборлосон алтнаас ихээхэн хамааралтай байдаг. Дээр үед Уэлст алтны уурхай ажилладаг, Шотланд, Девонд гол мөрний сав газраас алт угаадаг байв. 1860-1909 оны хооронд 3.5 тонн алт үйлдвэрлэж байсан байна¹⁵. Одоо Кэмбриан Гоулфийлдс ЛТД хэмээх жижигхэн компани Хойд Уэлсийн Долгелау Гоулбелтэд хайгуулын лиценз эзэмшсэн хэвээр байгаа бөгөөд хуримын бөгжний зориулалтаар маш бага хэмжээний алт үйлдвэрлэдэг байна.

Тансаг гудамж зээл дэх алт

Их Британид алтан эдлэл ихээхэн түгээмэл хэвээр байна. Алтан эдлэлийн борлуулалт 2002 онд оргил цэгтээ хүрснээс хойш унаж, цагаан алтыг сонирхох

явдал нэмэгдэж байгаа боловч алтны зах зээл хүчтэй хэвээр байна. 2003 онд Их Британид 2 тэрбум фунт стерлингийг алтан эдлэлд зарцуулсан тооцоо гарчээ¹⁶. 2005 онд бараг 19.5 сая ширхэг алтан эдлэл борлогдсон нь нийт өндөр сорьцтой үнэт эдлэлийн 68 хувийг эзэлж байна¹⁷. Энэ нь нийт хүн амын бараг гуравны нэг хувь нь жилд нэг ширхэг алтан эдлэл худалдан авч байна гэсэн үг бөгөөд энд ээмэг мэтийн 1 граммаас бага жинтэй, өндөр сорьцтой бус алтан эдлэлийг оруулаагүй болно. Их Британий үнэт эдлэлийн жижиглэн худалдааны зах дээрх бүтээгдэхүүний дийлэнх хувь нь 9 каратын алтан эдлэлүүд байна.

2001 онд Их Британид борлогдсон алтан эдлэлийн төрөл



* энгэрийн зүү, хавчаар, ханцуйны чагтан товч, зангианы хавчаар, биеийн зүүлт гэх мэт

Эх сурвалж: *Минтелийн үнэт металл эдлэлийн газар, Зах зээлийн тагнуул, 2004, х. 22*

Зах зээлийн судалгаагаар хэрэглэгчдийн зан төлөвт өөрчлөлт гарч байгааг тогтоосон бөгөөд эмэгтэйчүүд өөртөө болон бэлэг дурсгалын зориулалтаар үнэт эдлэл худалдан авах нь нэмэгдэж, эрэгтэйчүүд үнэт эдлэл хэрэглэх нь ихэссэн байна. Өөр нэг чиг хандлага бол хэрэглэгчид илүү үнэтэй эд зүйл худалдан авдаг болсон байна. Минтелийн урьдчилсан таамаглалаар 2007 он гэхэд Их Британи дахь үнэт металл эдлэлийн зах зээлийн үнийн дүнгээр 2.96 тэрбум фунт стерлинг болох ажээ¹⁸.

Үнэт эдлэлийн үйлдвэрлэл

Их Британид борлуулсан алтан эдлэлийн талаас илүү хувь нь гадаадад үйлдвэрлэгдсэн байна. Саяхан хүртэл Итали улс үнэт эдлэлийн импортын (хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн) томоохон эх сурвалж байсан бол одоо Хятад, Тайланд, Энэтхэг улсууд тэргүүлэх болжээ. Бага сорьцтой алтан эдлэлүүдийг гадаадад үйлдвэрлэж импортлох явдал улам бүр нэмэгдэж байна.

Их Британи дахь үнэт эдлэл үйлдвэрлэгчид нь Сигнет, Аргос гэх мэт жижиглэнгийн худалдаачдад бараагаа борлуулдаг G&A компаниас эхлээд жижиг

бие даасан загвар зохион бүтээгчид, уран дархчуул хүртэл маш олон янз байдаг¹⁹. Сүүлийн үед Их Британид өндөр чанартай, гар хийцийн алтан эдлэл өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Их Британи дахь алтны жижиглэнгийн худалдаачид

Үнэт эдлэл жижиглэн худалдаалах салбар маш олон хэсэгт хуваагдах бөгөөд түүний дотор дээд зиндааныханд зориулсан бие даасан үнэт эдлэлийн газар, бүс нутгийн болон үндэсний хэмжээний сүлжээнүүд, катологи бүхий үзүүлэнгийн танхимууд, хямдралт үйлчилгээний дэлгүүрүүд гэх мэт төрлүүд бий. Борлуулалтын ганц цэгтэй жижиг, бие даасан үнэт эдлэлийн газрууд ч олон бий. Мөн хэрэглэгчид их дэлгүүрийн үнэт эдлэлийн тасгаас гадна интернэт, гэрээр үйлчилдэг телевизийн сувгуудаар дамжуулан алтан эдлэл худалдаж авч болно. Зах зээлд эзлэх хувь болон дэлгүүрийн тооны хувьд хамгийн том компани бол Сигнет групп юм. Сигнет бол АНУ, Их Британид борлуулалтын цэгтэй дэлхийн хамгийн том үнэт эдлэлийн жижиглэн худалдааны компани билээ. 2005 онд тус групп Их Британид 598 борлуулалтын цэгтэй байсны дотор Эйч Самуэл ба Эрнест Жонесийн сүлжээ дэлгүүрүүд орж байна²⁰.

Хэрэглэгчдийн алтны талаарх итгэл

Их Британи дахь үнэт эдлэлтэй холбоотой ёс зүйн асуудлууд Ангол, Либер, Сиерра Леоне зэрэг газрын зөрчилтэй очир алмааз руу төвлөрөх хандлагатай байна. Глобал Витнесс, Амнести Интернэшнл гэх мэт төрийн бус байгууллагуудаас олны анхаарал татсан кампанит ажлууд явуулж, жижиглэнгийн худалдаачдаас алмаазан эдлэл худалдан авахдаа зөрчилдөөнгүй газраас гаралтай эсэхийг асууж байхыг хэрэглэгчдэд уриалж байна²¹.

Алтны нийгмийн болон байгаль орчны үнэ өртгийг хэрэглэгчид сайн мэдэхгүй байна. Үүний нэг шалтгаан бол уурхайгаас эхлээд цэвэршүүлэлт, хагас боловсруулалт, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатуудыг дамжин дэлгүүрүүдэд очдог алтны нийлүүлэлтийн сүлжээний гинжин холбоо хэрэглэгчид төдийгүй жижиглэнгийн худалдаачдад хүртэл тун ойлгомжгүй байх нь элбэг байдагтай холбоотой.

Их Британий Олон Улсын Хөгжлийн Газраас хэсэгчлэн санхүүжүүлж, 2003 онд нийтлэсэн нэгэн судалгаагаар үнэт эдлэлийн салбар дахь ёс зүй, нийгэм, байгаль орчны холбогдолтой гол гол асуудлыг судалж тогтоосон нь тус салбарын холбогдох талуудад эдгээр асуудлыг хөндөн шийдвэрлэхэд туслах зорилготой байлаа²². Санхүүжилт дутагдсанаас болж энэхүү судалгаанаас дэвшүүлсэн саналууд цааш хэрэгжээгүй боловч үнэт эдлэлийн зарим нэг жижиг бизнес эрхлэгчид үнэт металлыг ёс суртахууны хувьд цэвэр эх сурвалжаас хангадаг схем бий болгохыг оролдож байна.

“Нэг үнэт эдлэлийн жинхэнэ үнэ цэнэ, гоо үзэмжийг нь уурхайчдаас эхлээд хэрэглэгчид хүртэлх нийлүүлэлтийн сүлжээнд бүхэлд нь үзүүлж буй үр нөлөөгөөр тодорхойлох ёстой... олборлолтын үед ямар ч гоо үзэмж байхгүй байж болно.”

Грег Валерио, Кред Жүвелри компанийг үүсгэн байгуулагч

Жишээ судлал: нэгэн жижиг бизнес алтны шударга худалдаанд чиглэсэн алхам хийж байна

Нуруугаа бөгийтөл ажилласныхаа үр өгөөжийг өчүүхэн хүртдэг гар аргаар алт олборлогчдын нөхцөл байдлыг сайжруулах зорилготой Кред Жүвелри компанийг Грег Валерио үүсгэн байгуулсан байна.

Кред компани Колумбийн Корпорацион Оро Верде (Ногоон алт корпораци) компаниас алт худалдан авдаг. Оро Верде нь дотоодын төрийн бус байгууллагууд болон бага хэмжээний уурхайчдын нөхөрлөлүүдээс бүрддэг. Тус корпораци алтаа Номхон далайн бүс нутгийн байгаль орчны судалгааны хүрээлэнгээс нийгмийн ба байгаль орчны бодлогод нийцүүлэн олборлосон тухай гэрчилгээг бие даан авсан байна. Үүнд олборлолтын явцад мөнгөн ус, хүхрийн хүчил, цианид ашиглахгүй байх, мөн олборлолтын үйл ажиллагаа явуулж болно гэсэн зөвшөөрлийг нутгийн уугуул хүмүүс, ард иргэдийн зөвлөлөөс авсан байх шаардлагатай байдаг. Мөн алтны уурхайн компани нөөц ашигласны төлбөрөө тодорхой нэг орон нутгийн захиргаанд төлсөн тухайгаа зарлаж, бүртгүүлдэг байна.

Грегийн эцсийн зорилго бол алт, цагаан алт, мөнгө, алмаазан бүтээгдэхүүнд олон улсын Шударга худалдааны тэмдэг зүүлгэдэг болгох явдал юм. Үүний тулд тэрээр Шударга худалдааны сан, Хариуцлагатай уул уурхайн холбоо (www.communitymining.org) зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна. Дээрх байгууллагууд нь Оро Вердегийн туршлагаас санаа авч, гар аргаар болон бага хэмжээгээр олборлогчдод зориулсан хариуцлагатай стандарт, шалгуурууд бий болгохыг хөхиүлэн дэмжих зорилгоор 2004 онд байгуулагдсан бие даасан байгууллагуудын сүлжээ юм²³.

“Цэвэр” алтны төлөөх өсөн нэмэгдэж буй шахалт шаардлага

2002 онд АНУ-д Оксфам Америка болон Еэртуоркс байгууллагууд “Бохир алт хэрэггүй” хэмээх кампанит ажил эхлүүлсэн нь хэрэглэгчдийн үйлдлийн шууд нөлөөнд илүүтэй өртдөг уул уурхайн компаниуд ба жижиглэнгийн худалдаачдын хооронд хариуцлага хувааж үүрэх асуудлыг тодотгож өгснөөрөө амжилт олоод байна.

Уг кампанит ажлаар алтыг байгаль орчин, нутгийн ард иргэд болон ажилчдад хамгийн бага хор хохиролтойгоор олборлоход чиглэсэн багц “Алтан дүрэм”-д гарын үсэг зурж нэгдэн орохыг алтны жижиглэнгийн худалдаачид, уул уурхайн компаниуд ба хувь хүмүүст уриалсан юм.

Алтан дүрэм

Алтан дүрэм нь дараахь үндсэн стандартыг үйл ажиллагаандаа баримталж ажиллахыг уул уурхайн компаниудад уриалдаг:

- Олон улсын конвенци, хуулиудад заасан хүний үндсэн эрхүүдийг хүндэтгэж байх.
- Холбогдох нутгийн ард иргэдээс мэдэж гаргасан, үнэ төлбөргүй зөвшөөрлийг урьдчилан авах.
- Аюулгүй ажиллах нөхцлөөр хангах.
- Ажилчдын эрх, хөдөлмөрийн стандартууд (түүний дотор ОУХБ-ын 8 гол конвенци)-ыг хүндэтгэн дагах.
- Зэвсэгт буюу цэргийн мөргөлдөөнгүй газарт үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангах.
- Төслүүд нь ард иргэдийг газар нутгаас нь албадан хөөхгүй байх.
- Уул уурхайн хог хаягдлыг далай тэнгис, гол мөрөн, нуур цөөрөм, булаг шандын усанд хаяхгүй байх.
- Тусгай хамгаалалтад авсан газар нутаг, эмзэг эко систем, эсвэл дархан цаазтай болон экологийн үнэ цэнэ бүхий бусад газарт төслүүд хэрэгжүүлэхгүй байх.
- Төслүүд нь хүхрийн хүчлийн байнгын эх үүсвэр болдоггүй байх.
- Уурхайн үйл ажиллагааг хаах, газар орныг цэвэрлэхтэй холбоотой бүх зардлыг даах.
- Төслүүдийн нийгмийн болон байгаль орчны үр нөлөөний талаарх мэдээллийг бүрэн ил тод болгох.
- Дээрх зүйлсийг сахиж байгаа эсэхийг хараат бусаар шалган тогтоохыг зөвшөөрөх

2005 онд тус салбарынхан энэхүү кампанит ажлын хариу болгож Үнэт Эдлэлийн Хариуцлагатай Үйл ажиллагааны Зөвлөлийг байгуулжээ.

Дараа нь, 2006 оны 2 дугаар сарын 14-нд Тиффанийс, Сигнет групп, Картиер зэрэг хэд хэдэн компани Алтан дүрмийг дэмжихээ олон нийтэд зарласан юм. Энэ нь эдгээр жижиглэнгийн худалдаачдын хувьд алт худалдан авах эх сурвалжаа тодорхойлох талаар нийлүүлэгчидтэйгээ хамтран ажиллана, эх сурвалжууд тодорхой болсны дараа Алтан дүрмийг хүндэтгэн дагадаг уурхайнуудаас бараагаа татна, эдгээр стандартыг хангасан эсэхийг хараат бус гуравдагч этгээдээр шалгуулахыг дэмжинэ гэсэн үг. Эдгээр үйл явдал Их Британид дам нөлөө үзүүлснээр хэрэглэгчдийн итгэлийг хүлээхэд чиглэсэн арга хэмжээ авах хэрэгтэй гэсэн ойлголт батжиж байна²⁴.

Одоо Алтан дүрмийг мөрдөх тухай үүрэг амлалтуудыг алт олборлолтын стандартыг сайжруулахад чиглэсэн тодорхой үйл ажиллагаа болгон хувиргах асуудал чухал болоод байна.

Үнэт Эдлэлийн Хариуцлагатай Үйл ажиллагааны Зөвлөл

Одоо энэ салбарынханы хувьд хамтарсан арга хэмжээ авахад тохиромжтой цаг болоод байна. Үнэт эдлэлийн хариуцлагатай үйл ажиллагааны зөвлөл нь хөгжиж байгаа орнуудад уул уурхайгаас үзүүлэх уршгийн асуудлыг авч үздэг нэг чухал байгууллага болох боломжтой юм. Тус байгууллага нь “очир алмааз ба алт нийлүүлэх сүлжээнд итгэх итгэлийг бэхжүүлэх” зорилготойгоор “уурхайгаас жижиглэнгийн худалдаа хүртэл” хүрч ажиллахыг зорьж байна. Бусад салбарын туршлагаас үзэхэд, салбарын хэмжээний арга хэмжээ авснаар нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудлуудтай тэмцэхэд тусалж болох боловч хөшүүн хойрго компаниудаас болж салбарын ямар ч стандартыг сулруулах аюултай байдаг. Харин алтны уурхайн шууд нөлөөнд өртөж буй ард иргэдийн төлөөллийг уг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулаагүй байна.

Үнэт эдлэлийн хариуцлагатай үйл ажиллагааны зөвлөлд дараахь гишүүд ордог:

- АнглоГоулд Ашанти
- БиЭйчПи Биллитон
- Британий Үнэт Эдлэлийн Худалдаачдын Холбоо
- Картиер
- Ньюмонт
- Пиагет
- Пласер Доум
- Рио Тинто
- Сигнет
- Тиффани & Ко
- Дэлхийн алтны зөвлөл

Шударга ёс тогтооцгооё

Хэрэв энэхүү салбарын сайн дурын санаачилга өөрчлөлт гаргах, итгэл хүлээх чадвартай больё гэвэл гишүүддээ зориулсан хатуу чанд стандартууд тогтоох шаардлагатай. ҮЭХҮАЗ-ийн ажлын дүрмийн төслийг боловсруулах үед нээлттэй зөвлөлдөөн явуулж байсан. Энд хэд хэдэн сул тал байгаа юм:

- Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд шууд өртөж буй ард иргэдээс зөвшөөрөл авахыг компаниудаас шаардахын оронд "зохистой үед" зөвлөлдөх тухай заасан.
- Уурхайн нөөц шавхагдсаны дараа хүчлийг хатаах буюу талбайг цэвэрлэхтэй холбоотой тодорхой арга хэмжээ авах ёстой байтал (хэдийгээр тус Зөвлөлөөс уул уурхайн салбарт зориулсан нэмэлт шаардлагуудыг хожим боловсруулна гэсэн боловч) байгаль орчны стандартуудыг бүдэг бадаг оруулсан.
- Уул уурхайн компаниуд үндэсний болон орон нутгийн засгийн газарт төлж буй төлбөрөө нийтлэх, уурхайгаас хэр их орлого олж байгааг олон нийтэд мэдэгдэх талаар огт дурдаагүй. Газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас төлж буй орлогын төлбөрүүдийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авилгыг бууруулах зорилготой Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад энэ зөвлөлийн гишүүн хэд хэдэн уул уурхайн компани хэдийнээ нэгдэн ороод байгаа боловч ийнхүү орхигдуулсан нь гайхал төрүүлж байна.

Хэрэв уг Зөвлөл уул уурхайн үйл ажиллагааны хамгийн хор хохиролтой зарим чиглэлээс барьж авъя гэж байгаа бол эдгээр асуудлыг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай болно.

Алт олборлолтын арга замыг өөрчлөхөд чиглэсэн дарамт шахалтыг тогтоон барихад үнэт эдлэлийн жижиглэнгийн худалдаачид чухал үүрэгтэй. Магадгүй худалдааны холбоод, жижиглэн худалдааны томоохон сүлжээнүүд алт үйлдвэрлэгчдэд нөлөөлөх магадлал илүү их байж болох юм. Цөөн тооны жижиглэнгийн худалдаачид, тухайлбал Тиффаний & Ко, Картиер, Сигнет Групп зэрэг компани Алтан дүрэм, ҮЭХҮАЗ хоёрыг хоёуланг нь дэмжихээ амлаад байна. Одоо эдгээр компани илүү хатуу чанд Алтан дүрмийг ҮЭХҮАЗ-өөс гаргах салбарын шинэ дүрмийн үндэс суурь болгох талаар ажиллаж болно. Түүнчлэн үнэт эдлэлийн жижиглэнгийн худалдаачид өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээнд аудит хийж, одоо байгаа нийлүүлэгчдээсээ алтаа хаанаас авч байгааг лавлаж эхлэх замаар хамгаалалтын сүлжээ бий болгох алхамууд хийж болно.

Бүлэг 3

Хөгжиж байгаа орнуудын алтны үнэ өртгийг дэнслэх нь

Дэлхийн алтны үйлдвэрлэлд хөгжиж байгаа орнуудын үйлдвэрлэлийн эзлэх хувь өссөөр байна. Олон алтны уурхай арваас хорин жилийн буюу нилээд хязгаарлагдмал настай байх бөгөөд алт бол сэргээгдэхгүй нөөц учраас түүний нөөцийг ухаалгаар ашиглах нь онцгой чухал. Энэхүү эрдэс баялгийг ядуурлыг бууруулахад ашиглах боломжтой, гэхдээ уул уурхай үнэхээр ядууст ашиг тусаа өгдөг гэж үү? Алт олборлолтыг ядуурлыг бууруулалт, тогтвортой өсөлтөд хувь нэмэр оруулах байдлаар явуулах боломжтой юу?

Тогтвортой хөгжил гэдэг бол “ирээдүй хойч үеийнхэнийхээ эрэлт хэрэгцээг хангах чадварыг алдагдуулахгүйгээр өнөөгийн хэрэгцээгээ хангах хөгжил” мөн.

Байгаль орчин, хөгжлийн дэлхийн комисс

Ард иргэдийн бүлгүүд, олон улсын ТББ-уудын эсэргүүцэл, кампанит ажлуудтай тулгарсан зарим томоохон уул уурхайн компаниуд үйл ажиллагааныхаа нийгэм, байгаль орчин, эдийн засгийн үр нөлөөг эргэж харахад хүрээд байна. 1998 онд уул уурхайн есөн компани хамтран Дэлхий дахины уул уурхайн санаачилга хэмээх байгууллага байгуулж, Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжлийн судалгаа явуулж эхэлсэн юм. Үүний нэг адилаар газрын тос, байгалийн хий, уул уурхайн төслүүдэд оролцох нь ядуурлыг бууруулах, тогтвортой байдлыг хөхиүлэн дэмжих зорилтуудад нийцдэг гэсэн төсөөллийг шалгаж үзэх үүднээс Дэлхийн Банкны

Групп Олборлох үйлдвэрлэлийн үнэлэлт дүгнэлт хэмээх бие даасан үнэлгээг 2001 оны 7 дугаар сараас 2003 оны хооронд явуулсан байна. Үүний үр дүнд, алт олборлолтын хөгжиж буй ертөнцөд үзүүлэх сөрөг нөлөөг илүү өргөн хүрээтэй ойлгодог болоод байгаа боловч эдгээр нөлөөг авч үзэж шийдвэрлэх хамгийн сайн арга замын тухай мэтгэлцээн ихээхэн маргаантай хэвээр байна.

Нөөцийн хяслан буюу байгалийн баялаг ихтэй хөгжиж байгаа орнууд дэлхийн хамгийн ядуу буурай орнуудын тоонд орсоор байгаа гаж үзэгдлийг уул уурхай олон талаар илтгэн харуулдаг. Аливаа улс эрдэс баялгийн экспортоос хэдийчинээ их хамааралтай байна, нялхсын эндэгдэл, дундаж наслалт, хүүхдийн боловсрол гэх мэт хүний хөгжлийн үзүүлэлтээр төдийчинээ тааруу амжилт үзүүлдгийг нэгэн шинжилгээгээр тогтоосон байдаг²⁵.

Эрдэс баялгаас хамааралтай орнууд ижил түвшний орлоготой бусад орныг бодвол тэгш бус байдлын өндөр түвшинтэй байх хандлагатай байдаг. Энэ нь, аливаа улс эрдэс баялгийн экспортоос хэдийчинээ их хамааралтай байх тусам хүн амынх нь хамгийн ядуу 20 хувьд төдийчинээ бага орлого хуваарилагдана гэсэн үг²⁶. Уул уурхайн бүс нутагт амьдардаг нутгийн ард иргэдэд олборлолтын үйл ажиллагаа хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай атал тэд үр шимээс нь маш өчүүхэн хүртэж магадгүй байдаг.

Яагаад алт ихтэй зарим орон энэ давуу талаа хөгжлийн үр шим болгож чадахгүй байгааг тайлбарлахад туслах үүднээс энэ бүлэгт алт олборлолттой холбоотой зарим хүндрэлтэй асуудлыг товч онцлон авч үзэх болно.

1. Алт олборлолтын эдийн засгийн үр нөлөө

Дэлхийн алтны зөвлөлөөс хөгжиж байгаа орнууд дахь алт олборлолтын ач холбогдлыг чухалчлахдаа экспортын орлого, нөөц ашигласны төлбөр ба татварын орлого, технологийн шилжүүлэлт гэх мэт ашиг тусыг жагсаан харуулдаг²⁷. Эдийн засгийн хөгжлийг болон ядуурлын бууралтыг хөхиүлэн дэмждэг гэдэг үүднээс Дэлхийн Банкны Групп сүүлийн 20 жилийн турш хөгжиж байгаа ертөнц дэх газрын тос, байгалийн хий, уул уурхайн төслүүдийг идэвхтэй дэмжиж ирсэн. Үнэн хэрэгтээ өөрсдийнх нь хийсэн Олборлох үйлдвэрлэлийн үнэлэлт дүгнэлтэд, хэрэв зүй зохистой нөхцөл байдал бүрэлдсэн, тухайлбал “ядуусын төлөө гэсэн төрийн болон бизнесийн засаглалтай, нийгмийн болон байгаль орчны хамаагүй үр нөлөөтэй бодлоготой, хүний эрхийг хүндэлдэг”, тохиолдолд л олборлох үйлдвэрлэл тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж болох юм гэж дүгнэсэн байдаг²⁸. Мөн уг Үнэлэлт дүгнэлтэд эдгээр нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай өөрчлөлтүүдийг тодорхойлж гаргасан боловч тус Банкны Групп эдгээр санал зөвлөмжийн зөвхөн заримыг нь л авч үзэх сонголт хийсэн байна.

Орлогын өсөлт

Дэлхийн хамгийн ядуу буурай олон тооны улсын хувьд орлогын нэг чухал эх үүсвэр нь алтны экспортын орлого байдаг. Түүнчлэн алт олборлолтоос орж буй нөөц ашигласны төлбөр ба татварын орлогууд нь хөгжиж байгаа орнуудыг үндэсний болон орон нутгийн түвшний орлогоор хангаж байдаг. Гэвч гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулах үүднээс татварын түвшинг харьцангуй доогуур түвшинд тогтоосон байх нь олонтаа учраас бүрдүүлэх орлогын хэмжээ хумигддаг.

Уул уурхайгаас олж буй орлогыг хөгжлийг дэмжих чиглэлд зарцуулахгүй байж болно. Тус салбараас санхүүжүүлсэн Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжлийн төсөлд “Ашигт малтмалын баялгийг үр нөлөөтэй удирдах чадвар нь түүнд зориулсан хөрөнгө оруулалтыг татах чадвараасаа хоцорч байна” гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна²⁹.

Алт бол сэргээгдэхгүй нөөц учраас энэ нөхцөл байдал нь онцгой санаа зовоосон асуудал болж байна. Аливаа улс эрдэс баялгийн нөөцөө ухаалгаар ашиглахгүй бол эцэстээ хүн ам нь юу ч үгүй хоцрох юм.

Мөн ганцхан төрлийн бараа бүтээгдэхүүнд хэт их найдах нь асуудал үүсгэж болно. Энэ нь тухайн улс орныг алтны үнэ, валютын ханшны зах зээлийн хэлбэлзэлд илүү эмзэг өртөмтгий болгож байдаг. 2005 оны Алтны судалгаагаар, хэрвээ алтны үнэ 10 ам. доллароор унавал их хэмжээний өртэй орнууд бүхэлдээ 75 сая ам. долларын экспортын орлогоо алдах болно гэж тооцоолсон байна³⁰. Түүнчлэн байгалийн баялгийн экспортын салбар их хэмжээгээр өссөний үр дүнд аж үйлдвэр, хөдөө аж ахуй гэх мэт экспортын бусад салбарт “Голланд өвчин” хэмээх өвчин нүүрэлж, уналтад орж болох юм³¹. Ерөнхийдөө, 1990-ээд оны үед уул уурхайн салбар “зонхилдог” (экспортын 50-иас дээш хувь) орнуудад нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ жил тутамд 2.3 хувиар буурч байв³².

Ажил эрхлэлт

Томоохон хэмжээний алтны уурхайнууд хөдөлмөрийн нягтрал ихтэй салбар байхаа болиод байна. Технологи өөрчлөгдөж, бүтээмж нэмэгдэх нь цөөн тооны ажилчин хэрэгтэй гэсэн үг учраас дэлхийн хэмжээгээр албан ёсны уурхайд ажиллаж буй хүмүүсийн тоо буурч байна. Магадгүй, үүний улмаас үндэстэн дамнасан компаниуд дотоодын хүн амаас аль болох олон хүн авч ажиллуулахыг хичээдэг чиг хандлага бий болж байж мэдэх юм. Ийнхүү ажилтай болж чадсан хүмүүс эдийн засгийн шууд үр шимийг нь хүртэх, улмаар уул уурхайн ажиллагааг дэмжих магадлал ихтэй байж болно. Энэ бүлэгт эмэгтэйчүүд маш цөөнөөр хамрагдах юм. Үнэндээ бол эмэгтэйчүүд ерөнхийдөө уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих магадлал, түүнээс ямар нэг үр шим хүртэх боломж багатай бөгөөд ингэснээрээ эрэгтэйчүүдээс улам их хамааралтай болж болно. Зарим оронд эмэгтэйчүүд уурхайд ажиллахыг огт зөвшөөрдөггүй байна³³.

Нөгөө талаас бага хэмжээний уурхай болон гар аргаар олборлолтод хөдөлмөрийн нягтрал их байдаг. Одооны байдлаар албан ёсны уурхайн ажилчдаас ч олон хүн албан бусаар олборлолт явуулж байна. Дэлхийн хэмжээгээр гар аргаар олборлолтод 13 сая хүн (үүнээс 1 сая нь хүүхдүүд)³⁴ шууд оролцож, энэ нь цаашлаад 80-100 сая хүний амьжиргаанд нөлөөлж байна гэж Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага үзэж байна³⁵.

Гар аргаар олборлох явдал ихэвчлэн зохицуулалтгүй байдаг. Эдгээр уурхайчид хөрөнгө мөнгө дутагдалтай, зах зээлд хүрэх боломж муутай, алслагдмал эсвэл жижиг орд газруудыг ашигладаг бөгөөд нөхөн сэргээлтийн түвшин доогуур байдаг. Уурхайчид өөрсдөө маш бага орлого олох бөгөөд борлуулалтынх нь дийлэнх ашгийг наймаачид, дамжуулан зуучлагчид хүртдэг байна. Хамгийн гол нь гар аргын олборлолт нь олон хүмүүсийн амь зуух хэрэгсэл болдог. Ашиг малтмалыг хууль бусаар олборлосноор татварын орлогоо давхар алдаж байгаа учраас засгийн газрууд энэ салбарт зохицуулалт хийх сонирхол ихтэй байдаг³⁶. Гэхдээ гар аргын олборлолтыг албан ёсны болгож зохицуулахад олон хүндрэл бэрхшээл гардаг бөгөөд ялангуяа эдгээр уурхайчид голдуу алслагдмал газар нутагт үйл ажиллагаа явуулдагтай холбоотой байдаг.

Дэд бүтцийн сайжралт

Аливаа уул уурхайн компани үйл ажиллагаагаа явуулахын тулд ихэвчлэн зам, бохир усны систем, эрчим хүчний эх үүсвэр зэргийг байгуулж ажиллуулах болно. Үүний үр шимийг нутгийн ард иргэд хүртэж болно. Мөн компаниуд уурхайнхаа ойр орчимд эмнэлэг, сургууль ажиллуулж болно. Харин нутгийн иргэдийн хувьд уурхай хаагдах үед яах вэ гэдэг асуудал гол байдаг.

Хөгжлөөр хоцрогдсон эсвэл алслагдсан бүс нутгуудад уул уурхайн компаниуд төрийн зарим чиг үүргийг үр нөлөөтэй гүйцэтгэж байж болно. Энэ нь эдгээр үүргийг хольж хутган, төөрөгдөхөд хүргэж болно. Тухайн компани юугаар хангах ёстой талаар ард иргэд ба компаний удирдлагууд шал өөр ойлголттой байж болно. Нэг үе Африкт уул уурхайн улсын компаниуд нутгийн ард иргэдэд хандсан нилээд өргөн хүрээтэй, эцэг ёсны үүрэг гүйцэтгэх явдал олон байв. Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжлийн тухай тайланд, төрийн өмчийн компаниуд хувийн өмчийн эзэмшилд орсноор тухайн компаний өмнө нь үзүүлж байсан өргөн хүрээтэй нийгмийн тусламж дэмжлэгийг хариуцаж ажиллахыг тэр бүр хүсдэггүй гэж тэмдэглэсэн байдаг³⁷.

Нийгмийн ба хөгжлийн төслүүд

Уул уурхайн компаниуд нөлөөнд нь өртсөн ард иргэдэд туслах төслүүдийг санхүүжүүлэх явдал олонтаа тохиолддог. Жишээлбэл, нутгийн иргэдэд бага хэмжээний буцалтгүй тусламж өгөх, эсвэл үйлдвэрлэл эхлэн эрхлэх зээл олгох, орон нутгийн чанартай үйл явдлуудыг ивээн тэтгэх зэрэг хэлбэрийн тус дэм үзүүлж болно.

Ард иргэдийн, ялангуяа нутгийн уугуул иргэн ахан дүүс нарын маань шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн болон амьжиргааны эрсдлүүд, байгаль орчны их хэмжээний гарз хохирлууд нийлээд үндэстэн дамнасан корпорациудын уул уурхайгаас бий болгохоор амласан эдийн засгийн үр ашгаас давж байна.

Филиппиний Каталок шашны хамба нарын мэдэгдэл, 2006

Ерөнхийдөө алтны уурхайн ажиллагаа зарим нэг эдийн засгийн үр ашиг авчирдаг боловч түүнийг нь тэгш шударгаар хуваахгүй байх явдал олонтаа тохиолддог. Түүнчлэн богино хугацааны ашиг орлогыг урт хугацааны өртөг зардлуудтай нь харьцуулан цэгнэж үзэх шаардлагатай. Алт олборлолтын төслүүд харьцангуй богино, тухайлбал 10-20 жилийн настай байдаг. Ажлын байр, дотоодын дэлгүүр хоршооны бизнес гэх мэт үр ашиг уурхай хаагдмагц байхгүй болдог бол байгаль орчин ба нийгэмд учруулсан нөлөө нь хожим урт удаан хугацаанд мэдрэгдэн үргэлжилдэг талтай.

2. Байгаль орчны гарз хохирол

Алт олборлоход голдуу химийн боловсруулалт ашигладаг учраас алтны уурхайгаас байгаль орчинд үзүүлэх нөлөө онцгой хүнд ноцтой тусдаг.

Гар аргаар олборлоход алтны өчүүхэн хэлтэрхийг ялгаж авахын тулд мөнгөн ус байнга хэрэглэдэг. Ингэснээр мөнгөн ус агаарт дэгдэж, байгаль орчинд төдийгүй хүний эрүүл мэндэд ихээхэн хор хохирол учруулдаг. Энэ нь яагаад зохицуулалт шаардлагатай байдгийн нэг шалтгаан юм.

Томоохон хэмжээний уурхайн ажиллагаа явуулах эхний шат бол алтны орд газар буюу хүдрийн нөөцийг олж тогтоох, түүний үнэ цэнэд үнэлгээ өгөх эрэл, хайгуулын ажил байдаг. Орд газрыг газар доорх гүний уурхайгаар эсвэл ихэвчлэн хэрэглэгддэг ил уурхайн аргаар ашиглаж болно. Өндөр агууламжтай хүдрийн гүн судал байгаа тохиолдолд гүний уурхайг ашигладаг. Харин ил уурхай нь газрын гадаргууд ойр буй агууламж багатай хүдрийн нөөцийг олборлон гаргах хямд төсөр арга зам байдаг. Энэ нь уул уурхайн компаниуд уурхайгаа дахин нээж, өмнө нь ашиггүйд тооцогдож байсан ашигт малтмалын нөөцүүдийг хамруулан хүрээгээ тэлэх боломж олгодог. Ил уурхайн арга нь алт олборлолтын байгаль орчинд учруулах хор нөлөөг нэмэгдүүлдэг.

Овоолж уусгах арга

Овоолж уусгах арга бол цианид ашиглан алт олборлох хэд хэдэн арга техникийн нэг нь юм. Энэхүү аргыг хэрэглэх явцад ургамлын бүрхэвч, өнгөн хөрсний асар өргөн давхаргыг хуулж нүцгэлэх, чулуулгийг дэлбэлэн ухаж гаргах, түүнийгээ

Шударга ёс тогтооцгооё

няцлан нунтаглах, олборлон гаргасан хүдрийг хэдэн зуун фут өндөр, олон акр талбайг хамарсан шороон овоо болгон овоолох ажиллагаа ордог.

Дараа нь натрит цианидийн шингэрүүлсэн уусмалыг овоонууд дээгүүрээ шүршдэг бөгөөд улмаар хүдрийн завсраар цианид нэвчиж, алтны бичил хэсгүүдийг холбож өгдөг. Овооны дор байрлуулсан овооны суурь дэвсгэр (резинэн давхарга) нь нэвчсэн уусмалыг цуглуулах тойром руу урсгаж өгдөг.

Үүний дараа алт угаасан уусмалыг цуглуулж, алтыг химийн боловсруулалтаар ялгаж авдаг. Эндээс үлдсэн хаягдлыг *үлдэгдэл* гэх бөгөөд цианидын хүчлийн үлдэгдэл, хүнцэл гэх мэт бусад бохирдуулагч хорт бодис агуулсан байх нь олонтаа.

Асар их хэмжээний хөрс, чулуулгийг хуулж овоолно гэдэг бол олон тохиолдолд хөдөө аж ахуйд ашиглах газрыг үгүй хийнэ гэсэн үг байдаг. Жишээлбэл, 2003 онд Перугийн Янакоча уурхайг ажиллуулж байсан компани өдөрт 516.000 тонн хөрс хуулж байсан байна³⁸.

Мөн ил уурхайн арга нь ой модыг сүйтгэдэг. Гондурасын Сан Мартиний уурхайн жишээнд гэхэд, тус улсын ой модны газар (CONDEFOR)-аас уул уурхайн Ентре Марес компаний эсрэг албан ёсны гомдол гаргаж, уурхай ажиллуулах газраа байгуулахын тулд 1000-2000 модыг хууль бусаар огтолсон хэрэгт буруутгасан юм³⁹.

Мөн ил уурхайн нүх цооногууд нь хөдөө тосгодын амьдрах орчинг сүйтгэж, ард иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд хүргэдэг. Ялангуяа эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн салбарт ажиллах магадлал ихтэй, уурхайд ажилд орох боломж багатай байдаг учраас эдгээр сөрөг нөлөөнд илүүтэй өртдөг байна.

Цианид

Алтны уурхайтай холбоотой их хэмжээгээр цианид алдсан хэд хэдэн тохиолдол байдгийн дотор 1990-ээд онд АНУ-д гурван удаа, 2001 онд Гана улсад гурван удаа, 2000 онд БН Киргиз улсын Кумторын уурхайд нэг удаа, Румыны Баиа Маред нэг удаа гарсан байдаг⁴⁰. Эдгээрийн сүүлийн алдалтаар 2.5 сая хүний ундны усны нөөцийг бохирдуулсан нь алдагдсан газраас 2000 км зайд 4 долоо хоногийн дараа хийсэн хэмжилтээр илэрч байсан бөгөөд үүнээс болж 1.240 тонн загас үхсэн байна. Харин тус уурхайн компани дөнгөж 170 ам. доллартай тэнцэх торгууль төлөх ёстой болсон ажээ⁴¹. Ийм алдалтаас болж АНУ-ын Монтана муж улс шинээр ажиллуулах уурхайнуудад цианидаар овоолж уусгах арга хэрэглэхийг хориглоод байна. Мөн БН Чех улсад овоолж уусгах аргыг хориглосон байна.

Энд тавигдаж байгаа нэг чухал асуудал бол зөвхөн хорт бодис алдахад хүргэж байгаа аюулгүй ажиллагааны дүрэм зөрчих явдал бус, харин байдлыг нуун дарагдуулж, орон нутгийн ард иргэд ба эрх бүхий байгууллагаас онцгой байдлын сөрөг арга хэмжээ авахад хугацаа алдуулж байгаа явдал юм. Жишээ нь, Кумторын уурхайд гарсан цианидын ослын үед тухайн компани ойролцоох тосгодод мэдэгдэхээс таван цагийн өмнө хорт бодис алдагдаж эхэлсэн байжээ⁴².

Хэдийгээр цианид нь эко системийг богино хугацаанд устгах аюултай ч, алт олборлолтоос үүсдэг бусад хорт бодис урт хугацаанд бүр ч их хор хөнөөлтэй асуудал үүсгэдэг.

Хүчлийн чулуулагт бохир ус

Уул уурхайгаас үүссэн усны бохирдлын дийлэнх нь Хүчлийн чулуулагт бохир уснаас (ХЧБУ) болдог⁴³. Энэ нь уурхайн үйл ажиллагааны явцад чулуулагт агуулагддаг хүхэр хүчилтөрөгч ба устай нэгдэж, хүхрийн хүчил үүсгэх урвал явагдах үед тохиолддог. Уг хүчил нь уурхайн хаягдалд хүнцэл, мөнгөн ус, тугалга гэх мэт хорт металл ялгаруулдаг. Энэхүү хорт шингэн нь урсгал усаар дамжин хөрсөн доорх гүний усыг бохирдуулдаг байна.

Хүчлийн чулуулагт бохир усыг тогтоон барих боломжтой ч үүнд тодорхойгүй урт хугацаа шаардсан өртөг ихтэй ажиллагаа явуулах хэрэгтэй байдаг. Иймээс уурхайг ажиллуулж эхлэхээс өмнө ХЧБУ ялгарах магадлалыг нарийвчлан шалгаж, аливаа Байгаль орчинд нөлөөх байдлын үнэлгээнд оруулж байх ёстой. Мөн ХЧБУ үүсч эхлэх тохиолдолд холбогдох хяналт шинжилгээг уурхайг ашиглах хугацааны турш тогтмол хийж байх ёстой⁴⁴.

Хог хаягдлын менежмент

Ялангуяа ил уурхайн ажиллагаа асар их хэмжээний хаягдал бий болгодог. Энд хамгийн маргаантай байдаг асуудлын нэг бол хүчил үүсгэгч материалууд агуулах нь олонтаа байдаг уурхайн үлдэгдэл ба хаягдал чулуулган овоонуудыг яах вэ гэдэг асуудал юм. Цөөн тооны хөгжиж байгаа оронд уурхайн үлдэгдлийг шууд гол мөрөн эсвэл далай тэнгист хаядаг бол ингэж хаях асуудал АНУ болон Европт хууль бус байдаг байна.

Ус

Ил уурхайн ажиллагаанд асар их хэмжээний ус ашиглаж байгаа нь гол мөрөн, горхи булаг, тэр ч байтугай гүний усны нөөцийг шавхаж байна гэсэн үг. Перу улсад уул уурхайтай холбоотой гарч буй зөрчлүүдийг шинжилж үзэхэд 60 хувь нь усны нөөцтэй холбоотойг харуулж байна⁴⁵. Цаг уурын өөрчлөлтийг нотлох баримт нэмэгдэхийн хэрээр алт олборлолтын зорилгоор ус ашиглах асуудал улам бүр маргаантай болох болно.

Түүнчлэн усны хомсдлын асуудлаас гадна уурхайгаас гарсан хаягдал ус орон нутгийн гол, горхинд орох явдал болон, хур тунадас харьцангуй их үед хорт бодис урсаж тархахтай холбогдсон бэрхшээлтэй асуудлууд үүсч болно.

Тогтмол, хараат бус хяналт шинжилгээ хийх шаардлага

Дээр дурдсан байгаль орчны асуудлууд нь ил уурхай хөдөөд амьдарч буй хүмүүсийн хэвийн амьдралд хор нөлөөтэй байж болохыг хэлж байгаа үг. Үүнийг тэдний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлтэй холбож үзвэл, компаниуд байгаль орчны стандартууд, үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах хараат бус мэргэжилтнүүдээр уурхайн газар нутагт тогтмол хяналт шинжилгээ хийлгэх нь ямар чухал болохыг харуулж байна. Гэвч үүнд хөгжиж байгаа ертөнцийн үндэсний агентлагууд, орон нутгийн захиргаадад тэр бүр байдаггүй хөрөнгө мөнгө, техникийн ур чадварын асуудал нь засгийн газруудаас ард иргэддээ үзүүлж чадах хамгаалалтын түвшинг бууруулж байдаг.

3. Эрүүл мэндэд үзүүлж болох нөлөө

Алт олборлолтын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаарх судалгаанууд голдуу гар аргаар олборлоход ашигладаг мөнгөн усны нөлөөг судлахад чиглэдэг. Ийм олон судалгаагаар тэнд ажиллагсдын 40-70 хувь нь мөнгөн усны хордлоготой байдгийг тогтоосон байдаг. Мөн алт олборлолтын талаар хийсэн зарим судалгаанд, хордлого авч эхлэснээс хойш 20 жилийн дараа уушигны хорт хавдраар нас барах магадлал ихэсдэг бөгөөд алт олборлогчдын 35-47 хувь нь амьдралынхаа турш чулуулгийн тоосонцрын өвчин тусах эрсдэлтэй гэдгийг тогтоожээ. Эндээс үзэхэд алт олборлолт нь урт хугацааны ноцтой үр дагавартай төдийгүй урьд өмнөх хордлогын хор нөлөө алт олборлогчдын амьдралд цаашид удаан хугацаанд мэдрэгдэж байх бололцоотой юм⁴⁶.

Гүний ба ил уурхайн аль алинд тоосонцрын нөлөө гол асуудал байдаг. Энэ нь тэнд ажиллаж буй хүмүүсийн хувьд төдийгүй уурхайн ойр орчимд, нэн ялангуяа шороон замтай газар оршин сууж байгаа ард иргэдэд хүндрэлтэй асуудал болдог. Уул уурхайтай холбоотой өөр нэг асуудал бол мөнгөн ус агаарт уурших явдал бөгөөд хүний эрүүл мэндэд төдийгүй экологийн эрүүл ахуйд эрсдэл учруулж болдог. Ер нь, уурхайн эргэн тойрны агаарын бохирдолтод хяналт шинжилгээ тааруу хийгдэх хандлагатай байна⁴⁷.

Уул уурхайгаас эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндэд өөр өөр нөлөө үзүүлж байгаа эсэх талаар өнөөг хүртэл бага анхаарч ирсэн боловч Уурхай дахь эмэгтэйчүүдийн олон улсын сүлжээнээс уг асуудалд зарим анхаарал тавьсны үр дүнд бусад нөлөөний дотроос эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг онцлон тэмдэглэсэн байна⁴⁸. Түүнчлэн дэлбэлэлт, том машин механизмын хөдөлгөөн гэх мэт дуу чимээний нөлөөний талаар болон уурхайн ажилчид ба уурхайн ойр орчимд амьдрагсдын сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар бага анхаарал тавьж ирсэн байна.

Ерөнхийдөө уул уурхайгаас эрүүл мэндэд үзүүлж болох нөлөөний тухай мэдээлэл олж авах боломж хэцүү, ялангуяа хөгжиж байгаа орнуудад илүү хүндрэлтэй байдаг. Одоо байгаа ихэнх судалгаа нь хөгжилтэй орнуудын эрэгтэйчүүдэд үзүүлж

буй нөлөөнд тулгуурласан байдаг. Хөгжиж байгаа орнуудад хийгдсэн судалгаа нь маш цөөн тооны түүвэр судалгаанд тулгуурласан, хяналтын хангалттай тоо баримтгүй байдаг. Уул уурхайгаас эрүүл мэндэд үзүүлж болох боломжит нөлөөг бүрэн ойлгохын тулд найдвартай тоо баримт цуглуулж, нэгдсэн дүн шинжилгээ хийхэд илүү их анхаарал тавих хэрэгтэй юм.

4. Хүйс

Эмэгтэйчүүд гэр бүлийнхээ эрүүл мэнд, хоол ундны асуудлыг голдуу хариуцдаг учраас усны хэмжээ, чанар буурч байгаа явдал тэдэнд илүү их нөлөөлж байж мэднэ. Үүнтэй адилаар түлээ мод түүх үүрэгтэй байдаг газруудад ой модыг устгаж үгүй болгосны нөлөө ч тэдэнд илүүтэй тусч байж болно. Мөн эмэгтэйчүүд өрхийн хэрэглээндээ эсвэл борлуулахад зориулж тариа ногоо тарьдаг бага хэмжээний газраа ч алдаж мэднэ. Эдгээрийн үр дүнд эмэгтэйчүүдийн өрх гэртээ болон нийгэмд эзэлдэг байр суурь, зэрэг зиндаанд ч уул уурхай сөргөөр нөлөөлөх талтай. Түүнчлэн эмэгтэйчүүд нөхрийнхөө олсон орлогоос илүү хамааралтай болох эсвэл айлд зарцлагдах, биеэ үнэлэх гэх мэт ажилд татагдан орж эмзэг байдлаа улам дордуулах талтай.

Уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртөх ард иргэдтэй зөвлөлдөж шийдэл хайх үедээ түүнд хамгийн их өртөж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дуу хоолойг адилхан сонсоход онцгой анхаарал хандуулах ёстой. Эс тэгвээс хүйсийн болон бусад чиглэлийн тэгш бус байдлыг, тухайлбал уул уурхайгаас олгох нөхөн төлбөрийг хэрхэн зарцуулах хяналтыг эрчүүд гартаа авах эсвэл шинээр олгох газрын эзэмших эрхийг зөвхөн эрчүүдэд олгох зэрэг тэгш бус байдлыг уул уурхайн үйл ажиллагаа даамжруулах аюултай.

5. Засаглал ба авилга

Уул уурхай авилга газар авах эрсдлийг нэмэгдүүлж болно. Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гаас явуулсан судалгаанд олборлох үйлдвэрлэлийн салбар бол “авилгын нэг гол шийдвэрлэгч хүчин зүйл” бөгөөд хөдөө аж ахуй гэх мэт эдийн засгийн бусад салбараас хамаагүй илүүгээр авилга өдөөх магадлалтай гэж дүгнэжээ⁴⁹. Ашигтай талбай, гэрээний хөнгөлөлтүүдийн төлөө өрсөлдөж байна гэдэг бол тодорхой нэг лиценз эсвэл тусгай зөвшөөрөл олгох эсэхээс их зүйл хамаарч байна гэсэн үг.

Аливаа улсын нөөц баялаг эдийн засагт нь эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлэх эсэх нь түүний институциудийн чанараас хамаардаг. Сайн институцитэй улс орны эдийн засагт байгалийн баялаг эерэг нөлөө үзүүлнэ, энэ нь очир алмааз болон үнэт металлын нөөцөөр баян орнуудын хувьд хамгийн чухал гэж Босчини, Петерссон

нар үздэг⁵⁰. Харамсалтай нь, алтнаас хамгийн их хамааралтай олон оронд авилга ужгирч газар авсан байдаг. Хээл хахуулийг нотлоход ихэнхдээ хэцүү байдаг бөгөөд нутгийн ард иргэдийн хувьд, хэдийгээр зохих ёсны хууль журмын дагуу явсан ч гэсэн эцсийн үр дүнд нөлөөлж чадахгүй гэж үзэн, эрх мэдэл дутагдаж буйгаа мэдэрдэг.

Улс орныхоо байгалийн баялгийн үр шимийг хэн хүртэж байгааг иргэд мэдэхгүй байх явдал дэндүү элбэг тохиолддог. “Юу төлж байгаагаа нийтэл” хэмээх кампанит ажлаар олборлох үйлдвэрлэлийн компаниуд засгийн газруудад төлж буй бүх төлбөрөө зүйлчлэн задалж (татвар, нөөц ашигласны төлбөр гэх мэт), улс орон бүрээр нь хэвлэн нийтлэхийг уриалж байна⁵¹. “Юу төлж байгаагаа нийтэл”-ийнхэн газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарыг бүхэлд нь хамарсан өөрчлөлт гаргах зорилгоор энэхүү мэдээллийг хэвлэн нийтлэх үүргийг хөрөнгийн биржийн жагсаалтад бичихэд заавал тавих шаардлага болгох, үндэсний болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад оруулахыг хүсч байгаа юм. Уул уурхайгаас олж буй орлого ашгийн талаар илүү их ойлголцтой болох нь тэдгээр орлогыг хэрхэн зарцуулж байгааг хянаж, засгийн газруудад хариуцлага хүлээлгэх боломжийг иргэний нийгмийнхэнд олгож буй анхны алхам юм. Засгийн газар ба компаниуд орлогоо олон нийтэд ил тод зарладаг болсноор авилгыг нуун далдлахад улам хэцүү болох юм.

Орлогын ил тод байдлыг үндэсний болон орон нутгийн түвшинд хангахын ач холбогдлыг уул уурхайн хэд хэдэн тэргүүлэх компаниуд онцлон тэмдэглэж байна⁵². Орон нутгийн ард иргэд алт олборлолтын сөрөг нөлөөний дийлэнхийг амсаж туулдаг учраас нутгийн ард иргэдэд зориулж бий болгосон орлогоо тодорхой харуулах нь тухайн компаниудын ашиг сонирхлын асуудал юм. Зарим оронд засгийн газар нь татварын орлогыг орон нутгийн түвшинд хуваарилах үүрэгтэй байдаг бол, нөгөө зарим орны хувьд компаниуд шууд орон нутгийн байгууллагуудад төлбөр төлдөг байна. Уул уурхайн компаниуд өөрсдөө бүх төлсөн төлбөрүүдээ жилийн тайландаа оруулах, үйл ажиллагаа явуулж буй нутаг орныхоо орон нутгийн болон үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж нийтлэх замаар уурхайн санхүүгийн үр өгөөжийн тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхийн зэрэгцээ авилгын эрсдлийг бууруулж чадах юм.

6. Уул уурхай ба зөрчил мөргөлдөөн

Байгалийн баялаг, зөрчил мөргөлдөөн хоёр нягт уялдаатай байдаг нь хөгжиж байгаа ертөнцийн олон хүнд газрын тос, байгалийн хий, эрдэс баялаг ач буян болохоосоо илүү хяслан болдгийг тайлбарлах нэг шалтгаан юм. 2001 онд гарсан 50 орчим дайн, мөргөлдөөнөөс үзэхэд дор хаяж дөрөвний нэгд нь зөрчил мөргөлдөөнийг өдөөх юм уу үргэлжлэхэд байгалийн баялгийн ашиглалт нөлөөлсөн нь харагдаж байна⁵³. Ангол, Сиерра Леоне, БН Ардчилсан Конго зэрэг улсад гарсан зөрчил мөргөлдөөнүүд даамжирахад очир алмааз, тантал, касситерит, алтны уурхайн ажиллагаа нилээд үүрэг гүйцэтгэсэн байна⁵⁴.

Хувийн хэвшлийн, ялангуяа олон улсын компаниудын оролцоо ч нэмэлт асуудал (доорх хүснэгтийг үзнэ үү) үүсгэж байна. Ард иргэдийн түвшний зөрчилдөөн голдуу уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой байдаг⁵⁵. Уурхайн үр шимийг зарим хүмүүс бусдаасаа илүү хүртэж байна гэсэн ойлголт ч цаашдын гүнзгий хагарал үүсгэж болно.

Компани буюу зөрчилдөөний байдал

1. Газрыг чөлөөлөх (тухайлбал уурхайн зориулалтаар) үүднээс нутгийн ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх нь ард иргэд ба компаний хооронд төдийгүй ард иргэдийн дунд зөрчилдөөн үүсгэхэд хүргэдэг.
2. Компаний явуулж буй үйл ажиллагаа ард иргэдийн дунд эсвэл ард иргэд ба орон нутгийн буюу үндэсний эрх бүхий этгээдүүдийн хооронд өмнө нь үүссэн хурцадмал байдлыг улам хурцатгаж, хүчирхийллийг өдөөдөг.
3. Засгийн газарт төлж буй орлогын төлбөрүүд нэгэнт сул дорой байсан засаглалын бүтцэд тогтворгүйжүүлэх нөлөө үзүүлж, урт хугацаанд зөрчил мөргөлдөөн гарах магадлалыг нэмэгдүүлдэг.
4. Дээрх орлогыг зэр зэвсэг худалдан авахад ашигласнаар зөрчил мөргөлдөөнийг даамжруулах буюу хурцатгадаг.

Хуулбарлаж авсан эх сурвалж: Олон улсын сэрэмжлүүлэг, *Зөрчилдөөнд өртөмхий бизнесийн практик: Олборлох үйлдвэрлэлд зориулсан заавар*, 2005, Хэсэг 1, хуудас 6.

Баруун Папуа дахь Грасбергийн алт, зэсийн уурхай хэдэн арван жилийн турш зөрчилдөөний эх сурвалж болсоор байна. Индонезийн Засгийн газар 1967 онд Фрийпортод лиценз олгосон нь тус улсын хүн амын тусгаар тогтнолын төлөөх удаан хугацааны тэмцлээс үүсээд байсан хурцадмал байдалд гал нэмсэн байна. Улмаар уг уурхайг хамгаалахаар Индонезийн аюулгүй байдлын хүчнийхэн ирж ажиллах болсон нь хүн ор сураггүй алга болох, амь насыг нь хөнөөх, хүчирхийлэх, эрүүдэн зовоох явдал гарахад хүргэсэн юм⁵⁶.

Мөн гар аргаар олборлох болон том хэмжээний уурхай хоёр зэрэгцэн орших явдал зөрчилдөөн үүсэхэд хүргэж байна. Томоохон компаниуд өндөр түвшний хамгаалалтынхан хөлсөлж, гар аргаар олборлогчдыг хөөн зайлуулахад ашигласан жишээ олон байдаг. 1996 онд Кахама Майнинг Корпораци цагдаагийн хүч ашиглаж 400.000 шахам гар аргаар олборлогчдыг гэр бүлийн хамт уурхайн талбайгаас хүчээр нүүлгэн шилжүүлж, албадан хөөн гаргасан гэж Танзаний нэгэн ТББ буруутгасан байдаг⁵⁷. Гар аргаар олборлогчид, томоохон уул уурхайн

компаниуд хэрхэн харилцах, ялангуяа хүч хэрэглэсэн зөрчилдөөн үүсгэхгүйгээр яаж харилцах вэ гэдэг нь тус салбарын нэг гол асуудал юм.

7. Нутгийн уугуул иргэдэд үзүүлэх нөлөө

1995-2015 оны хооронд олборлох алтны тал хувь нь нутгийн уугуул иргэдийн уламжлалт газар нутгаас гаралтай байх магадлалтай гэсэн тооцоо байдаг⁵⁸. Нутгийн уугуул иргэдийн хувьд алт олборлолт тэдний бүхэл бүтэн соёл, амьдрах арга замд аюул занал учруулж чадна. Тодорхой нэг бүс нутаг, газар оронтой оюун санааны холбоотой байна гэдэг бол уламжлалт газар нутгаа алдаад, оронд нь өөр газар руу албаар нүүн шилжиж, нөхөн төлбөр авах асуудал байж болшгүй гэсэн үг. Олон улсын хамтын нийгэмлэгээс нутгийн ард иргэдийн онцгой нөхцөл байдлыг олон улсын хүний эрхийн хуулинд хүлээн зөвшөөрч, улс орнууд хөгжлийн замаар замнахын тулд эдгээр эрхийг зөрчих ёсгүй гэж заасан байдаг⁵⁹. Мөн Нутгийн уугуул ба омгийн хүмүүсийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 169 дүгээр Конвенцид “нутгийн уугуул иргэд өөрсдөд нь нөлөөлж буй төр засгийн бүхий л шийдвэрт уламжлалт байгууллагаараа уламжлан оролцох эрх”-ийг хүлээн зөвшөөрсөн байдаг⁶⁰.

Компаниуд уул уурхайн төслөө хэрэгжүүлэх зөвшөөрөл авахын тулд нутгийн уугуул иргэдэд дарамт шахалт үзүүлэх нь олонтаа тохиолддог. Энэ нь сунжирсан хагарал, зөрчилдөөн үүсгэдэг. Филиппиний Минданао арал дээрх Субан хүмүүст тохиолдсон явдал бол алт олборлолтоос болж нутгийн уугуул иргэдийн зөрчилдөөн үүсгэсний нэг жишээ юм.

Канадын TVI Пасифик компани хэдэн жилийн турш нутгийн уугуул иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсны эцэст одоо субанчуудын уламжлалт газар нутагт алт олборлож байна⁶¹. Нутгийн уугуул иргэдийн ариун дагшин уулыг уул уурхай сүйтгэж байна гэж нутгийн иргэд хэлдэг бол тус компани энэ нэхэмжлэлийг нь үгүйсгэн маргаж байна. Уурхайн үйл ажиллагааны талаарх зөрчилдөөн нь ард иргэдийн дунд хурц зөрчил хагарал үүсэхэд хүргэсэн нь тодорхой⁶². Тус компани уурхайн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай зөвшөөрлийг авахын тулд тэдний уламжлалт байгууллагыг хуурч аргалсан гэж субанчуудын зарим нь үзэж байна. Одоо уг уурхайн эргэн тойрны бүс нутгийг цэрэгжүүлж, зэвсэгт хамгаалагчид, замын хаалтуудаар хамгаалсан байна⁶³. Уурхайн ажиллагааг идэвхтэй эсэргүүцдэг Субаны хэд хэдэн удирдагчид амь насыг нь хөнөөхөөр заналхийлсэн гэсэн мэдэгдэл хийж байна⁶⁴.

Уугуул иргэдийн эрхийн асуудлыг өргөн хүрээтэй авч үзсэн Дэлхийн Банкны Олборлох үйлдвэрлэлийн үнэлэлт дүгнэлтэд, нутгийн уугуул иргэд уул уурхайн компаниудтай тохиролцсон төслүүдийн талаарх хангалттай мэдээллийг ямар нэг зохисгүй дарамт шахалт, хөндлөнгийн оролцоогүйгээр авч байсан тохиолдолд л уурхайн үйл ажиллагаа явуулах ёстой гэсэн шийдвэр гаргасан байна. Үүндээ

“мэдэж гаргасан, үнэ төлбөргүй, урьдчилан өгсөн зөвшөөрөл” гэсэн нэр томъёо ашигласан байна. Мөн энэ зарчмыг уул уурхайн шууд нөлөөнд өртсөн бусад ард иргэдэд ч хэрэглэх юм.

“ОУҮД-тэд нутгийн уугуул иргэд болон нөлөөнд өртсөн бусад талууд шийдвэр гаргалтад оролцох, төслийн мөчлөгийн үе шат бүрт өөрсдийн мэдэж гаргасан, үнэ төлбөргүй, зөвшөөрлийг урьдчилан өгч байх эрхтэй гэж дүгнэсэн байна. Энэхүү зөвшөөрлийг үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл байгаа эсэхийг тодорхойлох үндсэн хүчин зүйл гэж үзэх ёстой...”⁶⁵

Дэлхийн Банк уул уурхайн компаниуд ба үндэсний засгийн газруудын дарамт шахалтын дор энэхүү санал зөвлөмжийг “мэдэж хийсэн, үнэ төлбөргүй, урьдчилсан зөвлөлдөөн” болгож сулруулсан байна. Энэ бол маш сул томъёолол юм. Зөвлөлдөөн гэдэг нь нөлөөнд өртөж буй ард иргэдийн санаа бодлыг харгалзаж үзэх нь заавал биелүүлэх үүрэг биш гэсэн үг.

Уул уурхайн тухай бүхий л маргаан мэтгэлцээний хамгийн их хэл амтай асуудлын нэг нь энэхүү зөвшөөрлийн асуудал байсаар байна. Жинхэнэ мэдэж гаргасан, үнэ төлбөргүй урьдчилан өгөх зөвшөөрөл бол нутгийн ард иргэдийг арилжааны хувьд ашигтай боловч нийгмийн ба байгаль орчны өртөг зардлаас давахуйц өндөр ашиг тус өгөхгүй байж болох төслүүдийг зогсоох чадвартай болгох юм. Мэдэж гаргасан, үнэ төлбөргүй зөвшөөрөл урьдчилан олгох үйл явцыг хөгжүүлэх нь ирээдүйн уул уурхайн төслүүдийг хялбар болгоно гэж хэлэхэд амархан. Гэвч хэрэв уул уурхайн салбар, үндэсний засгийн газрууд, олон улсын санхүүгийн байгууллагууд тогтвортой уул уурхайн загвар боловсруулах талаар үнэхээр санаа тавьж байгаа бол энэ асуудлыг онцолж авч үзэх шаардлагатай. Одоогоор уул уурхайн хоёр томоохон компани өөрсдийн бодлогод мэдэж гаргасан, үнэ төлбөргүй, урьдчилсан зөвшөөрөл авах асуудлыг нэгэнт тусгаад байгаагаа мэдэгдээд байна⁶⁶. Эцсийн эцэст, эсэргүүцээр байхад уурхай ажиллуулаад байх юм бол хэн ч хожихгүй, тогтворгүй байдал, зөрчил мөргөлдөөний улмаас хаагдах л болно.

8. ХДХВ ба ДОХ

Уурхай бий болсноор хүмүүст ХДХВ буюу хүний дархлал дутлын вирус халдах боломж нэмэгдэж мэднэ. Олборлох салбарууд нь шууд ажил хайсан эсвэл уурхайчид ба компаниудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах шууд бус боломж хайсан шилжин суурьшигчдийг татаж байдаг. Тэнд байсан худалдааны зам харгуйн хөдөлгөөний ачаалал нэмэгдэж эсвэл шинэ зам харгуй бий болдог. Шилжилт хөдөлгөөн болон шилжин суурьшигчид, тэдний гэр бүл, нутгийн иргэд ХДХВ-ийн халдварт өртөмтгий байх явдал хоёр хоорондоо уялдаатай болохыг судалгаагаар хэдийнээ тогтоож баримтжуулжээ⁶⁷.

Таатай боломж, эдийн засгийн ашиг орлого хайсан шилжин суурьшигчид гэр орноосоо удаан хугацаагаар хол ажилладаг нь бэлгийн хавьтагч нарынх нь тоо нэмэгдэх боломж бүрдүүлдэг. Мөн гэр орноосоо удаан хугацаанд хол байх нь согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ гэх мэт бусад ноцтой асуудал гарахад хүргэж болно. Ажил олж чадаагүй эмэгтэй шилжин суурьшигчид, нутгийн эмэгтэйчүүд ч биеэ үнэлэх ажилд татагдан орж болно. Мөн бэлгийн хүчирхийлэл ч ДОХ өвчний тархалтад хүргэж болно. Шинэ газар нүүж очсон шилжин суурьшигчид эмнэлгийн болон бусад дэмжлэг үйлчилгээ авахдаа удаан байдагт тэдний эрх зүйн байдал баталгаагүй эсвэл ажиллах нөхцөл баттай бус байдал нөлөөлдөг. Түүнчлэн эр нөхөр нь ХДХВ-ийн халдвар аваад эргэж ирвэл ар гэртээ үлдэж хоцорсон эхнэр нь ч эмзэг өртөмтгий байх болно.

Корпорациуд ХДХВ-ийн халдварт хэрхэн хувь нэмэр оруулж байгаа тухай ойлголтыг Эрдэс баялаг ба уул уурхайн тухай Өмнөд Африкийн цагаан хуудас (1998)⁶⁸ хэмээх баримт бичигт харуулсан байна. Гэвч уг салбар бүхэлдээ ХДХВ-ийн тархалтын нэг шалтгаан гэж үзэх нь ховор боловч ХДХВ тархахад хүргэдэг нөхцөл байдлуудыг арилгахад олборлох үйлдвэрлэлийн салбарууд гол үүрэг гүйцэтгэж болох юм. Тус салбар үйл ажиллагаа явуулснаар, мөн ямар нэг бүс нутаг эсвэл улсад ирж ажилласнаар ХДХВ-ийн халдварт ямар нөлөө үзүүлж болох талаар илүү идэвхтэй байр сууринаас судалгаа шинжилгээ хийж, ажлын байран дээр ХДХВ ба ДОХ-ийн үзүүлэх нөлөөг багасгахад зориулсан одоо байгаа олон заавар, сэргийлэх арга замуудад хувь нэмэр оруулах ёстой. Уул уурхайн компаниуд хүмүүсийн ХДХВ-ээр өвчлөх боломж нэмэгдэхэд гүйцэтгэж буй үүргээ ойлгож, хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ажиллагсдынхаа болон олон түмний өмнө хүлээх үүргээ хэр сайн ухаарч байгаагаа харуулж чаддаг болно.

Нөөц баялгийн хясланг арилгах нь

Алт олборлолтын үнэ цэнийн тухай мэтгэлцээн маш их туйлширсан байдаг. Алт олборлолтоос үүдэх боломжит хүндрэл бэрхшээлүүд, хор хохирлын талаарх мэдлэг дээшилсээр байтал түүнд хамгийн ойр оролцдог бүлгүүд авбал зохих арга хэмжээнүүдийн талаар тэс өөр үзэл бодолтой байна.

Уул уурхайн салбар олон янзын сайн дурын стандарт, санаачилгуудыг хөхиүлэн дэмжиж байна. Мэдээж энэ бол маш өргөн хүрээтэй салбар бөгөөд компаниудын үйл ажиллагаа, арга барил нилээд олон янз байдаг. Томоохон үндэстэн дамнасан компаниудыг төлөөлсөн салбарын байгууллагууд өөрсдийн техник мэдлэг, далага туршлагадаа тулгуурлан тэргүүн туршлагын жишээнүүд гаргаж байна. Энд яригдаж буй сэдэв бол “тогтвортой хөгжилд шилжих”, “нөөц баялгийн хясланг давж гарах” явдал юм. Мөн энд алт олборлолтын салбарт эрс өөрчлөлт гэхээсээ илүү шинэчлэлт хийх зорилт тавигдаж байгаа бөгөөд компаниуд заавал биелүүлэх шаардлага биш, сайн дурын арга хэрэглэх явдал нэн тэргүүнд тавигдаж байна.

Корпорациудын бодлого ба амьдрал дээрх бодит байдлын хоорондох зөрүүний тухайд нутгийн ард иргэдийн бүлгүүд, үндэсний ба олон улсын ТББ-ууд, нутгийн уугуул иргэд гутранги үзэл бодолтой байна. Олонхийн шийдвэрт хүчин мөхсдөх вий гэдэгт иргэдийн анхан шатны байгууллагын идэвхтнүүд онцгой санаа зовж байна. Иймээс тэд элдэв санаачилга, мэтгэлцээнийг хясан боогдуулж байна. Үндэсний ба олон улсын түвшинд тус салбарын лобби хүчтэй байгаа явдал болон өмнөх туршлагауд нь тэдэнтэй яриа хэлэлцээ хийснээр ямар нэг бодитой өөрчлөлт гарах эсэх тухайд гутруу үзэлтэй байхад хүргэж байна. Иргэний нийгмийн олон бүлэгт тавигдаж буй шийдвэрлэх гол асуулт бол уул уурхайн өнөөгийн практикийг яаж сайжруулах вэ гэдэгт бус, уул уурхайн үйл ажиллагаа явуулах уу, үгүй юу гэдэгт оршиж байна. Ард иргэдэд учруулж буй нийгмийн ба байгаль орчны хор хохирлоос үүдэн зарим анхан шатны байгууллагууд ерөөсөө уул уурхайг эсэргүүцэх байр суурьтай байгаа бөгөөд үүний нэг жишээ бол Гватемал улсын Сан Маркост Гламис Гоулд компаний маргаантайгаар ажиллуулж буй Марлиний уурхайг хаах кампанит ажил үргэлжлэн явагдаж байгаа явдал юм⁶⁹.

Алт олборлолтын салбартай холбоотой сүүлийн үеийн санаачилгууд

Салбарын санаачилгууд:

Уул уурхай, металлын олон улсын зөвлөл (УУМОУЗ)

УУМОУЗ бол “уул уурхай, эрдэс баялаг, металлын салбарыг орчин үеийн амьдралд онцгой чухал үүрэгтэй бөгөөд тогтвортой хөгжилд гол хувь нэмэр оруулагч хэмээн хаа сайгүй хүлээн зөвшөөрөгдсөн амьдрах чадвартай салбар болгох” зорилготой салбарын байгууллага юм.

АнглоАмерикан, Ньюмонт, Рио Тинто зэрэг компани тус байгууллагын гишүүн байдаг. Одоогоор уул уурхайн салбарыг амжилттай хөгжүүлсэн орнуудын уул уурхайгаас хөгжилд үзүүлсэн үр шимийг судалж, энэ амжилтыг бусад газарт дэлгэрүүлэх төслүүд хэрэгжүүлж байна. УУМОУЗ-өөс Тогтвортой Хөгжлийн Хүрээг тодорхойлж, компаниудын үйл ажиллагааг сайжруулахад туслах янз бүрийн арга хэрэгслүүдийг боловсруулаад байна⁷⁰.

Дэлхий дахины тайлагналын санаачилга (ДДТС)

ДДТС бол дэлхий нийтээр хэрэглэгдэх тогтвортой байдлын тайлагналын заавар удирдамж боловсруулж, дэлгэрүүлэх зорилготой олон оролцогч тал бүхий үйл явц юм. Тус байгууллага уул уурхай, ашигт малтмалын салбарт зориулсан тусгай нэмэлт заавар боловсруулах ажлыг 2005 оны 2 дугаар сард эхлүүлсэн байна. Үүнд ашигтай мэдээллүүд орсон боловч эцсийн дүндээ ямар ямар элементийг тогтвортой байдлын эсвэл корпорацийн нийгмийн хариуцлагын тайландаа оруулахыг компаниуд өөрсдөө сонгох юм байна.

Цианидын удирдлагын олон улсын дүрэм (ЦУОУД)

Алтны салбарынхан НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөртэй хамтран алтны үйлдвэрлэл дэх цианидын аюулгүй удирдлагын сайн дурын дүрэм боловсруулаад байна. 2006 оны 3 дугаар сарын байдлаар энэ дүрэмд уул уурхайн 12 компани гарын үсэг зурж нэгдэн ороод байна⁷¹.

Үнэт эдлэлийн хариуцлагатай үйл ажиллагааны зөвлөл (ҮЭХҮАЗ)

2005 онд уул уурхайн компаниуд, боловсруулагчид, жижиглэнгийн худалдаачид, худалдааны холбоод хамтран ҮЭХҮАЗ-ийг байгуулжээ. Одоо тус зөвлөл гишүүддээ зориулсан үйл ажиллагааны дүрэм боловсруулж байна.

ТББ-ын санаачилгууд:

Ард иргэдийн бүлгүүдээс төрж гарсан олон тооны санаачилга, сүлжээнүүд байдгийн дотор Сүм хийдүүдийн нутгийн уугуул иргэдийн хөтөлбөрийн дэлхийн зөвлөл, JАТAM буюу Индонезийн уул уурхайн нөлөөллийн холбоо, WACAM буюу Уул уурхайн нөлөөгөөр хохирсон ард иргэдийн Уасса холбоо, Энэтхэг дэх “Уурхай, эрдэс баялаг ба хүмүүс” байгууллага, мөн Перугийн Улаан Миквигийн уурхайн сүлжээ зэргийг дурдаж болно.

Зөрчилдөөнд өртөмтгий бизнесийн үйл ажиллагаа: Олборлох үйлдвэлд зориулсан заавар бол 2005 оны 3 дугаар сард Интернэшнл Алерт буюу Олон улсын сэрэмжлүүлэг байгууллагаас гаргасан практик хэрэгсэл юм.

Ашигт малтмалын салбарт ажилладаг ТББ-ууд, жижиглэнгийн худалдаачид, хөрөнгө оруулагчид, даатгалынхан, техникийн шинжээчдийн хамтран бүтээсэн **Хариуцлагатай уул уурхайн хүрээ** буюу уул уурхайгаас үзүүлэх нөлөөний дэлгэрэнгүй тойм хэмээх ажил 2005 оны 10 дугаар сараас эхлээд байна. Энэхүү хүрээ нь яриа хэлэлцүүлэг өрнүүлж, стандарт тогтоох зорилготой юм. Энд нийгмийн болон байгаль орчны өргөн хүрээтэй асуудлаарх одоо байгаа салбарын практик ажиллагааг тогтоож, “шилдэг тэргүүний” практик ажиллагааг тодорхойлж өгч байна. Уг төслийг олон нийтийн ашиг сонирхлын бүлгүүд, нутгийн уугуул иргэдэд уул уурхайн асуудлаар техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус байгууллага болох Олон нийтийн оролцоон дахь шинжлэх ухааны төв гэдэг байгууллага удирдан хэрэгжүүлж байна.

Олон оролцогч тал бүхий санаачилгууд:

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)

2002 онд Их Британи улсаас санаачилан гаргасан ОУИТБС нь үндэсний засгийн газрууд, олборлох компаниуд, иргэний нийгмийн төлөөлөгчдийг оролцуулсан олон оролцогч тал бүхий санаачилга юм. Энэ нь нөөц баялаг ихтэй баян орнуудад тулгардаг нэг онцлог асуудал болох авилгыг онцлон авч үзэхэд чиглэдэг.

Тус санаачилга улс орнууд нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа явуулж буй олборлох үйлдвэрлэлийн бүх компаниас хүлээж авсан орлогоо дэлгэрэнгүйгээр нийтэлдэг болгох зорилготой. Эдгээр тоо баримтад хараат бус аудит хийлгэх бөгөөд иргэний нийгмийнхэн ОУИТБС-ын үйл явцын бүхий л үе шатанд оролцох юм.

Одоогоор Азербайжан, Нигери улсууд газрын тосны орлогынхоо баримтуудыг нийтлээд байна. Анхандаа уул уурхайгаас хамааралтай орнуудын сонирхлыг татаж, амжилт олохоор байсан уг санаачилга Гана, БН Киргиз улсуудад зогсонги байдалд орчихоод байх шиг байна. Энэ санаачилгад оролцох сонирхлоо илэрхийлсэн алт олборлогч бусад орнуудын тоонд Перу, БН Ардчилсан Конго, Монгол орж байна.

Олон талт байгууллагуудын санаачилгууд

Дэлхийн Банк, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Их Британий Олон Улсын Хөгжлийн Газар зэрэг байгууллага гар аргаар олборлогчдын үйл ажиллагааг цэгцлэх, байгаль орчны голлох асуудлуудаар уурхайчдад боловсрол олгох, амьжиргааны эх үүсвэрийн төрлийг олшруулах, тогтвортой зээллэг олгох болон тоног төхөөрөмж хуваах хөтөлбөрүүд боловсруулах зэрэг дэлхийн нийтийн арга хэмжээнүүдэд оролцож байна. Энэ салбарыг албан ёсны болгох, туслалцаа үзүүлэх зорилгоор сая сая доллар амлаад байгаа боловч уурхайчдад зохих

зөвлөгөө өгөхгүй, тэдний үйл ажиллагаа явуулж буй орчин нөхцлийг бүрэн ойлгохуйц хангалттай анхаарал тавихгүй байгаа учраас уурхайчдын хүртэх бодит ашиг тус бага гэж нэг эрдэмтэн үзсэн байдаг⁷².

Одоо уул уурхайн компаниуд хөгжиж байгаа ертөнц дэх алт олборлолтын практик ажиллагааг сайжруулах, сөрөг нөлөөг багасгах чиглэлд нэг бол бие даан эсвэл салбарынхаа хэмжээгээр арга хэмжээ авч чадна. Гэвч үр дүнтэй өөрчлөлт гаргахад дан ганц сайн дурын санаачилга хангалтгүй байх болно. Маш цөөн тооны алтны уурхайн компани дээр дурдсан санаачилгуудад оролцох сонголт хийгээд байгаа бөгөөд ахиц дэвшил нь алаг цоог байна. Салбарын санаачилгуудыг заавал биелүүлэх шаардлагатай зүйрлэх хэрэггүй. Уул уурхайн тогтвортой хандлагын төлөө жинхэнээсээ зүтгэж буй компаниуд бол үндэсний болон олон улсын хууль тогтоомжийг улам чангаруулах гэсэн оролдлогыг эсэргүүцэх ёсгүй.

Компаний үйл ажиллагааг үндэсний болон олон улсын түвшинд зохицуулах нь

Нөөцийн хясланг дуусгавар болгохын тулд уул уурхайн салбарыг зохицуулах үндэсний хатуу чанд хууль тогтоомж гаргаж, үр нөлөөтэй сахиулах шаардлагатай. Ийм хууль тогтоомж нь байгаль орчны өндөр стандарт тогтоох, ашигт малтмалын хөнгөлөлт олгох нарийн, ил тод зөвлөлдөх дүрэм журмаас гадна хүн амд үр шимээ өгөх татварын дэглэм тогтоох ёстой. Үндэсний засгийн газрууд татварын тааламжтай орчноор дамжуулан гадаадын хөрөнгө оруулалтыг татах хууль гаргаж, хөнгөлөлт олгох үйл явцыг оновчтой болгож байна. Үүнийгээ голдуу Дэлхийн Банк, ОУВС-гийн шахалтан дор хийх нь олонтаа⁷³. Гондурасын жишээнээс харж байхад, олон нийтийн дотор зөвшилцөлд хүрсэн хэдий ч нэгэнт тогтчихсон уул уурхайн тухай хуулиа өөрчлөхөд хэцүү байдаг байна.

Эцсийн дүнд заавал даган биелүүлэх олон улсын стандарттай байж, эдгээр стандартыг хангаагүй тохиолдолд засч залруулдаг үр нөлөөтэй арга хэрэгсэлтэй болох шаардлагатай. Иймэрхүү олон улсын стандарт боловсруулах чухал гарааны цэг бол Үндэстэн дамнасан корпорациуд ба бизнесийн бусад байгууллагын Хүний эрхтэй холбоотойгоор хүлээх хариуцлагын тухай НҮБ-ын нормууд юм. Уул уурхайн компаниуд төвлөрдөг улсуудын засгийн газар ч бизнесийн хариуцлагатай байдлын өндөр стандарт тогтоох үүрэгтэй байдаг. Компаниудиаас нийгэм болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөгөө тайлагнахыг шаардах, Их Британий компаниудын нөлөөгөөр хохирч буй хилийн чанад дахь ард иргэдэд шударга ёсоор хангагдах боломж олгох өөрчлөлтүүдийг компаний тухай хуулиндаа оруулахыг Их Британий CORE Эвсэл шаардаж байна⁷⁴.

Дүгнэлт

Алт олборлолт нь хөгжиж байгаа орнуудын хувьд сайн муу янз бүрийн үр нөлөөтэй. Түүний нийгэм болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь ялангуяа уул уурхайн ажиллагаа шууд нөлөөлж буй ард иргэдийн хувьд маш илэрхий байдаг боловч алт олборлолтын эдийн засгийн үр ашгийг гаргаж харуулахад илүү хэцүү байдаг. Түүний ачаар хязгаарлагдмал тооны хүмүүсийн амьдрал эрс сайжирдаг бол олборлолтоос бий болсон ашиг орлого нийт хүн амын хөгжилд чухал сайжруулалт гаргахгүй байх явдал элбэг байдаг. Энэ бүхнээс үзэхэд ард иргэдэд уурхайн ажиллагаа явуулах төлөвлөгөө, явагдаж буй ажиллагааны нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөө, бий болгосон орлогын талаарх мэдээлэл хэрэгтэй төдийгүй уурхайн төслүүдийг цааш үргэлжлүүлэн явуулах эсэх, түүнээс олсон орлогыг хэрхэн ашиглах талаар тэд үгээ илүү их хэлдэг болох шаардлагатай нь тодорхой болж байна.

Бүлэг 4

Жишээ судлал: Гондурасын хувьд алтан боломж уу?

“Испанийн булаан эзлэгчдийн хувьд ядаж манай колонийн өмч хөрөнгө тэднийх байх эрхтэй гэж бодоход хүргэхүйц геополитикийн болон антропологийн өөр үзэл санаатай байсан, харин энэ жишээн дээр бол манай засгийн газар бидний өмч хөрөнгийг бусдад зүгээр өгч байна.”

Кардинал Родригез, 2005 оны 5 дугаар сар

Гондурас бол дэлхийн бөмбөрцгийн баруун хэсэгт оршдог хамгийн ядуу буурай орны нэг юм. 1998 онд Митч хар салхинд сүйтгүүлж, гадаад өрд баригдсан тус улсын засгийн газар гаднаас хөрөнгө оруулалт татах үүднээс Уул уурхайн тухай хуулиа шинэчилсэн байна. Гэвч ихээхэн хэмжээний алт олборлолт тус улсын засгийн газарт буюу Гондурасын хүн амд бодитой орлого бий болгож өгөөгүй юм. Сүүлийн арав гаруй жил явуулсан уул уурхайн үйл ажиллагааны үр өгөөж байгаль орчин, ард иргэдэд учирсан нилээд их хэмжээний хохирлоос давж гарсан эсэх нь маш тодорхойгүй байна.

Алт олборлолтын ашгийг илүү шударгаар хуваарилдаг болоход ямар хэцүү байдгийг Гондурасын жишээ харуулж байна. Сүм хийдүүд, ард иргэдийн болон байгаль орчны бүлэглэлүүд, ТББ-ууд, хүний эрхийг дэмжигчид, орон нутгийн захиргаадыг нэгтгэсэн Иргэний Холбооноос энэ хуулийг өөрчилж, Гондурасын ард түмний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн кампанит ажил явуулж байна. Уул уурхайн салбар, засгийн газар, иргэний нийгмийнхэн харилцан буулт хийсэн зөвшилцлийн баримт бичиг гаргасан нь уул уурхайн компаниудын төлж буй татварыг нэмэгдүүлэх, байгаль орчны хяналт шинжилгээг сайжруулах арга

хэмжээ авах, нутгийн ард иргэд компаниудад үзүүлэх хөнгөлөлтийн талаар үзэл бодлоо илүү ихээр илэрхийлэх эрх олгох зэрэг асуудлыг тусгасан байна. Гэвч уг хуулийг шинэчлэх асуудал дахин дахин хойшилсоор байна. Тус Иргэний Холбоо 2004 оны сүүл үеэс өнөөг хүртэл шинэ концесс олгохыг түр зогсоох уриалгыг гаргаж амжилт олсон юм. Энэ хугацаанд Төв Америк-Домниканы Чөлөөт худалдааны гэрээ (CAFTA) хүчин төгөлдөр болсон тул АНУ, Канадын компаниуд шинэ концесс олгох шийдвэр гаргахыг хүлээж байгаа бөгөөд концесс олгосноор тус улс дахь алт олборлолтын цар хүрээ эрс нэмэгдэх юм.



Эх сурвалж: АНУ-ын ТТГ-ын Дэлхийн тоо баримтын тухай ном

Гондурас улс 112,492 хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, долоон сая орчим хүн амтай. Ихэнх гондурасчуудын хувьд ядуурал амьдралын бодит байдал болсон буюу хүн амын 64 хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, 44 хувь нь туйлын ядуу түвшнээс доогуур түвшинд амьдарч байна⁷⁵. Хүн амын арван хүн тутмын нэг нь цэвэр усаар хангагдаж чадахгүй байна.

Өөр нэг чухал асуудал бол тэгш бус байдал: Гондурасчуудын хамгийн баян 20 хувь нь үндэсний орлогынхоо бараг гуравны хоёрыг хүртэж байхад, хамгийн ядуу 20 хувьд нь 3 хүрэхгүй хувь нь ноогдож байна⁷⁶. 2002 онд Гондурас улс “авилгын хяналт” хэмээх засаглалын үзүүлэлтээр Төв Америкийн бүх улс дотроос сүүл барьж байв. Транспаренси Интернэшнл байгууллагын 2005 оны Авилгын ухамсрын индексээр Гондурас улс 158 орноос 106-д буюу Казахстан, Зимбабве улсуудтай ижил түвшинд байв⁷⁷.

Түүхийн хувьд тус улс маш өндөр хэмжээний өртэй явж ирсэн түүхтэй. 2003 онд тус улсын гадаад өр 5,641 сая ам.доллар буюу Үндэсний Нийт Орлого

(ҮНО)-ын 54 хувьд хүрч байв. Дэлхийн Банкнаас Их хэмжээний өртэй ядуу орнуудыг өргөтгөсөн санаачилгын дагуу чөлөөлөгдөх өрийн хэмжээ яваандаа 1 тэрбум ам. доллараас давах юм.

Гондурас дахь алт олборлолтын улс төрийн нөхцөл байдал

Хөрш Гватемал улсын нэг адил Гондурас улс олон зууны тэртээгээс алт олборлолтын уламжлалтай. Уурхайг гадаадынхан хяналтдаа авах явдал ч олон давтагддаг сэдэв болж ирсэн. XV зууны үед испаничууд нутгийн ард иргэдийг албадан алт олборлуулж байв. 1880-аад онд Хойд Америкийн бизнес эрхлэгчид Гондурас дахь олборлолтын ажиллагааг сэргээн явуулсан боловч тус улсад үлдэх олигтой ашиг байсангүй бөгөөд 1950-иад онд өндөр агууламжтай ордуудын нөөц шавхагдсан учраас алт олборлох ажиллагаа хумигдсан байна.

1980-аад оны үеэс алт олборлолтын ажиллагаа дахин арилжааны хувьд ашигтай болж иржээ. Овоо босгож цианидаар уусгах арга нэвтэрсэн нь бага агууламжтай ордуудаас алтыг харьцангуй хямд төсөр олборлох боломжтой болсон гэсэн үг. Энэ аргын нэг сул тал бол ил уурхай байгаль орчныг сүйтгэх уршигтай байдаг явдал юм. Ийм өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа нь бүхэл бүтэн уул нурууг эвдэхийн зэрэгцээ асар их хэмжээний ус шаарддаг байна. Мөн цианид ашиглах явдал өөрөө шинэ аюулууд бий болгодог учраас анхаарал болгоомжтой ажиллах шаардлагатай байдаг.

Олон янзын экспортын зүйлтэй Гондурас улс ашигт малтмалаас хамааралтай хөгжиж буй орон гэсэн ангилалд ордоггүй. Ашигт малтмал нь нийт экспортын багахан хувийг эзэлж байсан түүхтэй боловч 2000-2002 онд энэ хэмжээ өссөнийг дараахь хүснэгт харуулж байна⁷⁸. Гондурас улс алтнаас гадна бага хэмжээний цайр, мөнгө, цагаан алт, тугалга үйлдвэрлэдэг.


ГОНДУРАС: АШИГТ МАЛТМАЛЫН ЭКСПОРТЫН НИЙТ ЭКСПОРТОД ЭЗЛЭХ ХУВЬ

Сая ам.доллараар

	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Нийт экспорт	1763.1	1994.3	2211.0	2529.9	2383.3	2600.7	2517.5	2517.5
Ашигт малтмалын экспорт	47.4	44.1	64.9	47.3	59.3	72.4	113.5	117.5
Ашигт малтмалын нийт экспортод эзлэх хувь	2.7%	2.3%	2.9%	1.9%	2.5%	2.8%	4.5%	4.7%

2003 онд Гондурасын хамгийн чухал экспортын дөрөвдүгээрт алт орсон нь 80.5 сая ам. долларын хэмжээтэй байлаа⁷⁹. Гондурасын алтны ихэнх хувийг АНУ, Канадад экспортолдог байна.

Алтны экспорт, сая ам. доллараар



Эх сурвалж: Гондурасын Төв Банк, ОУВС

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зөрчилтэй хүрээ

Перу, Гана, Филиппин зэрэг эрдэс баялаг ихтэй хөгжиж байгаа олон орны нэг адил Гондурас улс гадаадын компаниудын хөрөнгө оруулалтыг татах үүднээс 1990-ээд онд Уул уурхайн тухай хуулиндаа өөрчлөлт оруулсан. 1998 онд тус улсын гадаад өр хэвийн хэмжээнээс хэтэрч, өмнөх олон арван жилийн хөгжлийн өдий төдий үр дүнг Митч хар салхинд сүйтгүүлсэн юм. Ингээд уг хар салхины дараахан буюу 1998 оны 12 дугаар сард уул уурхайн тухай шинэ хуулиа батлан гаргажээ. Ихэнх гондурасчууд гамшгийн дараахь хүндрэл бэрхшээлийг даван туулахаар дор бүрнээ оролдож байх зуур Уул уурхайн компаниудын холбоо (ANAMIMH) болон хараат бус зөвлөхүүдийн оролцоотой шинэ хуулийн төсөл боловсрогдсон байна. Үүний үр дүнд уг хууль олон улсын уул уурхайн компаниудад нилээд ашигтай тусч, нутгийн ард иргэд ба байгаль орчинд хохиролтой хууль болсон байна.

1998 оны Уул уурхайн тухай ерөнхий хуулийн гол элементүүд⁸⁰:

- Тус хуулинд **улсын хэмжээгээр бүхэлд нь** хайгуул, олборлолтын ажиллагаа явуулах боломж олгосон нь үндэсний хууль тогтоомжууд ба олон улсын конвенциудын эсрэгээр буюу ямар нэг чөлөөлөгдөх онцгой заалт ороогүй байна. Аялал жуулчлалын бүс, соёлын өв, оршин суух газар, экологийн нөөц газар, усны нөөцийн газрыг ч анхааран үзсэнгүй.
- Уг хуулинд уул уурхайн компаниудад, хөнгөлөлтийн гэрээнийхээ хүрээнд болон гадуур, **усыг чөлөөтэй ашиглах** эрх олгосон нь нутгийн ард иргэдийн усан хангамж урьд байгаагүй хэмжээгээр хомсдоход хүргэж байна.

- Уг хуулиар газрын эзэд нь татгалзаж байсан ч гэсэн **хувийн эзэмшлийн газарт орж ажиллах эрх** олгосон байна. Цаашилбал, хэрвээ уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулах эрхээ эдлэх боломжгүй буюу газар нутгийг эзэмших эрх авч чадахгүй бол тус газрыг ашиглаж, нийтийн хэрэгцээнд авах талаар шүүхэд хандан албадан хураалгаж болох ажээ. Эдгээр хоёр томъёолол нь хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, дэмжин баталгаажуулах тухай Үндсэн хуулийн 103 ба 106 дугаар заалтуудыг зөрчиж байна.
- Уг хуулиар аливаа хайгуулын ажлын эрх олгох шийдвэрийн төсөл Албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш нутгийн ард иргэд ба бусад сонирхогч талуудад **15 хоногийн дотор л эсэргүүцэл гаргах** эрх олгосон байна.
- **Татварын дэглэм** нь гадаадын уул уурхайн компаниудын сонирхлыг маш их татахуйц (дор үзнэ үү) болсон.
- Мөн уул уурхайг хөхиүлэн дэмжих үүрэгтэй засгийн газрын байгууллага болох DEFOMIN нь гэрээт талбай олгох болон байгаль орчны хяналт шинжилгээ явуулах эсэхийг шийдэх үүрэгтэй байдаг.

Уул уурхайн хуулийг илүү тэгш шударга болгохын төлөө кампанит ажил

1998 онд батлан гаргасан шинэ хууль гадны уул уурхайн компаниудыг татах тал дээр маш амжилттай байлаа. DEFOMIN-ий мэдээгээр, 1999 оны 10 дугаар сараас 2004 оны 5 дугаар сар хооронд АНУ, Канад, Итали, Гондурасаас гаралтай 10 өөр компанид уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх 82 эрх олгосон байна.

Засгийн газрын эрх бүхий байгууллагуудын хайхрамжгүй хандлагаас болж 2001 онд ард иргэдийн үймээн самуун, олныг хамарсан жагсаал цуглаан гарахад хүргэсэн байна. Үүнд оролцогчид тэдний эрхийг хүндэтгэж, Гондурасын Үндсэн хууль ба хууль тогтоомжуудыг мөрдөхийг шаарджээ. Эдгээр үйл явдал нь одоогийн уул уурхайн тухай хууль тогтоомжууд согогтой байна, ядаж зарим шинэчлэх арга хэмжээ авах шаардлагатай гэсэн үзэл газар авахад хүргэсэн байна. 2002 оны 5 дугаар сард тус улсын Конгресс, шаардлагатай гэж үзвэл 1998 оны хуулийг шинэчлэх талаар санал зөвлөмж гаргах зорилгоор уул уурхайн асуудлаар кампанит ажил явуулж буй байгууллагуудыг цуврал яриа хэлэлцүүлэгт урьж оролцуулсан байна.

Иргэний нийгмийн бүлгүүд нэгдэж **Аллианза Сивика** буюу Шинэчлэлийн төлөө Иргэний Холбоогоор дамжуулан үзэл бодлоо нэгтгэн гаргахаар болсон байна⁸¹. Тус Холбоо нь Католик шашны сүм хийд, байгаль орчны бүлгүүд, иргэдийн анхан шатны байгууллагуудтай нягт холбоотой ажилладаг төдийгүй засгийн газартай ажил төрлийн сайн харилцаатай байдаг. Тус холбооноос хүний болон хувь хүний

эрхийг хүндэтгэсэн, уурхайн концессийн эрх олгох эсэх тухай шийдвэрт өртөж хохирсон ард иргэдэд үгээ илүү ихээр хэлэх эрх олгосон, засгийн газрын дотоод хяналт, шалгалтыг илүүтэй оруулсан хууль гаргахыг уриалж, кампанит ажил явуулахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашигласан байна. Түүнчлэн хуулийн шинэчлэлийг хийж дуустал шинээр уурхайн үйл ажиллагааны эрх олгох ажлыг түр зогсоох шахалтыг амжилттай үзүүлж чадсан байна.

2004 оны 9 дүгээр сард Иргэний Холбоо уул уурхайн тухай хуулийг шинэчлэх төслийг Үндэсний Конгресст өргөн барьжээ. Олон сарын турш яриа хэлэлцээ хийсний эцэст буюу 2005 оны 1 дүгээр сард Иргэний Холбоо, уул уурхайн компаниуд (ANAMINH-аар төлөөлүүлсэн), засгийн газар (Defomin ба DECA-Байгаль орчны үнэлгээ, хяналтын газар ба хууль тогтоох комисс)-ын хооронд нэгдсэн байр сууринд хүрсэн байна. Үүгээр харилцан тохиролцсон зүйл заалтуудыг Диктамен хэмээх 26 хуудас баримт бичигт оруулсан байна. Ийнхүү алт олборлолтыг тойрсон маргаантай нөхцөл байдалд харилцан буулт хийсэн баримт бичиг гаргасан нь гол ололт амжилт юм. Одоо энэ баримт бичгийг Конгрессоор батлуулах ажил үлдсэн байна. Шинэчлэлийн төслийн хураангуйг дараагийн хуудаснаас үзнэ үү.

Хэдийгээр Диктамени агуулгыг бүх гол оролцогч талууд олон нийтийн өмнө хүлээн зөвшөөрсөн боловч хачирхалтай нь 2005 онд Уул уурхайн тухай хуулийг шинэчлэх төслийн явц зогсонги байдалд орсон юм. 2006 оны 1 дүгээр сард шинэ Засгийн газар төрийн эрхэнд гарав. Засгийн газар шинээр уул уурхайн эрх олгох ажлыг 2007 оны 2 дугаар сар хүртэл зогсоосон хэвээр байх тухай мэдэгдсэн боловч Уул уурхайн тухай хуульд арайхийж хийх болсон шинэчлэлүүдэд засвар өөрчлөлт оруулж эхэлсэн байна. Шинэ засгийн газрын байр сууриар бол Иргэний Холбоо шинэчлэлийн байр сууриа хамгаалахыг шаардаж байна. Гэтэл энэ нь олон оролцогч талууд хэлэлцээ хийсний үр дүнд бий болсон харилцан буултын баримт бичигт нэгэнт тусгагдчихаад байгаа зүйл юм. Улс төрийн маргаан мэтгэлцээн ч улам бүр туйлширч, ил уурхай ажиллуулахыг хориглох ч санал гарсан байна. Энэхүү номыг бичиж байх үед уг шинэчлэлийн төсөл Конгрессийн хоёр дахь хэлэлцүүлгийг (нийт гурван хэлэлцүүлгээс) давж гараад байлаа.

2005 оны 7 дугаар сард санал нэгдэж Диктамений баримт бичигт оруулсан уул уурхайн хуулийг шинэчлэх төслийн хураангуй

- Ард иргэд уул уурхайн үйл ажиллагааны эрх олгохыг эсэргүүцэж нэхэмжлэл гаргах хугацааг 15-аас 30 өдөр болгон нэмэгдүүлэх (шинэ концессийн төслийн тухай мэдээллийг радиогоор дамжуулах ёстой).
- Төлөх татварыг нэмэгдүүлэх. 1-2%-иар нэмэгдүүлэхийг санал болгосон. Үүний 1.5%-ийг орон нутгийн захиргаанд, 0.5%-ийг холбогдох орон нутгийн захиргааны нийгмийн хөрөнгө оруулалтын санд оруулна⁸².
- АМНОН буюу Гондурасын нутгийн захиргаадын холбоо уг нийгмийн хөрөнгө оруулалтын санг захиран зарцуулна.
- Ашиглалтын эрх олгохын өмнө ард иргэдийн өргөн хүрээнд зөвлөлдөх шаардлага: уурхайн үйл ажиллагаа явуулах эсэх тухай шийдвэрийг иргэдийн хурлуудаар (кабилдос абиертос) нээлттэй зөвлөлдөх замаар иргэдээр батлуулна.
- DECA ба Defomin-с хийж буй байгаль орчны хяналт ба дагалдах үйл ажиллагаануудад Орон нутгийн байгаль орчны нэгжүүд (UMA) оролцоно.
- Хүсэлт гаргагч компани уурхайгаас байгаль орчинд үзүүлэх нөлөөг хэрхэн багасгахыг заасан Уурхайг хаах төлөвлөгөөгөө анхнаас нь оруулж батлуулах шаардлагатай.
- Байгаль орчны нөлөөний үнэлгээнд ус ашиглалтын судалгааг оруулах шаардлагатай. Ундны ус ба ахуйн хэрэглээний усны тухай хуулинд заасны дагуу ус ашиглалтын шатлалын нэн тэргүүнд дотоодын хэрэглээний зарчмыг тавина.
- Хамгаалалттай газар нутгийн үндэсний системд орсон бүсүүд, эрх бүхий байгууллагаас усны хагалбар гэж заасан газрууд, аялал жуулчлалын зориулалттай гэж заасан бүсүүд ба далайн эргийн амралтын газрууд, байгаль орчны эрх бүхий байгууллагаас тодорхойлсон байгалийн орчны нөхөн сэргээлтийн бүсүүд, зохион байгуулалттайгаар хүн ам оршин сууж буй хот, суурин газрууд, мөн бусад хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу чөлөөлөгдсөн бүсүүдэд уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Эдгээр нь Гондурасын нутаг дэвсгэрийн 34 хүртэл хувийг эзэлж байна.
- Уул уурхайн үйл ажиллагаанд тавих байгаль орчны хяналтыг чангатгаж, учруулсан хохирлыг нөхөн төлөхөд зориулсан барьцааны сан байгуулах.
- Уул уурхайн үйл ажиллагааны эрх олгосон газрын ойр орчимд амьдардаг буюу түүний нөлөөнд өртөж буй өмч эзэмшигчдийн эрхийг илүү сайн хамгаалах.

CAFTA буюу ТАСХХ

Тус улсын уул уурхайн салбарын цаашдын хөгжилд шийдвэрлэх цаг үе тохиож байна. Энэ нь 2006 оны 4 дүгээр сарын 1-нд Төв Америк-Домниканы Чөлөөт Худалдааны Хэлэлцээр (ТАСХХ) хүчин төгөлдөр болсон явдал юм.

ТАСХХ нь АНУ-аас Эль Сальвадор, Никарагуа, Гватемал, Гондурас, Коста Рика, БН Домникан улсуудтай хийх худалдааг либеральчлахыг хөхиүлэн дэмждэг. Уг хэлэлцээрийн заалтын дагуу гадаадын хөрөнгө оруулагчид газрын тос олборлолт болон уул уурхайн гэрээ хэлцэлтэй холбоотой засгийн газрын сөрөг шийдвэрийн талаар эсэргүүцэл гаргах бололцоотой юм⁸³.

Энэ нь уул уурхайн салбарт байгаль орчны болон нийгмийн стандартуудыг сайжруулах талаар Гондурасын засгийн газрын цаашид эдлэх эрх мэдлийг нилээд хязгаарлаж болзошгүй. Мөн уул уурхайн компаниуд Уул уурхайн тухай шинэ хуулинд орох шинэ заалтуудыг өөрсдөд нь хамааруулахаас сэрэмжлэхийн тулд ТАСХХ-ийн гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах заалтуудыг өмнөө барьж болно.

Хойд Америкийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээр (НАФТА буюу ХАСХХ)-ийн 11 дүгээр бүлгийн нэг адил ТАСХХ-ийн заалтууд нь, тухайн улсын холбооны, мужийн, орон нутгийн засгийн газраас гадаадын компаний оруулсан хөрөнгийг шууд буюу шууд бусаар албадан хураасан гэж үзэж болох үйлдэл хийсэн гэдэг үндэслэлээр гадаадын компани үндэсний засгийн газрын эсрэг хохирлоо нөхүүлэх нэхэмжлэх гаргаж болно гэсэн агуулгатай байдаг. Иймд, жишээлбэл аливаа компани байгаль орчны зохицуулалтыг дагаж мөрдөх нь төслийг арилжааны хувьд ашиггүй болгож байна гэж үзвэл хөрөнгө оруулалтаа “албадан хураалгасан” гэж үзээд шүүхэд хандаж болно гэсэн үг⁸⁴.

ТАСХХ нь засгийн газруудын үндэсний хэмжээнд арга хэмжээ авах эрх чөлөөг хязгаарлахын зэрэгцээ байгаль орчны хамгаалалтыг өргөжүүлэх буюу сайжруулахад тус болдоггүй, улс орнууд зөвхөн одоо байгаа байгаль орчны тухай хуулиа мөрдөхийг шаарддаг бөгөөд энэ тал дээр Гондурас улсын хууль маш сул байгаа юм. Хөрөнгө оруулалтын холбогдолтой журам нь олон улсын хөрөнгө оруулагчдад илүү их хариуцлага ноогдуулдаггүй мөртлөө үндэсний засгийн газрууд иргэдийнхээ эрх ашгийн төлөө ажиллахад үнэхээр хэцүү болгодог⁸⁵.

Хамгийн санаа зовоож байгаа зүйл бол, Гондурас үйл ажиллагаа явуулж буй компаниудын нэг нь ХАСХХ-ийн 11 дүгээр бүлгийн заалтыг нэгэнт ашиглачихаад байгаа явдал юм. АНУ-ын засгийн газар Калифорнид нутгийн уугуул иргэдийн ариун дагшин газрыг ил уурхайн ажиллагаанаас хамгаалах арга хэмжээ авсантай холбогдуулан төслийн тооцоолсон ашгийн алдагдалд зориулж 50 сая ам. долларын нөхөн төлбөр олгох нэхэмжлэлийг Гламис Гоулд компани гаргаад байгаа. Энэ хэрэг одоо шийдэгдээгүй хэвээр байна.

Гондурас улсын Уул уурхайн тухай хуулийг тус улсын хөгжилд илүү их хувь нэмэр оруулж, хүн амын болон ирээдүй хойч үеийн эрх ашгийг илүү сайн илэрхийлэх байдлаар сайжруулах шаардлагатайг өргөнөөр хүлээн зөвшөөрч байгаа боловч

ТАЧХХ-ээр компаниудад илүү их эрх мэдэл олгох бодит аюул тулгарч байна. Парламентийн нэгэн гишүүний ярьснаар бол, ТАЧХХ-ийг соёрхон батлахад Гондурасын Конгресс хэдхэн өдөр зарсан төдийгүй тэдний дунд маш бага мэтгэлцээн өрнөсөн байна.

Гондураст ажиллаж буй алтны уурхайн компаниуд

Гондураст алт олборлож буй уул уурхайн компаниуд бүгд гадны өмчийн компани байна. Мөн шинээр концессийн эрх авахыг хүсч буй хэд хэдэн гадны өмчит компани бий. Тус салбарын худалдааны холбоо болох ANAMIMH 23 гишүүн компанитай бөгөөд тэдний зарим нь үйлчилгээ үзүүлдэг компани байна. Тэдгээрийн эх компаниуд АНУ, Канад, Италиас гаралтай байдаг⁸⁶. ANAMIMH холбоо гишүүдийнхээ үйл ажиллагааг аль болохоор нааштайгаар харуулахыг эрмэлзэж ажилладаг. Жишээлбэл, тус холбоо НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран Гондурасын хүүхдүүдэд зориулж уул уурхайн ашиг тусыг онцлон харуулж, байгаль орчинд үзүүлж болох эрсдлийг нь ойлгуулахад чиглэсэн ном гаргасан байна.

Одоогоор Гондураст алт олборлолтын гурван компани үйл ажиллагаа явуулж байна. АМРАС ч бас бага хэмжээний алт олборлодог боловч голлон цайр, тугалга олборлодог байна.

Хамгийн том ил уурхай бол Сириагийн хөндийд оршдог **Сан Мартиний уурхай** юм. Сан Мартиний уурхайг ашиглах эрхийг 1999 онд 20 жилийн хугацаатайгаар олгожээ. Энэ нь нийтдээ 14.100 га талбайг хамарсан арван хэсгээс бүрдэх бөгөөд үүний 349 га газрыг одоогоор ашиглаж байна. Сан Мартиний уурхайг Канад-АНУ-ын хамтарсан Гламис Гоулд компанийн 100 хувийн эзэмшилд байдаг Гондурасын салбар болох Ентре Марес компани ажиллуулдаг. Гламис Гоулд компани Невада, Мексик, Гватемал, Гондураст алтны уурхай ажиллуулдаг. Тус компани Гондураст 264,000 унц алтны батлагдсан болон болзошгүй нөөцтэй гэж мэдэгдээд байна⁸⁷.

Гламис компани 1999 онд үйл ажиллагаагаа эхэлснээс хойш 77 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. 2004 онд энэ уурхайгаас олсон орлого ойролцоогоор 42.8 сая ам. доллар, татварын өмнөх ашиг нь 12.7 сая ам. доллар байжээ⁸⁸. 2002 онд үйлдвэрлэл 129,000 унцаас давж оргил цэгтээ хүрсэн боловч 2006 онд Сан Мартиний уурхайгаас 81,000 унц орчим алт олборлоно гэж Гламисынхан үзсээр байна⁸⁹. 2004 онд Сан Мартинаас 102,152 унц алт үйлдвэрлэсэн байна. Алтны агууламж багатай байсны улмаас ганцхан унц алт гаргахын тулд олон тонн хад чулуу ухаж гаргах шаардлагатай байдаг. Ентре Марес компанид 218 хүн ажилладаг бөгөөд тэдний дийлэнх нь ойролцоох жижиг хот Сан Игнасиод амьдардаг.

Сан Андресийн уурхай бол Копаны харъяа Юнион хотын нутагт оршдог дунд зэргийн хэмжээтэй ил уурхай юм. Уурхай ашиглах эрхийг 1983 онд 40 жилийн хугацаатайгаар, 988.93 га газрыг хамруулан олгосон бөгөөд үүний 400-г нь ашиглаж байна. Сан Андресийг Канад, Гондурасын хамтарсан Минералес де Оксиденте (МИНОСА) компани ажиллуулдаг. 2004 оны 12 дугаар сард энэ уурхайг Канадын Торонтод төвтэй Ямана Гоулд компани худалдаж авчээ. Уг уурхайд 44.4 сая ам. долларын шууд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 2003 онд 18 сая ам. доллар орчмын орлоготой, үйлдвэрлэлийн зардал нь нэг унц алт тутамд 100-130 ам.доллар байсан байна. Үйлдвэрлэлийн хэмжээ нь сард 4000 орчим унц алт байдаг⁹⁰.

Церрос дел Сюр уурхайг АНУ-ын Маян Гоулд компани эзэмшдэг. Энд бага хэмжээний олборлолт явуулдаг бөгөөд DEFOMIN-ий Үндэсний уул уурхайн төлөвлөгөөний дагуу 2004 онд дөнгөж 41,650 ам. долларын хэмжээтэй алт экспортложээ. Церрос дел Сюр нь гүний далд уурхай бөгөөд ил уурхай болгон өөрчилж байгаа юм байна.

Гондурас дахь алт олборлолтын зардал, үр ашгийг тооцох нь

“Хүмүүс алтны уурхайг тэдэнд эд баялаг, хөгжил цэцэглэлт авчрах нэгэн зүйл гэж боддог байв.”

Карлос Амадор, Эль Порвенирийн багш, Сириагийн хөндий

Алт олборлолтын эдийн засгийн үр ашиг

Гондурасын эдийн засаг хөдөө аж ахуйгаас ихээхэн хамааралтай байдаг. Кофе, гадил жимс, далайн сам хорхойн экспорт алтныхаас ч илүү чухал үүрэгтэй. Төв Америкийн бусад орны нэг адил олон хүмүүс гадаадад ажиллаж буй гэр бүлийн гишүүдийнхээ илгээсэн мөнгөнд найдвар тавьдаг. АНУ-д ажиллаж буй гондурасчуудын гэр рүүгээ илгээдэг мөнгө тус улсын орлогын хамгийн том эх үүсвэр бөгөөд 2003 онд 862 сая ам. доллар хүрч байв⁹¹. Уул уурхай нь ажил эрхлэлт, татвар төлөлтөөс гадна компаниуд, тэдний ажилчдын худалдан авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт шууд бус үр шимээр дамжуулан эдийн засагт хувь нэмрээ оруулдаг. Гондурасын ард түмний хувьд гол тулгамдсан асуудал бол уурхай яг хэдий хэмжээний хувь нэмэр оруулж байна вэ, тэр нь нийгэмд ба байгаль орчинд учруулж буй багагүй хохирлоос давж чадаж байна уу гэдэг асуулт юм.

1. Ажил эрхлэлт

Тус улсад ажилгүйдэл бол ноцтой асуудлын нэг учраас уул уурхайн салбараас бий болгосон ажлын байр чухал ач холбогдолтой байдаг хэдий ч нийт тоо нь

харьцангуй бага юм. Үүнийг сайнаар бодоход л 1500 ажлын байр болох биз. Гэтэл аялал жуулчлалын салбар харьцангуй олон буюу 34000 ажлын байр бий болгож байна. Металл олборлолтын салбарын дундаж цалин өдөр тутмын цалингийн дунджаас өндөр буюу тус салбарт 87.9 лемпира (4.77 ам. доллар) байхад бусад салбарт өдрийн дундаж цалин 77.4 лемпира (4.2 ам. доллар) байдаг⁹². Энэ нь боомтын үйлчилгээ, гадил жимсний экспорт, санхүүгийн үйлчилгээний салбаруудтай ижил түвшин юм. Уул уурхайн салбар бүхэлдээ 2003 онд төлөгдсөн нийт цалин хөлс, нэмэгдэл урамшууллын дүнгийн дөнгөж нэг хүрэхгүй хувийг олгосон байна⁹³.

2. Татвар төлөлт

Уул уурхай нь хөгжиж байгаа орнуудад татварын нэмэлт орлого бүрдүүлдэг боловч юун түрүүнд гадны компаниудыг татан оруулах зорилготой санхүүгийн хөшүүрэг ашигласнаар энэхүү орлогын хэмжээ нилээд буурдаг. Гондурасын эрх бүхий байгууллагуудаас уул уурхайн бүрдүүлж буй татварын орлогын тоо баримтыг олж авах бараг боломжгүй байдаг.

Нэг сонирхолтой шинэ санаачилга бол Ентре Марес компани Сан Мартиний уурхайн гадна самбар байрлуулж, түүндээ тус компани үндэсний засгийн газарт, орон нутагт, мөн нийгмийн төслүүдэд зориулж хэдий хэр мөнгийг татварын хэлбэрээр төлснөө харуулсан байдаг. Энэхүү самбарыг уншихад тэр бүр амаргүй хэдий ч тус компани энэхүү тоо баримтыг, тодорхой задаргааны хамт хэвлэн нийтэлж байвал илүү тустай байх болно. Мөн нутгийн иргэд дээрх тоо баримтыг тодорхой хугацаагаар харьцуулан үзэх боломжтой он дараалсан тоо баримт байвал зүгээр.

Уул уурхайгаас Гондурасын улсын төсөвт оруулж буй хувь нэмэр харьцангуй бага юм. Үүний нэг шалтгаан бол өнөөгийн татварын дэглэмээр уул уурхайн компаниуд нилээд олон тооны хөнгөлөлт урамшуулал эдэлдэг явдал юм. Жишээлбэл, гадаадын пүүс компаниуд аж ахуйн нэгжийн орлогын татварын талаас бага хувийг төлдөг буюу татварын стандарт хувь 25 байхад гадаадын компаниуд дөнгөж 10 хувийг төлдөг байна⁹⁴. Нийт төлбөрийн тодорхой босго хэмжээнээс дээш 25%-н стандартыг ашигладаг. Уул уурхайн компаниуд борлуулалтын татвараас гадна импортын татвараас чөлөөлөгддөг. Орон нутгийн түвшинд бол нэг хувийн орон нутгийн борлуулалтын татварыг тухайн орон нутгийн захиргаанд төлдөг байна. Уул уурхайн тусгай зөвшөөрөл ба үйлдвэрлэлийн эрхийн төлбөрийг өгсөх шатлалаар тогтоодог бөгөөд уул уурхайн компаниуд ашиглалтын эрх авсан нэг га талбай тутамд жил бүр дараахь хураамжийг төлдөг:

Эхний дөрвөн жилд га тутамд 0.25 ам. доллар
Тав, зургаа дахь жилд 0.75 ам. доллар
Долоо, найм дахь жилд 1.50 ам. доллар
Ес дэх жилд 3.00 ам. доллар⁹⁵.

Иргэний Холбооны гаргасан тооцоогоор, Гондурас улс санхүүгийн хувьд хожихоосоо илүү татварын орчны өөрчлөлт, 1998 оны уул уурхайн хуулиасаа болж жил тутамд 32 сая лемпирагийн (ойролцоогоор 1.8 сая ам.доллар) алдагдал хүлээдэг байна. Одоо төлж байгаа татварын бодит хэмжээ өмнө нь төлж байсныхаа дөнгөж гуравны нэгтэй тэнцэж байна гэж Иргэний Холбооныхон тооцоолсон байна⁹⁶.

Түүнчлэн компаниуд төв засгийн газарт төлөх татвараасаа уурхай байгуулахад гарсан зардлаа суутган авч болдог. Жишээлбэл, 2004 онд Гламис Гоулд компани 10 сая ам. доллар орчмын татварын өрөө хойшлуулжээ. Тус уурхайн үйл ажиллагаа дуусахад дөрөвхөн жилийн хугацаа үлдээд байхад энэ мөнгөө хэзээ, хэрхэн төлөх, төлөх эсэх нь тодорхойгүй байна. Манай компани хүлээсэн бүх үүргээ биелүүлж, 130 сая лемпирагаас дээш татвар төлөхөөс нааш тус улсыг орхиж явахгүй гэж энэ компанийхан мэдэгдээд байна⁹⁷.

Мөн тус компани Сан Мартиний уурхайг ашиглах эрхээ 30 сая ам. доллараар Гламис Гоулд компаний Барбадост төвтэй өөр нэг салбар болох Олон Улсын Эрдэс Баялгийн Санхүүгийн Корпорацид барьцаалуулсан байна.

3. Нутгийн ард иргэдэд зориулсан хөгжлийн төслүүд

Энтре Марес компани уурхайн эргэн тойрны газар нутагт нийгмийн хөгжлийн төслүүд хэрэгжүүлэхэд зориулсан сан байгуулжээ. Тус компани Сан Мартиний эргэн тойрон дахь сургууль, сургалтын тэтгэлэг, эрүүл мэнд, эмийн сангийн үйлчилгээ гэх мэт нийгмийн төслүүдэд жил бүр 1.5 сая лемпира (ойролцоогоор 80.000 ам.доллар) зарцуулдаг. Мөн Сан Игнасио хотын захиргаа ч энэ компаний төлсөн нэг хувийн борлуулалтын татварын үр шимийг хүртэж байна. Харин түүний эргэн тойронд буй орон нутгийн захиргаад ямар нэг татвар авдаггүй.

1998 оноос өмнөх хуучин Уул уурхайн тухай хуулиар бол уул уурхайн компаниуд нийгмийн эрүүл мэнд, боловсролын тодорхой төслүүдийг хариуцан хэрэгжүүлж, үйл ажиллагаа явуулж буй газрынхаа ард иргэдийн хөгжилд хувь нэмрээ оруулах шаардлагатай байв. Одоо бол компаниуд ийм үүрэг хүлээхээ больсон бөгөөд нийгмийн хөгжлийн төслүүдийг гагцхүү сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг⁹⁸.

Гондурас дахь алт олборлолтын байгаль орчны болон нийгмийн зардлууд

1. Усны хомсдол

Ил уурхайд асар их хэмжээний ус ашигладаг, иймээс ус ашиглалтын асуудал Гондурасын уул уурхайн бүсийн эргэн тойронд үүссэн маргааны гол цэг болоод байгаад гайхах зүйлгүй.

Сан Мартиний уурхайг барьж байгуулах явцад Ентре Марес компани өдөрт 60000 галлон ус ашиглаж байв. Уул уурхайн тухай ерөнхий хуульд концессийн нутаг дэвсгэрийн доторхи болон түүний гаднах усыг ашиглаж болохоор заасан учраас энэ нь уурхайн хамт олны эрх ашигт хохирол учруулахгүй. 2000 онд Байгаль орчны Омбудсмэний Газраас явуулсан техникийн судалгаагаар орон нутгийн Агуа Тибиа голд далан байгуулсан нь нутгийн иргэд малаа услахад хүндрэлтэй болсныг тогтоожээ. Мөн барилгын ажлын зорилгоор Плая голын сав газраас 30.000 шоо метр элс олборлосон нь усны болон газар дээрх амьдралд хор хохирол учруулж, гол усны гольдрол алдагдахад хүрсэн байна. Тэр ч байтугай уурхайн үйл ажиллагаа эхлэхээс ч өмнө Сириагийн хөндийд хуурай улиралд (2-6 дугаар сар) усны ноцтой хомсдол үүсдэг байсан нь тэнд хур тунадас маш бага унадагтай холбоотой байв. 2002 онд усны хомсдол бүр ихсэх үед Ентре Марес компани зэргэлдээх хөндийн хувийн эзэмшлээс нэг галлон усыг 19 лемпирагаар худалдаж авахад хүрч байлаа⁹⁹.

Сириагийн хөндийд амьдардаг тосгоныхон усны эх үүсвэрүүд ширгэж байгаа тухай мэдээлж байна. Хүмүүс одоо өөрсөдөө болон малдаа зориулж ус худалдан авах шаардлагатай болжээ. Компаниас хэд хэдэн худаг гаргаж, усан сан байгуулж өгсөн боловч гурван худаг нь хаагдах болсон байна. Эдгээр худгаас гарч буй усанд хүнцэл агуулагдаж буй нь тогтоогдсон учраас хүний хэрэглээнд ашиглаж болохгүй ажээ.

2. Цианид ба хүнцэлийн бохирдуулалт

Гондураст уурхайгаас үүдсэн цианидтай холбоотой хэд хэдэн осол гараад байна. 2003 оны 1 дүгээр сарын 6-нд Минералес де Оксиденте (МИНОСА) компанийн ажиллуулдаг Сан Андрегийн уурхайд гарсан ослоор 300 галлон гаруй цианидийн хорт уусмал алдагдаж ойролцоох нутгийн ард иргэдийн хүнс, усны хэрэгцээг хангадаг Лара голд урсан орсон байна¹⁰⁰. Үүнээс болж 18.000 загас үхсэн тооцоо байдаг. Мөн Эль Мочитогийн цайр, тугалганы уурхайгаас бохир ус алдагдснаас уснаас болон загаснаас хүнд металлын үлдэгдэл илэрснийг Бохирдлын судалгаа, хяналтын төвийнхөн тогтоожээ. Тус төвөөс явуулсан өөр нэг судалгаанд Сан Андрегийн уурхайн хаягдал устай холбоотой асуудал илрүүлжээ. Уг хаягдал уснаас гурван жил хүрэхгүй хугацаанд зургаа, долоон удаа авсан шинжилгээгээр гол мөрний системийг бохирдуулахуйц хэмжээний цианид илэрсэн байна¹⁰¹.

2003 оны 11 дүгээр сард Сан Мартиний уурхайн эргэн тойрны усны бохирдлын судалгааг Тегусигалпагийн дүүргийн Каритас байгууллага Ентре Марес компанитай хамтран явуулжээ. Судалгаагаар хүнцэлтэй холбоотой асуудал илэрсэн байна. Хүнцэл нь алт агуулсан хатуу чулуулагт олонтаа илэрдэг бөгөөд уурхайн үйл ажиллагааны үр дүнд ялгарч болдог. Гондурас улсын болон Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын стандартаар аюулгүй ундны усанд байж болох хүнцэлийн агууламжийн дээд хэмжээ литр тутамд 0.01 микрограмм (мг/л) байдаг. Сан Мартиний уурхайн хоёр өөр газар хийсэн шинжилгээгээр энэ хэмжээ 0.02 мг/л ба 0.0223 мг/л буюу зөвшөөрөгдөх түвшнээс наад зах нь 0.01 мг/л-р илүү байгаа нь тогтоогдсон байна¹⁰². Харин ийнхүү хүнцэл илэрсэн нь тухайн газрын байгалийн геологийн онцлогтой холбоотой гэж тус компанийхан мэдэгджээ.

Хамгийн сүүлд 2005 оны 12 дугаар сард DEFOMIN-ий хийсэн шалгалтаар Сан Мартиний уурхай орчмын усанд цианидийн түвшин аюултай хэмжээнд хүрснийг тогтоосон байна. Уурхайн талбай дундуур урсдаг Гуажиниквилийн горхи болон боловруулсан хаягдал ус хадгалдаг тойрмоос дээж авч шинжлэхэд тус тус 2.11 ба 3.71 нэгж/сая (ppm) хэмжээний цианид илэрсэн байна. Энэхүү шинжилгээний хүчин төгөлдөр эсэхтэй тус компани маргасаар байна. Уг цөөрөм нь уурхай дотор буюу уурхайн хилийн дагуу оршдог бөгөөд бусад цөөрөмтэй адилгүй нь усны хамгаалалтын шугамгүй ажээ. Цөөрөмд ямар нэг хашаа, хаалт байхгүй учраас хүрээлэн буй экологийн систем ба тус газрын байгалийн усны системийн нэг хэсэг болж байгаа юм. Эдгээр цианидийн түвшин нь Гондурасын норм 0.05 ppm хэмжээнээс дөрөв дахин их бөгөөд цианидийн хэмжээ энэ нормоос их бол байгаль орчинд аюултай болдог байна¹⁰³. Гуанжиниквили горхи Плая голд цутгадаг бөгөөд эндээс урссан усыг мал услах, хувцас угаах, тариан талбай услахад ашигладаг байна.

Нутгийн ард иргэд усан хангамжийн талаар ихээхэн санаа зовж, айдаст автаж байна¹⁰⁴. Энэ асуудлыг шийдэхийн тулд усны хэмжээ, чанарыг тогтмол, системтэйгээр шинжлэх бодит шаардлага гарч байна. Мөн олж авсан мэдээллийг нутгийн ард иргэдтэй хүртээмжтэй байдлаар хуваалцах ёстой.

Засгийн газарт хууль тогтоомж, зохицуулалтуудыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх чадавхи ихээхэн дутагдах бэрхшээлтэй тулгарч байна гэж DEFOMIN олон нийтэд мэдэгдээд байна¹⁰⁵. Байгаль орчны болон төсвийн стандартыг сахиулах үүрэгтэй засгийн газрын байгууллагуудын техникийн чадавхийг бэхжүүлэх хөрөнгө санхүү хойшлуулшгүй шаардлагатай байна. Үүний зэрэгцээ уул уурхайн компаниуд нутгийн иргэдтэй мэдээллээ хуваалцаж, тэдэнд байдлыг шууд тайлагнаж байх ёстой.

3. Хөдөө аж ахуйн газар нутгийн хомсдол ба ой модны сүйтгэл

Сан Мартиний уурхай Сириагийн хөндийн өргөн уудам газар нутгийг сүйтгэж байна. Тус бүс нутгийн ард түмний амьжиргааны гол эх үүсвэр нь хөдөө аж ахуй юм. 2003 онд хийсэн нийгэм, эдийн засгийн судалгаагаар тухайн үеийн нөхцөл

байдлыг 1993 оны суурь үзүүлэлттэй харьцуулах замаар Ентре Маресийн хөдөө аж ахуйд үзүүлсэн нөлөөг тооцож гаргасан байна. Судалгаанаас үзэхэд тариалангийн газар нутгийн хэмжээ (2003 онд) 1993 оны түвшнээс хамаагүй багассан байна. Энд эрдэнэ шиш, шошийн бусад төрлийн ургацыг хамруулсан бөгөөд хамгийн сайндаа (майцилло асоциадо сортын эрдэнэ шишийн хувьд) өмнө нь тариалж байсныхаа дөнгөж 38 хувьд тариалж байв. Хамгийн муу тохиолдол гэхэд урьд нь тариалж байсан талбайнхаа дөнгөж 2-3 хувьд тариалсан байна¹⁰⁶. Тус бүс нутгийн малын тоо толгойг 114 аж ахуйг (мал аж ахуй эрхэлдэг нийт аж ахуйн 13 хувийг төлөөлсөн) хамруулан судалхад 14.274-өөс 10.908 болж 24 хувиар буурсан байна¹⁰⁷. Уг уурхайг байгуулах үед гадна талбайг засах зорилгоор 1000-2000 мод тайрч унагасан байна. Мөн угийн хуурай энэ газарт ус хомсдож, хөрс элэгдэхийн хэрээр ой мод сүйдэж байна.

“Миний газар уурхайд ойрхон байдаг. Тэднийг хөрс хуулж эхэлмэгц элс нурж миний газрыг бүхэлд нь бүрхсэн. Би малын тэжээлд зориулж чихрийн нишингэ тарьдаг. Бороо орох бүр тэд машинаа авчран ажиллуулж дээрх явдал давтагддаг. Би хэдэн үнээгээ өөрийнхөө газар дээр бэлчээж чадахгүй байгаа. Манай газар бүхэлдээ элсэнд дарагдчихсан, уурхайн компани түүнийг цэвэрлэж өгдөг. Бусад олон хүн ийм байдалд автсан. Бид эсэргүүцэн тэмцсэн боловч энэ удаад бүр дордоод байна. Уурхай хаана л байна, түүний орчин тойрны газар нутгийг сүйтгэдэг юм байна. Ийм муу үр дагавартай байна гэж бид ерөөсөө төсөөлөөгүй юм байна.”

Арнулфо Веласквез, Сириагийн хөндийн малчин

Уурхайн газар нутагт амьдардаг хүмүүст тулгардаг нэг том асуудал бол алтны нөөц дуусч, компани яваад өгөхөөр яах вэ гэдэг асуудал юм. Ялангуяа уурхайн ашиглалтын хугацаа нь дуусах дөхөж байгаа Гламисийн эзэмшдэг Сан Мартиний уурхайд энэ асуудал ихээхэн холбоотой. Нөхөн сэргээлтийн ажлыг хэр амжилттай явагдаж байгаа тухай ойлголт өөр өөр байна. Тус компани 22000 гаруй мод тарьсан байна. Гламис Гоулдын мэдээлж байгаагаар, “Гондурас дахь Сан Мартиний уурхайд ухсан Роза цооногийн нөхөн сэргээлт туйлын амжилттай явагдаж байна.”¹⁰⁸ Гэвч орон нутгийн Байгаль орчны хороо энэ үнэлгээтэй санал нийлэхгүй байна. Ентре Марес компани Сириагийн хөндийд уурхай ажиллуулж дуусахын цагт цаашид амьдрах чадвартай эдийн засгийн стратеги боловсруулж, ард иргэдийг татан оролцуулах хойшлуулушгүй шаардлага тавигдаж байна.

4. Ард иргэдийн нүүлгэн шилжүүлэлт

“Гондураст... Гламис компани нутгийн ард иргэдтэй нягт хамтран ажиллаж, төсөл боловсруулалтын бүхий л шатанд тэднийг татан оролцуулахад чиглэсэн арга барилыг амжилттай боловсруулаад байна. Энэ туршлагад тулгуурласан мэдлэг нь тус компани хожим нь Мексикт Эль Саузальн уурхайг ашиглах, Гватемалд Марлины төслийг хэрэгжүүлэхэд сайн нөлөө үзүүлсэн юм.”¹⁰⁹

Цэвэр алт, Баттай өсөлт,
Гламис Гоулдын 2004 оны жилийн тайлан

Сан Андрес болон Сан Мартиний алтны уурхайг байгуулахын тулд хэд хэдэн нутгийн ард иргэдийг нүүлгэн шилжүүлсэн. Эдийн засаг, нийгмийн эрхийн төвөөс явуулсан судалгаагаар Сан Андрес амьдарч байсан хүмүүст засгийн газраас нүүлгэн шилжүүлэх дарамт шахалт үзүүлж, уурхайн компанийг эсэргүүцэх боломжгүй байсныг тогтоосон байна¹¹⁰.

Сан Мартиний уурхайн талбайг чөлөөлөхийн тулд Пало Рамос хэмээх жижиг тосгоныг нүүлгэжээ. Энд байсан 14 айлыг уурхайгаас 900 метрийн зайд ижил нэртэй тосгон байгуулж шилжүүлэн суурьшуулсан байна. Ард иргэдийн үзэл бодол хуваагдсан бөгөөд зарим хүмүүс шинэ гэр орондоо сэтгэл ханамжтай байхад, зарим нь энэ нүүдэлд сэтгэл дундуур, шинэ гэр орноо стандартын шаардлага хангахгүй гэж үзэж байна. Нүүлгэн шилжүүлснээс хойш таван жил өнгөрөөд байхад зарим айл Энтре Маресаас авсан шинэ газар, байшингийнхаа хууль ёсны эзэмших эрхийг одоо хүртэл аваагүй байна. Явж явж тус компаниас газар эзэмших эрхээ авсан айлууд гэрчилгээ нь алдаатай, тухайлбал нэр, үнэмлэхийн дугаарыг буруу бичсэн байгааг олж мэдсэн нь эрх зүйн хувьд хүчин төгөлдөр байдлыг нь алдагдуулах вий гэсэн айдас төрүүлж байна. Одоо тэдэнд зохих хууль ёсны эрхийг нь олгох талаар орон нутгийн кампанит ажил явагдаж байна.

Диктаменд дурдсан асуудлуудыг иргэдийн нээлттэй хурлаар хэлэлцүүлж, уул уурхайн ашиглалтын эрх олгох шийдвэрт нутгийн ард иргэд үгээ илүү их хэлэх боломж олгох бодит шаардлага тавигдаж байна. Уурхайн лиценз олгохоос өмнө иргэдийг оролцуулж, буурьтай зөвлөлдөх явдал дутагдаж байгаа талаар Эль Порвенир, Сан Игнасио, Сан Андресийн ард иргэдийн төлөөлөгчид бүгд л гомдол гаргажээ¹¹¹. Үүний зэрэгцээ нутгийн ард иргэд боловсрол муутай учраас уул уурхайн шийдвэрийн талаар тэдэнтэй зөвлөлдөх нь зохисгүй гэж үзэж байгаагаа DEFOMIN-ий ажилтнууд мэдэгдсэн байна¹¹².

Ийнхүү ард иргэдийн туршлагаас үзэхэд одоогийн хуулиар уурхай ашиглах эрх олгох явдал учир дутагдалтай байгаа нь харагдаж байна. Уурхайн лиценз авах хүсэлтийг албан ёсны сэтгүүлд хэвлэн нийтлэдэг ч тэр нь Сан Андресийн ард түмэнд очдоггүй, албан ёсоор эсэргүүцэл гаргахад зориулж дөнгөж

15-хан өдрийн хугацаа өгсөн байдаг ажээ. Түүнчлэн, Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээ гэх мэт мэдээллийн гол эх сурвалжийг олон нийтэд танилцуулдаггүйд ард иргэдийн төлөөлөгчид сэтгэл зовниж байв¹¹³.

5. Ард иргэдийн доторх зөрчилдөөн

Гондурас дахь уул уурхайн ажиллагаа ард иргэдийг хагалан хувааж байна. Уурхай ажилласны үр шимийг хүртэж, ихэвчлэн шууд ажлаар хангагдсан цөөн тооны хүмүүс болон тэгж чадаагүй хүмүүсийн хооронд бодитой хагарал үүсчээ. Жишээлбэл, Сан Игнасиогийн ард иргэдийн Сан Мартиний уурхайтай ойр байдаг зарим хүмүүс уг уурхай нээгдсэнээс хойш дэлгүүр хоршооны тоо нэмэгдсэн ч архидан согтуурах явдал давхар нэмэгдсэн гэжээ. Мөн тус хотод ирэх шилжин суурьшилт нэмэгдсэнээр орон сууц, барилгын үнэ өртөг өссөн байна¹¹⁴.

Өөр нэг маргаантай асуудал бол орон нутгийн татварыг зөвхөн Сан Игнасио хотын захиргаанд төлж байгаа явдал юм. Хөрш Порвенир хотын ард иргэд үнэндээ уг уурхайтай илүү ойр амьдардаг, түүний нөлөөнд илүү их өртдөг боловч засаг захиргааны хил хязгаараас болж Порвенир хотын захиргаа уурхайгаас ямар нэг татварын орлого авдаггүй байна.

Иргэний Холбооноос 2003 онд нутгийн ард иргэдийн дунд санал асуулга явуулжээ.

Асуулт: Танай хотын нутаг дэвсгэрт уул уурхайн компани бий болж, уурхай ажиллуулж байгааг юу гэж үздэг вэ?

	Тоо	Хувь
Хөгжлийн үндэс суурь мөн үү?	11	7.4%
Зарим үр өгөөж өгдөг үү?	13	8.8%
Үр өгөөжөөсөө илүү хор хохирол учруулдаг уу?	26	17.6%
Ихээхэн хор хохиролтой юу?	97	65.5%
Мэдэхгүй буюу хариулаагүй	1	0.7%
Нийт дүн	148	100.0%

Эх сурвалж: Иргэний Холбооны тайлан, Хүснэгт 11, х. 12

- Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 89.9 хувь нь байгаль орчны бохирдлын асуудал ард иргэдэд аюул занал учруулж байна гэж үздэгээ илэрхийлжээ¹¹⁵.
- Агаарын болон усны бохирдлын асуудлыг хамгийн хүнд ноцтойд тооцсон бөгөөд өөр нэг хүчин зүйл нь дуу чимээ байв.

Зарим тохиолдолд санал зөрөлдөөнтэй байдал хүчирхийлэл болон хувирч байна. Уул уурхайн байгаль орчинд учруулах хохирлын талаар ярьсан нутгийн нэг санваартан түүний амийг хөнөөхөөр хэд хэдэн удаа заналхийлсэн гэж мэдэгджээ. 2006 оны 2 дугаар сард Церрос дел Сюр далд уурхайг ил уурхай болгосон нь уурхайчид ба нутгийн иргэдийн хооронд зөрчилдөөнд гал нэмсэн байна.

Санал зөвлөмжүүд

- Уул уурхайн тухай хуулийн төслийн харилцан тохиролцсон баримт бичгийг аль болох хурдан, мэдээж шинээр ямар нэг эрх олгохоос өмнө батлан гаргах талаар бүх талууд, засгийн газар, парламентчид, иргэний нийгэм, уул уурхайн салбар хамтран ажиллах ёстой.
- Шинэ хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгийг засгийн газраас үндэсний болон нутгийн захиргааны байгууллагуудад хуваарилах ёстой.
- Алт олборлолтын боломжит өртөг зардал, үр өгөөжийн талаар тодорхой мэдээллийг хүн амд өгөх ёстой. Уул уурхайн компаниуд Гондураст явуулж буй үйл ажиллагаатайгаа холбоотой бүх талын холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь зохих ёсоор гаргаж өгөх ёстой. Үүнд: бүх төлсөн татвар, байгаль орчинд болон эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний тоо баримт, судалгаанууд, мөн гэнэтийн ослын төлөвлөгөө, байгаль орчинд үзүүлэх нөлөөг багасгах төлөвлөгөө, уурхайг хаах төлөвлөгөө гэх мэт компаний үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд орно.
- Диктаменд засгийн газар, иргэний нийгэм, уул уурхайн компаниудын харилцан тохирсон ард иргэдтэй нээлттэй зөвлөлдөх зарчмыг Гламис болон уул уурхайн бусад компани дэмжих ёстой. Хайгуулаас эхлээд хаах хүртэлх үйл явцын үе шат бүрт гаргаж буй шийдвэрийн талаар ард иргэдэд мэдээлж, тэднийг оролцуулах ёстой. Энэ нь ялангуяа ашиглалтын хугацаа нь дуусах дөхөж буй Сан Мартиний уурхайд илүү хамаатай.
- Алтны уурхайн дотор буюу эргэн тойронд буй усанд хараат бус мэргэжилтнүүд хяналт шинжилгээ хийж байх ёстой. Хэрэв тухайн компани уурхайд нэвтрэх эрх олгож байвал тэдний зүгээс үнэнчээр ажиллаж байгаагаа харуулах жишээ болох юм. Үүнийгээ бататгаж ус, хөрс, агаар, ойн нөхцөл байдал, чанарын талаар тогтмол тайлан гаргаж нийтэлдэг байх шаардлагатай. Орон нутгийн захиргаа ба компаний аль алиных нь зүгээс тухайн газар нутагт амьдарч буй хүмүүст мэдээлэл хүрч байгааг баталгаажуулах зохистой арга замыг олж хэрэгжүүлэх хэрэгтэй.

Бүлэг 5

Жишээ судлал: Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь алтны хясланг арилгах нь

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс “нөөцийн хяслан”-гийн төгс жишээ болж байна. Хэдийгээр тус улс эрдэс баялаг, очир алмааз, газрын тосоор баян боловч ард түмэн нь байгалийн арвин баялгийнхаа үр шимийг бараг үзээгүй байна. Энэ жишээнд БНАКУ-ын зүүн хойд хэсэгт орших нэгэн газар ашигт малтмалын илрэлд олборлолт явуулж газар нутгийг эвдэн сүйтгэж байгаа талаар авч үзнэ. Өмнөд Африкийн АнглоГолд Ашанти хэмээх уул уурхайн компани Итури дүүргийн алт ихтэй бүс нутаг Монгбуалуд орд газар ашиглах хайгуул хийж байна. Тус компаний өгөх үр ашгийн талаар нутгийн хүн ам их юм горьдож байдаг. Энэ компани хэрвээ эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжиж, цаашдын зөрчил мөргөлдөөнөөс зайлсхийе гэвэл нутгийн ард иргэдтэй хамтран ажиллаж, тэдний үзэл бодлыг тусгах дэс дараатай стратеги баримтлах нь онцгой чухал юм.

“Бид бүхний хувьд энд хичнээн их алт үйлдвэрлэж байгааг болон Монгбуалугийн нийт ард иргэдийн амьдрал ямар хүнд хэцүү байгааг харахад сэтгэл өвдөм байдаг. Ийм их алт өгч буй уурхайнуудынхаа үр шимийг ард иргэд хүртэх ёстой.”

Монсайнор Диюдонне Уринги Уучи, Буниагийн хамба лам

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ) Баруун Европын газар нутагтай тэнцэх хэмжээний нутаг дэвсгэртэй, дөнгөж 60.1 сая хүн амтай. Зэс, очир алмааз, алт, газрын тос болон бусад ашигт малтмалаар баян гэдгийг нь эс тооцвол дэлхийн хамгийн ядуу буурай орны нэг юм. Хүн амын дундаж наслалт 2005 онд 51 нас байсан бөгөөд таваас доош насны хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдлын хувь 30 хүрээд байна. Зөрчил мөргөлдөөнтэй холбоотой шалтгаанууд, түүний дотор халдварт өвчин, өлсгөлөн, хүчирхийллийн улмаас өдөрт 1200 хүн нас барж байгаа тооцоо гарч байна¹¹⁶.

БНАКУ дахь уул уурхайн улс төрийн нөхцөл байдал

БНАКУ Африк тивийн томоохон зөрчил мөргөлдөөний төв болж ирсэн. 1998-2003 онд Ангол, Намиби, Зимбабве улсуудын дэмжлэгтэй БНАКУ-ын засгийн газрын хүчнийхэн Уганда, Руанда, Бурундигийн босогчидтой тэмцсэн цуврал дайнд 4 сая хүн амь үрэгдсэн гэсэн тоо гарчээ. “БНАКУ дахь зөрчил мөргөлдөөнийг даамжруулж, тус улсын эдийн засгийн хөгжилд саад учруулан, Конгийн ард түмний зовлон зүдүүрийг хурцатгах”-д байгалийн баялгийг нь цөлмөн дээрэмдэх явдлын гүйцэтгэж буй үүргийг НҮБ хүлээн зөвшөөрсөн байдаг¹¹⁷. Хэдийгээр энхийн тохиролцоонд хүрч, 2003 оны 6 дугаар сард шилжилтийн засгийн газар байгуулагдсан хэдий ч иргэний дайн дэгдэх аюул хэвээр байна. Тус улсын зах хязгаарын алслагдмал нутгуудад зэвсэгт дайчид, бусад зэвсэгт бүлэглэлүүд, гадаадын босогчид үйл ажиллагаа явуулсаар байна.

Уул уурхайн салбарыг сэргээх оролдлогууд

Албан ёсны уул уурхайн салбар эрс уналтад ороход дайн, хөрөнгө оруулалтын хомсдол, зохисгүй удирдлага, засаг захиргааны задран уналт зэрэг хүчин зүйлс бүгд хувь нэмрээ оруулсан. 2004 онд уул уурхай болон эрдэс баялгийн боловсруулалт ДНБ-ий дөнгөж 8.7 хувийг хангаж байв. Энэ нь тус улсын экспортын дөрөвний гурав, төсвийн орлогын дөрөвний нэг, мөн ДНБ-ий дөрөвний нэг хувийг уул уурхай эзэлж байсан 1985 оны нөхцөл байдлаас асар их ялгаатай байна¹¹⁸. Түүнчлэн зөрчил мөргөлдөөнөөс үүдэн албан бус олборлолт нэмэгдсэн бөгөөд үүнийг ядарч цөхөрсөн хувь хүмүүс гэр бүлээ тэжээх арга зам болгож байсан бол цэргийнхэн уурхайг хяналтдаа байлгахын тулд албадан хөдөлмөрлүүлэх замаар олборлолт явуулах нь олонтаа байв. Одоо бага хэмжээний олборлолт явуулахад олон зуун мянган хүн оролцож байгаа нь ихэнхидээ юу ч тохиолдож болзошгүй, аюултай нөхцөлд ажиллаж байна¹¹⁹. ОУВС-гийн тооцоогоор, БНАКУ-ын хүн амын 20 орчим хувь нь гар аргаар очир алмааз, алт, колтан, касситерит болон бусад ашигт малтмал олборлон амь зууж байгаа ажээ¹²⁰.


Засгийн газарт нь уул уурхайгаас олох орлогыг нэмэгдүүлэх хүнд сорилт нүүрлээд байна.

Шударга ёс тогтооцгооё


БНАКУ Уул уурхайн хуулиа 2002 онд Дэлхийн Банкны ивээл дор шинэчилсэн боловч түүнийг бодитойгоор даган мөрдөж байгаа цар хүрээний асуудал санаа зовоож байгаа төдийгүй үндэсний засгийн газрын хяналтад үлдээд байгаа газар нутагт хүртэл байдал хүндрэлтэй байна.

Албан ёсны тоо баримтаас үзэхэд БНАКУ-аас экспортолж байгаа алтны хэмжээ буурсан (дор үзнэ үү) нь харагдаж байгаа боловч тус улсаас алтыг хулгайгаар хил давуулж байгаагаас болж багагүй хэмжээний орлогоо алдаж байгаа нь тодорхой юм. 2003 онд Конгоос гаралтай 60 сая ам. долларын алтыг хөрш Уганда улсаас экспортолсон дүн гарчээ¹²¹.

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь ашигт малтмалын гол ордууд



© Хүний Эрхийн Манаа, “Алтны гай”, 2005

БНАКУ-ын алтны үйлдвэрлэл (тонноор)

Эх сурвалж: GFMS Алтны судалгаа, 2005 он

Зөрчилдөөн үүсгэгч өөр нэг эх сурвалж бол ашигт малтмал ашиглах эрхийн эмх замбараагүй байдал юм. 1996-аас 2003 оны хооронд засгийн эрх шилжсэнтэй холбоотойгоор өөр өөр засгийн газар, босогчдын бүлэглэлүүд уул уурхай ашиглах олон янзын эрх олгосон байдаг¹²². Лютундулагийн Парламентын Комиссийн 2005 оны тайланд хууль бус буюу улс орны хөгжилд оруулах хувь нэмэр багатай гэдэг үндэслэлээр 16 бизнесийн гэрээг дахин хэлэлцэж байгуулах шаардлагатай гэсэн санал зөвлөмж гаргасан байна. Засгийн газар энэ санал зөвлөмжийн талаар арга хэмжээ хараахан аваагүй байна.

Хэрвээ БНАКУ-ын ард түмэн байгалийн баялгийнхаа олборлолтын үр шимийг урт удаан хугацаанд хүртэе гэвэл авилгатай тэмцэх асуудал гол ач холбогдолтой. Транспаренси Интернэшнл байгууллагын авилгын ухамсрын индексэд БНАКУ 136 дугаар байр эзэлсэн бөгөөд ОУВС-гийн саяханы нэгэн тайланд “Авилга гүнзгий нэвчсэн хэвээр бөгөөд бизнесийн уур амьсгалыг сайжруулахад гол саад тотгор болж байна” гэжээ¹²³. Тус улсын Засгийн газар Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгад нэгдэн орох сонирхлоо илэрхийлсэн бөгөөд 2005 оны 11 дүгээр сард ОУИТБС-ын Үндэсний Хороогоо байгуулжээ.

Эдийн засгийн сэргэлтэд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг

Уул уурхайд оруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх явдал бол тус засгийн газрын эдийн засгаа сэргээх стратегийн нэг гол хэсэг юм. Дээр дурдсан бэрхшээлүүдийг үл харгалзан тус бүс нутагт алт олборлолтын олон улсын компаниуд эргэн ирж байна. Үүнд БНАКУ-ын ашигт малтмалын орд газруудын үнэ цэнэ хүчтэй хөшүүрэг болж байна. Канадын Банро корпораци

БНАКУ-ын Өмнөд Киву мужийн Туангиза-Намоягийн алтны бүсэд хайгуулын ерөмдлөг хийж байна. АнглоГоулд Ашанти компани Монгбуалу хотын ойролцоох Итуригийн зүүн хойд бүс нутагт хайгуулын ажил гүйцэтгэж байна. Мөн Мото Гоулдмайнес компани тус улсын зүүн хойд нутагт эрэл хайгуул хийж байна. Харин БНАКУ-ын зүүн хэсэгт үндэсний засгийн газрын эдлэх эрх мэдэл бага байдаг. Ийнхүү засаг захиргааны чадавхи хязгаарлагдмал байгаа нь үйл ажиллагаа явуулж буй газар нутгийнхаа эдийн засгийн тогтвортой сэргэлтэд хувь нэмэр оруулж, зөрчил мөргөлдөөн дахин өдөөхгүй байх асар их үүрэг хариуцлагыг компаниудын нуруунд үүрүүлж байгаа юм.

Итуригийн бүс нутаг дахь алт олборлолт

Конгийн зүүн хойд хэсэгт зуу гаруй жилийн турш алт олборлолт явагдаж ирсэн. Колонийн дэглэмийн үед Бельгийн СОКИМО компани энэ бүс нутгийн алтны уурхайнуудыг эзэмшиж байв. 1966 онд тус компанийг үндэсний компани болгож “Оффисе дес Минес д’Ор Кило-Мото” буюу ОКИМО гэж нэрлэжээ. ОКИМО компани 1992 оноос хойш гадаадын уул уурхайн хувийн компаниудтай хамтран янз бүрийн хамтарсан үйлдвэр байгуулсан байна. Тус бүс нутагт зөрчил мөргөлдөөн гарч уул уурхайн үйл ажиллагаа түр зогссон гэж үзэж байх зуур Ерөнхийлөгч Лаурент Кабилагийн засгийн газар байгуулагдсан гэрээнүүдийг өөрчилж, шинэ яриа хэлэлцээ хийснээр нөхцөл байдал улам бүр түвэгтэй болсон юм. 2001 онд АнглоГоулд Ашанти компани өөрийн харъяа Ашанти Гоулдфийлдс компаниар дамжуулан Монгбуалу хотын орчимд төвтэй уурхайн газар нутаг болох 40 дүгээр ашиглалтын талбайд бүхэлд нь хайгуул явуулах эрх авсан байна.

Байгалийн баялаг ба зөрчил мөргөлдөөн

Дайн БНАКУ-ын зүүн хойд хэсэгт ихээхэн сүйтгэл авчирсан. Уганда, Руанда хоёрын хилд ойрхон байрладаг тус бүс нутаг эдгээр улсын үндэсний арми болон тэдний дэмжлэгтэй зэвсэгт дайчдын тулаанд өртсөн юм. Энд Конгийн эх орончдын Хема эвлэлийн зэвсэгт дайчид ба Лендугийн Үндсэрхэг, нэгтгэх үзэлт фронтын (ҮНҮФ) хоорондын үндэс угсааны сөргөлдөөн үүсч, дор бүрнээ Уганда, Руанда улсуудаас дэмжлэг авч байснаас гадна янз бүрийн бүлэглэлүүд алтны уурхайн газруудыг хяналтдаа авахыг эрмэлзэж байв. Монгбуалу хотыг эзэлж авахын төлөөх таван тулалдаан болсны улмаас 2002 оны 6 дугаар сар, 2004 оны 9 дүгээр сарын хооронд наанадаж хоёр мянган энгийн иргэд амь насаа алджээ¹²⁴. Түүнээс ч олон хүмүүс гэр орноосоо дайжиж, өлсгөлөн, өвчин, цаг агаарт нэрвэгдэн амь насаа алдсан байна.

АнглоГоулд Ашанти (АГА) компани 2003 онд тус бүс нутагт эргэн ирж, 2004 онд хотхоноо байгуулсан бөгөөд энэ үед тус газар нутагт зэвсэгт дайчдын идэвхтэй хяналт хэвээр байв. Хүний Эрхийн Манаа байгууллага “Алтны гай” хэмээх 2005 оны тайландаа тус компани ба ҮНҮФ-ын хоорондын хэлхээ холбоог дэлгэрэнгүй харуулсан байдаг. Ийнхүү зэвсэгт дайчидтай харилцаж байснаараа АГА компани

хүний эрхийн ноцтой зөрчил гаргаад байсан байгууллагад нэр хүндийн төдийгүй санхүүгийн туслалцаа үзүүлсэн гэж буруутгасан байна. Үүний хариуд тус компани ҮНҮФ-той тогтоосон бүх харилцаагаа тасалж, мөн ҮНҮФ-ынхонд санхүүгийн туслалцаа үзүүлснээ үгүйсгэжээ. Энэ явцад засгийн газрын хүчнийхэн Монгбуалуд тогтоох хяналтаа нэмэгдүүлж, зэвсэгт дайчдыг эргэн тойрны хөдөө нутаг руу шахсан байна.

Алт олборлолт дотоодын эдийн засагт ямар ашиг тус өгч байна вэ?

Монгбуалугийн ард түмэн өдөр тутмын амин зуулгынхаа төлөө тэмцэхийн зэрэгцээ мөргөлдөөнд сүйдсэн амьдралаа дахин босгохыг хичээж байна. Энэ хот Африкийн хамгийн баян алтны орд газарт байрладаг боловч энд дэд бүтэц гэх юм огт байхгүй. Итуригээс олборлосон алтны ашиг орлого ард түмний амьдралыг сайжруулах, нийгмийг сэргээн байгуулахад зарцуулагдахгүй байна. Олборлолтыг албан бусаар явуулж байгаа учраас ихээхэн хэмжээний алтыг хууль бусаар хил давуулан Угандагаас экспортод эсвэл боловсруулах үйлдвэрт шилжүүлдэг бөгөөд татварын орлого бүрдүүлэлт маш бага байдаг. ОКИМО-гийн гар аргаар олборлолтоос олж байгаа болон АнглоГоулд Ашантигаас түрээсийн хэлбэрээр авч байгаа орлого хэрхэн зарцуулагдаж байгаа нь тодорхойгүй байна.

Гар аргын олборлолт бол Монгбуалугийн дүүрэгт амьдрах аргын нэг юм. Монгбуалуд ойролцоогоор 40000 орчим хүн амьдарч байгаагийн 20000 нь олборлолтод шууд оролцдог хэмээн нутгийн нэгэн удирдагч тооцсон байна. Энэ нь тун хэцүү, аюултай ажил бөгөөд борооны улиралд бараг ажиллах боломжгүй байдаг. Олборлогчид ил уурхайгаас гадна хуучны хоёр гүний уурхайг ашигладаг. 2005 онд энд хэсэгчилсэн нуралт болох үед 12 уурхайчин амиа алджээ.

Монгбуалугийн олон иргэн гар аргаар алт олборлолтоос наад захын хэрэгцээгээ хангах төдий амь зууж байна. Буниа хүртэл зам муутай, 90-хэн км зам хэдэн ч өдөр авч магадгүй учраас эндэхийн хүн ам тусгаарлагдмал байдаг. Хотод юмны үнэ өндөр учраас уурхайчид дөнгөж амьжиргаагаа залгуулах төдий орлого олдог гэж ярьж байна. Орлогын хэмжээ тодорхойгүй бөгөөд өдөрт олсон алтны хэмжээнээс хамаардаг байна. Ихэнх хүмүүс орлогодоо нэмэр болгож бага хэмжээний талбайд идэшний ногоо тарьдаг. Гэвч уул уурхайг орлох ажил ужиг хомсдолтой байдаг байна.

“Заримдаа маш хүчтэй бороо орж ухсан нүх эргээд шавраар дүүрдэг тул анх хийж эхэлсэн байдалдаа эргээд очдог. Энд ажиллаж амьдрах маш хэцүү, гэхдээ өөр ажил байхгүй учраас чаддагаа л хийхээс өөр аргагүй болдог.”

Монгбуалугийн гар аргаар олборлогч

Ийм нөхцөлд гар аргаар олборлогчид олон улсын уурхайн компаниудыг илүү аюулгүй ажлын байр, илүү сайн хөдөлмөрийн нөхцлийн боломжит эх сурвалж гэж үзэх нь аргагүй юм¹²⁵. Гэхдээ АнглоГоулд Ашанти компани томоохон хэмжээний үйл ажиллагаа явуулж эхэллээ ч гэсэн одоо уурхайд найдан амьдарч буй бүх хүмүүст хүрэлцэхүйц хангалттай тооны ажлын байр бий болгож чадахгүй билээ.

АнглоГоулд Ашантигийн БНАКУ дахь үйл ажиллагаа

АнглоГоулд Ашанти бол дэлхийд гуравт орох томоохон алт олборлогч юм. Тус компани дэлхийн хэмжээнд явуулж буй үйл ажиллагаанаасаа 2004 онд 188 тонн алт үйлдвэрлэсэн байна. Өмнөд Африкийн БНУ-д төвтэй энэ компани одоо Англо Американ группийн бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд Гана, Мали, Намиби, Танзани улсуудад ил уурхай, Гана, Өмнөд Африк улсад гүний уурхай ажиллуулдаг.

БНАКУ-д АнглоГоулд Ашанти өөрийн салбар АнглоГоулд Ашанти Кило (АГК)-р дамжуулан үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь АнглоГоулд Ашанти ба Конгийн улсын уул уурхайн компани ОКИМО хоёрын хамтарсан үйлдвэр юм. АнглоГоулд Ашанти энэ хамтарсан үйлдвэрийн хувьцааны хяналтыг багцыг эзэмшдэг. АГК компани одоо зөвхөн хайгуулын шатандаа явж байна. Одоогийн хайгуул явуулж байгаа газар нь 10000 км² талбайг хамарсан хайгуулын лицензийн дөнгөж 150 км²-г эзэлж байна. Ашанти гэрээт тайлбайнхаа сарын түрээсийг ОКИМО-д киншясагаар төлдөг. Энэхүү гэрээт талбай нь нилээд том хэмжээний алт ихтэй газар нутгийг хамардаг бөгөөд тус компаний хамтарсан үйлдвэрийн хөрөнгийн 86.22 хувийг эзэмшдэг. Одоо ОКИМО, АГА хоёрын хооронд ашиглалтын талбайтай холбоотой гэрээгээ дахин байгуулж, улмаар БНАКУ-ын ард түмний эрх ашгийг илүүтэй тусгах ёстой эсэх талаар маргаан өрнөсөөр байна. Ялангуяа Лютундулагийн тайланд гэрээг дахин хэлэлцэж байгуулахыг тусгайлан санал болгож байна. Засгийн газар уг гэрээг дахин хянаж үзэх гэж байгааг АГА компани нааштай хүлээж авахаа олон нийтэд мэдэгдээд байна.

Монгбуалуд тогтвортой уул уурхай эрхлэхэд тулгарах сорилтууд:

АнглоГоулд Ашанти компани очиж ажилласнаар нутгийн ард иргэдийн амьдрал сайжрах ёстой гэсэн зарчимд тулгуурлан ажиллах нийгмийн зөвшөөрөлд АГА тулгуурлаж байна. Хэрвээ тус компани ажилласнаар Монгбуалугийн ард түмний амьдрал сайжирна гэж үзэж байгаа бол дараахь таван сорилтыг онцлон шийдвэрлэх шаардлагатай болно:

1. Зөрчилдөөнийг сэрэмжлэн зайлуулах горьдлогыг хэрэгжүүлэх

АнглоГоулд Ашанти компани зөрчилдөөнтэй буюу зөрчилдөөн үүсэхүйц нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулах сонголт хийсэн. Монгбуалуд төрийн хяналт маш хязгаарлагдмал байдаг. Мөн энэ бол угсаатан хоорондын хурцадмал байдал ихтэй, зэвсэгт дайчид хотын гадна үйл ажиллагаа явуулсан хэвээр байгаа газар юм. Хэрэв тус компани энэ бүс нутгийн угсаатан хоорондын зөрчлийн түгшүүртэй байдлыг хурцатгахгүй байя гэвэл сайтар төлөвлөсөн, идэвхтэй арга хэмжээ авах шаардлагатай болно.

Нутгийн ард иргэд Ашантигийн ажил эрхлэлтийн болон ажилд авах арга барилын талаар хэдийнээ санаа зовж эхлээд байна¹²⁶. Энэхүү талбайг өмнө нь эзэмшиж байсан КИМИН компанид ажиллаж байсан 500 орчим ажилчны хөдөлмөрийн гэрээг 2003 онд Ашанти компани хүчингүй болгосон бөгөөд ажлаас халсны тэтгэмж хангалттай өгөөгүй байна. 2006 оны 1 дүгээр сард энд ажиллаж байсан хэсэг ажилчид тэдний асуудлыг судлан шийдвэрлэх хүртэл тус компаний үйл ажиллагааг түр зогсоохыг үндэсний засгийн газраас шаардсан юм¹²⁷. Одоогоор тус компани хуучин ажилчдын төлөөлөгчидтэй тохиролцоонд хүрснээ мэдэгдээд байна.

Ашанти одоо 100 орчим ажилчинтай бөгөөд үүний бараг тал хувь нь гэрээгээр ажиллагсад ажээ. АГА ашиглалтын талбайд амьдардаг хүмүүсээс бус, Итуригийн гаднаас хүмүүс ажилд авч байгаад нутгийн иргэд сэтгэл зовниж байна. Энэ нутгийн уугуул иргэд болох Няли хүмүүсийн зарим нь тус компани ажлынхаа төлөвлөгөөний талаар тэдэнтэй уулзаж ярих ёстой гэжээ¹²⁸.

2. Ард иргэдтэй үр нөлөөтэй зөвлөлдөх

2005 оны 1 дүгээр сард АГА компани Нийгмийн Хөгжлийн Хороо байгуулсан бөгөөд тус хороо нийгмийн хөгжлийн төслүүдийн талаар хэлэлцэхээр компанитайгаа сар тутамд уулздаг байна. Хорооны гишүүдэд нутгийн лам, хотын дарга, сургуулийн захирлууд ордог. Одоогийн хорооны ач холбогдол, тэдний үзэл бодлыг компаниас сонсож байгаа байдлын талаар хорооны гишүүдийн дунд асуулга явуулсан байна¹²⁹. АнглоГоулд Ашанти компани тус хороог илүү олон төлөөлөлтэй болгож, Оролцогч талуудын чуулга уулзалт болгохоор төлөвлөж байгаа аж. Энэ шинэчлэлийг болгоомжтой хийж, нутгийн ард иргэдтэй нягт хамтарч ажиллах шаардлагатай.

Хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэхээс гадна түүний бүрэн эрхийг өргөжүүлж, нийгмийн хөгжлийн төслүүдийг сонгохоос гадна компаний үндсэн үйл ажиллагааны талаар авч үздэг болгож болох юм. Олон талт оролцоог хангах нь үйл ажиллагаа явуулах нийгмийн тусгай зөвшөөрлийн нэг хэсэг болоод зогсохгүй ард иргэдтэй нээлттэй яриа хэлэлцээ өрнүүлэх стратеги болно гэж АГА компани дурдсан байна. Одоогоор компаний үйл ажиллагаа, ашиглалтын төлөвлөгөөний

талаар өргөн хүрээтэй зөвлөлдөх энэ төрлийн ямар нэг чуулга уулзалт эсвэл бүтэц бий болоогүй байна. Хэрэв тодорхой бүрэн эрх, өргөн хүрээтэй төлөөлөлтэйгээр боломжийн хэмжээнд байгуулж чадвал шинэчлэн байгуулсан Хороо чухал үүрэг гүйцэтгэж болох юм.

Хэрэв АГА томоохон цар хүрээтэй алт олборлолт явуулахаар шийдэх юм бол тус бүс нутгийг ихээхэн өөрчлөнө. Жишээлбэл, тус компани өмнө нь ажиллаж байсан Бельгийн компаний адилаар гүний уурхай ажиллуулна гэж Монгбуалугийн олон хүн төсөөлж байгаа. Үнэн хэрэгтээ, уг компани ил уурхай ажиллуулахаар төлөвлөж байгаа юм. Хайгуулын үе шат үргэлжлэн явагдаж байх зуур АГА компани ашиглалтын талбайг хөгжүүлэх төлөвлөгөөгөө нутгийн ард иргэдтэй аль болох эртнээс зөвлөлдөж, байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөний үнэлгээнээсээ Монгбуалуд томоохон хэмжээний алт олборлолт явуулахын бүрэн утга учрын талаарх мэдээллийг хуваалцаж байх нь онцгой ач холбогдолтой. Ингэж бодитойгоор зөвлөлдөх нь нэгэнт гаргачихсан шийдвэрээ ард иргэдэд зүгээр нэг танилцуулахаас илүү нутгийн ард иргэдэд тус компаний явуулах үйл ажиллагааны арга барилд нөлөөлөх боломжийг олгох юм.

“Энэ Хороонд Монгбуалугийн эргэн тойронд буй бүх тосгоны дарга нар, бизнесийн хороо, гар аргаар алт олборлогчдын хороо, сургууль, эмнэлэг, орон нутгийн сүм хийдүүд, жолооч нарын хороо болон орон нутгийн бүх хороодын төлөөлөгчдийг оруулахыг бид хүсч байна. Бүх үндэс угсааны ард иргэдийн төлөөллийг ч оруулах шаардлагатай. Хороо үнэхээр бүрэн төлөөлөлтэй байж чадвал нутгийн ард иргэдийн хөгжлийн талаар авч хэлэлцэх байр суурь нь дээшилнэ.”

Жан-Пьер Бикилисенде Бадомбо,
Хорооны гишүүн бөгөөд Хотын дарга

3. Орон нутгийн горьдлого: корпорацийн ивээл үү эсвэл хууль ёсны үүрэг үү?

АГК-ийн Монгбуалуд гүйцэтгэх ёстой үүргийн талаар нутгийн ард иргэд маш өргөн хүрээтэй олон янзын үзэл бодолтой байдаг. Тус компани КИМИН-ий гэрээг өвлөн авсан учраас КИМИН-ий гүйцэтгэж байсантай ижил үүрэг хүлээнэ гэсэн горьдлого бий. Гэтэл эцэс төгсгөлгүй их хүсэлт шаардлага ирж байна гэж компаний төлөөлөгчид мэдэгдэж байгаа учраас тэрхүү горьдлого нь тус компаний үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байдал үүсэхэд хүргэжээ. Жишээлбэл, Монгбуалу, Буниагийн хоорондын замыг засч сайжруулах нь энэ компаний нэн тэргүүнд хүлээх үүрэг гэж олон хүн үзсэн байна.

Урьд нь Монгбуалугийн ганц л эмнэлэг КИМИН-д харьяалагддаг байжээ. Энэ эмнэлгийн эм тарианы төлбөрийг АГА төлж байгаа боловч ажилтнууд нь энэ компанитай ямар холбоотойгоо сайн мэдэхгүй байна. Мөн АГА компани

Монгбуалу дахь Киломотогийн бага ба дунд сургуулийн төсөвт аль хэдийн хандив өргөж эхэлжээ. Тус сургуулийн хичээлийн эрхлэгчийн хэлж байгаагаар, компани сургуулийн 38 ажилтанд зориулж сард 2000 ам. доллар өгдөг нь тус хотын амьжиргааны түвшинг хангах цалинд хүрэлцдэггүй байна. Эмнэлгийн нэг адил сургуулийн ажилтнууд ч бас хэнд харъяалагддаг болохоо сайн мэддэггүй ажээ.

Монгбуалугийн ашиглалтын талбай нь уурхай гэхээсээ илүү хайгуулын талбай учраас тус компани гүйцэтгэх үүргээ хязгаарлагдмал гэж үзэж байгаа боловч энэ тухайгаа нутгийн ард иргэдэд тодорхой мэдээлж ойлгуулах талаар ихийг хийх шаардлагатай байгаагаа хүлээн зөвшөөрсөн байна¹³⁰. Ямар нэг хурцадмал байдал үүсэхээс зайлсхийхийн тулд аль хандив тусламж нь компани ОКИМО-той байгуулсан гэрээний дагуу хүлээсэн хууль ёсны үүрэг, аль нь сайн дурынх болох талаар компани тодорхой мэдээлэл өгч байх нь онцгой чухал. Ашиглалтын талбайн талаар одоо байгуулаад байгаа гэрээгээ хэвлэн нийтлэх нь эхний чухал алхам болох болно.

“Засгийн газраас эндэхийн багш нарт хэдэн жил цалин өгөөгүй. Иймээс миний хувьд эцэг эхчүүдийн төлсөн сургалтын төлбөрөөс сард дөнгөж 30 ам. доллар л авдаг. Манай сургуульд 6-12 насны хүүхдүүд хамрагддаг. Эцэг эхчүүд хүүхдээ сургуульд явуулахын тулд сард нэг хүүхдийн нэг доллар төлдөг. Олон хүүхэд төлбөрөө төлж чадахгүйгээс болж сургуулиа орхин уурхайд ажиллаж эхэлдэг. Тэдний зарим нь үдээс хойш хичээлээ тараад уурхайд ажилладаг. Жил бүр бид нилээд олон хүүхэдтэй хичээлээ эхэлдэг боловч хэсэг хугацааны дараа тэдний хичээлд ирэх нь улам цөөрдөг. Эцэг эхчүүд бүгд л хүүхдүүдээ сургуульд явуулахыг хүсдэг боловч яаж ч чаддаггүй.”

Монгбуалугийн сургуулийн багш

4. Гар аргаар болон бага хэмжээгээр алт олборлогчид

АнглоГоулд Ашанти компани Монгбуалуд өргөн цар хүрээтэй уурхайн үйл ажиллагаа явууллаа ч зөвхөн хязгаарлагдмал тооны ажлын байр л бий болгох болно. Өмнө нь КИМИН компани уурхайчдын холбооноос алт худалдан авдаг систем ажиллуулж байсан бөгөөд Ашанти ч бас үүнтэй төстэй үүрэг гүйцэтгэх болов уу гэж зарим гар аргаар олборлогчид найдаж байна. Өөр нэг боломж нь ажилчдын хоршоо байгуулах явдал байж болох юм. Одоогоор гар аргаар олборлогчид олсон орлогынхоо 30 хувийг ОКИМО-д төлөх ёстой ч тэр болгон төлөхгүй байх нь олонтаа. Олон уурхайчид АГА-ын ашиглалтын талбайд үйл ажиллагаа явуулж байгаа учраас баталгаагүй нөхцөлд байгаагаа хүлээн зөвшөөрдөг.

“Уурхайчид ашигт малтмалыг яаж олборлох, олборлосон алтаа Ашантид хэрхэн худалдах талаар болон дайны дараа энд амьдрал шинээр бий болгоход алтны давуу талыг компани, засгийн газар, хүн амын зүгээс хэрхэн ашиглах вэ гэдэгт туслах арга хэмжээг Ашанти компани зохион байгуулах хэрэгтэй байна.”

Няли иргэдийн уурхайчдын холбооны төлөөлөгч

АнглоГоулд Ашанти компани бусад оронд гар аргаар олборлогчидтой хамтран ажиллаж байсан туршлагатай. Бага хэмжээний олборлох ажиллагааны нилээд нь осолтой байдаг онцлогтой учраас энэ нь тийм ч амар ажил биш юм. Тухайлбал, гар аргаар алт боловсруулах явцад мөнгөн ус олон удаа ашигладаг учраас одоо явуулж буй олон үйл ажиллагаа эрүүл мэнд, аюулгүй байдалд бодитой эрсдэл учруулдаг байна. Гэвч энэ дүүрэгт ажиллаж буй мянга мянган хүмүүсийн хувьд энэ бол амь зуух ганц хэрэгсэл юм. Ашанти, ОКИМО хоёрын аль аль нь одоогийн гар аргаар олборлох ажиллагаанд үнэлэлт өгч, уурхайчид зохион байгуулалтад орж, үйл ажиллагаагаа албан ёсны болгоход туслах үүрэгтэй. Саяхан АнглоГоулд Ашанти компани PACT, USAID, DFID, ОКИМО болон бусад оролцогч талуудтай хамтран тухайн ашиглалтын талбайд гар аргаар болон бага хэмжээгээр явуулж буй олборлолтод үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг эхлүүлсэн байна. Энэ дүүрэгт зөрчил мөргөлдөөн, ядуурал хурцдахаас зайлсхийхийн тулд уурхайд ажиллаж буй ард иргэдийн төлөөлөгчидтэй хамтран хөтөлбөр боловсруулж амжилттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

5. Ил тод байдал ба авилгатай тэмцэх асуудлыг дэмжих

Хэдийгээр АнглоГоулд Ашанти компани БНАКУ дахь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын гурван талт санаачилгад оролцож байгаа ч, үнэн хэрэгтээ иргэний нийгмийн тэргүүлэх байгууллагууд нь ч энэ талаар мэдэхгүй байв. Компаниас улсын болон орон нутгийн түвшинд төлж буй төлбөрүүдийнхээ талаар тодорхой мэдээлэл гаргаж, гадуур дэгдээд байгаа зарим нэг цуу яриа, тодорхойгүй байдлыг арилгах нь тус компанид өөрт нь л ашигтай билээ.

“Ашанти, засгийн газар хоёрын харилцааны ил тод байдлыг ч бас сайжруулах шаардлагатай. Ашанти засгийн газарт мөнгө төлж байгаа нь тодорхой ч хэдийг төлж байгаа нь тодорхойгүй байна. Ашанти, ард түмэн хоёрын хооронд, мөн ард түмэн, засгийн газар хоёрын хооронд ил тод байдал хэрэгтэй байна. Тэгвэл ашиг орлогын хэдэн хувь нь хүн амд очиж байгааг ард түмэн мэддэг болохын зэрэгцээ нутаг орноо хөгжүүлэхэд энэ мөнгийг яаж ашиглахаа шийдэж чадах юм.”

Монсайнор Диюдонне Уринги Уучи, Буниагийн хамба лам

Тус компани БНАКУ-ын төр засагт болон төрийн байгууллагуудад төлсөн бүх төлбөрөө тус улсын засгийн газарт аль хэдийн илээр тайлагнасан боловч засгийн газар энэ тоо баримтыг хараахан нийтийн хүртээл болгоогүй байна гэж мэдэгдсэн байна¹³¹. Энэ нь, компани өндөр эрсдэл бүхий газар ажиллаж байгаа учраас хүний эрхийн зөрчил гаргаж, зөрчил мөргөлдөөнд хувь нэмэр оруулсан гэж үзэгдэх магадлалыг багасгах үүднээс АнглоГоулд Ашантигаас авч хэрэгжүүлж буй багц арга хэмжээний нэг хэсэг юм. Мөн энэ компани БНАКУ-д явуулсан хайгуулын төслийнхөө тайланд засгийн газарт төлсөн төлбөрүүдийнхээ мэдээллийг оруулах бодолтой байгаа нь дэмжүүштэй шинж тэмдэг юм.

Компаний хувьд бүх төлбөрийнхөө мэдээллийг, түүний дотор тухайлбал ОКИМО-д төлж буй түрээсийн төлбөр зэргийг нийтлэснээр тэргүүн туршлагын жишиг тогтоох тодорхой боломж бүрдэх юм. Энэ нь АнглоГоулд Ашанти ил тод байдлын асуудлыг хариуцлагатайгаар авч үзэж байгаагаа харуулахын зэрэгцээ БНАКУ-д ажиллаж буй бусад компаниудад үнэ цэнэтэй үлгэр жишээ болох юм. Үүний нэг адилаар, нийгмийн чанартай болон нутгийн ард иргэдэд тулгуурласан төслүүдэд үзүүлж буй дэмжлэгүүдээ нарийвчлан задлаж нийтлэх нь тус компаний хувьд ач холбогдолтой байх болно. Энэ нь дээрх мөнгийг үр ашигтай зарцуулах нөхцлөөр хангаад зогсохгүй компани тодорхой хүмүүс, угсаатны бүлгийг илүүд үздэг гэсэн гүтгэлгийг зогсоох болно.

Санал зөвлөмжүүд

АнглоГоулд Ашантид зориулсан санал зөвлөмжүүд:

- Шинэчлэн байгуулсан Нийгмийн хөгжлийн хороонд ашиглалтын талын бүхий л оролцогчид, түүний дотор эмэгтэйчүүд, янз бүрийн угсаатны бүлэглэлийн төлөөллийг оруулах. Хорооны бүрэн эрх зөвхөн нийгмийн хөгжлийн төслүүдийг авч хэлэлцдэг хүрээнээс хальж, хороог ард иргэдэд нөлөөлж буй компаний үндсэн үйл ажиллагааны бүхий л асуудлыг авч хэлэлцдэг чуулга уулзалт болгон өргөжүүлэх ёстой.
- Монгбуалуд байрлаж, ард иргэдтэй нягт хамтран ажилласны үндсэн дээр тэдэнд үр ашгаа өгөхүйц төслүүдийг хэрэгжүүлдэг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан идэвх зүтгэлтэй мэргэжилтэн авч ажиллуулвал зохино.
- Компани нутгийн иргэдтэй мэдээлэл солилцож, тэдэнд санал хүсэлтээ илэрхийлэх боломж олгох, тогтмол яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд чиглэсэн харилцааны тодорхой стратеги боловсруулж ажиллах ёстой.

Шударга ёс тогтооцгооё

- Хөдөлмөрийн гэрээ нь хүчингүй болсон ажилчдын маргааныг Конгийн хөдөлмөрийн хуулийн дагуу шийдвэрлэж, үлдсэн ажилчдад өөрсдийн үйлдвэрчний эвлэл байгуулах боломжийг олгох ёстой.
- Компани янз бүрийн угсаатны бүлгээс ажилчид авч ажиллуулах нөхцлийг хангавал зохино.
- ОКИМО-той хамтарч гар аргаар болон бага хэмжээгээр олборлогчидтой харилцах хөтөлбөр боловсруулахад нутгийн гар аргаар олборлогчдын төлөөлөгчдийг бүрэн оролцуулах.
- АнглоГоулд Ашанти компани ОКИМО-д төлж буй төлбөр, байгуулсан гэрээгээ дэлгэрэнгүй нийтлэх, үндэсний хэмжээний ОУИТБС-д идэхтэй оролцох замаар БНАКУ дахь орлогын ил тод байдалд эерэг үлгэр жишээ үзүүлэх ёстой.
- Үнэт эдлэлийн хариуцлагатай үйл ажиллагааны зөвлөлийн гишүүн уул уурхайн компаниудын нэгийн хувьд АнглоГоулд Ашанти компани ҮЭХҮАЗ-ийн арга ажиллагааны дүрмийг нарийн чанд боловсруулж Алтан дүрэмд (хуудас 14-г үзнэ үү) нийцүүлэн гаргахад шахалт үзүүлж ажиллах ёстой.

ОКИМО–д зориулсан санал зөвлөмжүүд:

- Орхигдсон уурхай дахь гар аргаар олборлох тухай бодлогоо эргэн хянаж, гар аргаар олборлогчдод зориулсан илүү албан ёсны, тогтвортой хөтөлбөрүүд боловсруулж ажиллах талаар эдгээр уурхайчидтай болон АнглоГоулд Ашантитай хамтран ажиллах.
- Хүлээн авсан төлбөрүүдээ дэлгэрэнгүй нийтэлж, энэ мөнгийг яаж зарцуулснаа тодорхой болгох.
- Алт олборлох концессийн эрх олгосон бүх гэрээгээ нийтлэх. Хэрэв АГА-тай байгуулсан гэрээг дахин хэлэлцэх болвол гэрээнд БНАКУ-ын ард түмний эрх ашгийг тусгасан байх, гэрээний хоёр талаас ажилчид, нутгийн ард иргэд, байгаль орчны талаар хүлээх хариуцлагыг тодорхой зааж өгсөн байх нөхцлийг ОКИМО хангаж өгөх ёстой.
- Ялгаварлан гадуурхах талаар ойлголт төрөхөөс сэргийлж, ажиллах хүчнийхээ дунд үүссэн зөрчлийг шийдвэрлэж, угсаатан хоорондын хурцадмал байдлыг саармагжуулах чиглэлээр ажиллах.

Бүлэг 6

Өөрчлөлт хийх санал зөвлөмжүүд

Гондурас, БНАКУ хоёрын туршлагаас үзэхэд дэлхийн хамгийн ядуу буурай орнуудын хувьд алт маш олон янзын үр нөлөөтэй болох нь харагдаж байна.

Алтны үнэ өссөөр байгаатай холбогдон алтны уурхайн компаниудын үйл ажиллагааны шууд нөлөөнд хөгжиж байгаа орнуудын ард иргэд улам ихээр өртөн хохирох магадлалтай байна. Түүнчлэн, гар аргаар алт олборлогч сая сая хүмүүс зөвхөн амь зуухын төлөө тэмцэж байна.

Алт олборлолтын хортой үр дагаварыг шийдвэрлэх, ашигт малтмалын нөөц баялгийн үр шимийг түүний эзэн орнууд хүртдэг болох таатай боломж бий болоод байна. Үүнд амжилт олохын тулд үндэсний засгийн газрууд, уул уурхайн салбар, санхүүгийн байгууллагууд, жижиглэнгийн худалдаачид, хэрэглэгчдийн зүгээс олон янзын арга хэмжээ авах шаардлагатай болно.

Иймд ХЧХКША-аас дараахь зүйлсийг уриалж байна:

Нөөц баялаг ихтэй хөгжиж байгаа орнуудын үндэсний засгийн газрууд:

- Хүн амын илүү өргөн хүрээний эрх ашгаас гадна гадаадын хөрөнгө оруулалтыг татах хүсэл эрмэлзлийг тусгасан үндэсний эрх зүйн тэнцвэртэй хүрээг бий болгох. Ийм эрх зүй хүрээ нь:
- Олон улсын хэмжээний хүний эрхийн үүрэг хариуцлагыг хүндэтгэдэг байх;

- Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд хамгийн их шууд өртөж буй хүмүүс уурхайн концессийн эрх олгох шийдвэрт нөлөөлж чаддаг байх явдлыг хангах;
- Нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалдаг байх;
- Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын өндөр стандарт тогтоосон байх;
- Тогтоосон стандартыг хараат бус албан тушаалтнууд үр нөлөөтэй сахиулдаг байх;
- Уул уурхайн компаниудтай байгуулсан гэрээний нарийн ширийн заалт, тэднээс хүлээн авсан бүх орлогыг нийтлэхийг шаарддаг байх;
- Гар аргаар болон бага хэмжээгээр олборлогчдын байр суурийг албан ёсны болгож, тэдний амьжиргаа, ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлд уул уурхай эрхлэгч ард иргэд, компаниудтай хамтран ажиллах.

Их Британий болон Их 8-ын бусад засгийн газар:

- НҮБ-ын норм хэм хэмжээнд тулгуурлан, үндэстэн дамнасан компаниудад зориулсан заавал дагаж мөрдөх олон улсын стандартууд, ард иргэдэд учруулсан хохирлыг барагдуулах үр нөлөөтэй арга хэрэгсэл боловсруулахад дэмжлэг үзүүлэх.
- Компаниуд явуулж буй үйл ажиллагааныхаа байгаль орчинд болон нийгэмд үзүүлэх үр нөлөөг тайлагнадаг байх хууль ёсны шаардлага бий болгох.
- Хөрөнгийн биржийн жагсаалтад бичигдэх олборлох үйлдвэрлэлийн компаниуд засгийн газруудад төлсөн бүх төлбөрөө улс орноор нь задлан дэлгэрэнгүй нийтэлдэг байхыг шаардах, энэ шаардлагыг нягтлан бодох бүртгэлийн стандартад оруулах.
- Улс орнууд ба компаниуд ОҮИТБС-ын дагуу хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхийг харуулах нарийн чанд механизм бий болгож хэрэглэх, энэ үйл явцын бүхий л шатанд иргэний нийгмийн бүлгүүдийг идэвхтэй оролцож чаддаг болгох замаар Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын итгэл хүлээх чадварыг хадгалах.
- Ялангуяа хүний эрхийн хамгаалалт, орлогын ил тод байдал, байгаль орчны стандарттай холбоо бүхий зохих хамгаалалт бий болгох шаардлагыг бүхий л уул уурхай, олборлолтын үйл ажиллагаанд экспортын зээл, эрсдэлийн даатгал олгох болзол болгох талаар ЭЗХАХБ-ын Экспортын зээл олгох газрын ажлын хэсгийн хүрээнд идэвхтэй ажиллах.

Банкууд ба олон улсын санхүүгийн байгууллагууд:

- Нутгийн уугуул иргэдээс мэдэж гаргасан, үнэ төлбөргүй, урьдчилсан, зөвшөөрөл авах шаардлагыг уул уурхайн төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх урьдач нөхцөл болгон оруулах.

- Аливаа уул уурхайн төслийг санхүүжүүлэхээр тохиролцохын өмнө хүний эрхийн хамгаалалт, орлогын ил тод байдал, байгаль орчны стандартуудтай холбоотой баталгаа гаргасан байх нөхцлийг хангах.

Уул уурхайн компаниуд:

- Хүний эрхийг баримталж, үйл ажиллагааны арга барил нь ард иргэдийн болон угсаатны бүлгүүдийн хооронд үүсээд байгаа хурцадмал байдал, зөрчил мөргөлдөөнийг даамжруулахгүй байх нөхцлийг хангах.
- Үйл ажиллагааныхаа журамд мэдэж гаргасан, үнэ төлбөргүй, урьдчилсан зөвшөөрөл авах зарчмыг оруулах.
- Уурхай ажиллуулах болсон тохиолдолд ард иргэдтэй үр нөлөөтэй зөвлөлдөх зарчмыг нэвтрүүлэх.
- Үйл ажиллагааныхаа тухай мэдээллийг, түүний дотор байгаль орчин, нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөний үнэлгээ, уурхайг хаах төлөвлөгөө, ойр орчмын ард иргэдэд сайн дурын тусламж үзүүлэх төлөвлөгөө зэргийг нийтлэх.
- Үндэсний болон орон нутгийн засгийн газруудад төлж буй бүх төлбөрөө улс орон бүрээр дэлгэрэнгүй гаргаж нийтлэх.
- Хөгжилтэй эсвэл хөгжиж байгаа оронд ажиллаж байгаагаас үл хамааран уурхайн ашиглалтын болон хаасны дараах хугацаанд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын дээд зэргийн стандарт мөрдөж ажиллах.
- Компаний ашиглалтын талбайд ажиллаж буй гар аргаар олборлогчидтой харилцах харилцааны хөтөлбөрийг уурхайд ажиллаж буй ард иргэдтэй хамтран боловсруулах.

Алтны жижиглэнгийн худалдаачид:

- Алтныхаа гарал үүслийг тогтоохын тулд нийлүүлэлтийн сувгаа шалгах.
- "Алтан дүрэм"-д үндэслэсэн үйл ажиллагааны нарийн чанд дүрэм боловсруулах талаар салбарынхаа хүрээнд идэвхтэй ажиллах.

Хэрэглэгчид:

- Жижиглэнгийн худалдаачдын борлуулж буй алтан эдлэл ард иргэд, ажилчдын эрхийг хүндэтгэж, байгаль орчинд учруулах хор хөнөөлийг аль болох багасгах замаар "Алтан дүрэм"-д нийцүүлэн олборлосон алтаар хийгдсэн байх нөхцлийг хангаж байгаа эсэхийг нь тэднээс асуух.

Тайлбар, ишлэл

- ¹ GFMS-н Алтны судалгаа, хуудас 57
- ² дээрхтэй адил, хуудас 81
- ³ дээрхтэй адил, хуудас 57
- ⁴ Darryl Thomas 'Precious and base metals hit new highs' /Үнэт болон үндсэн металлууд шинэ өндөрлөгт гарч байна/, Financial Times, 2006 оны 4 сарын 19
- ⁵ Lehman Brothers, USGS-с Ali, SH-д дахин хэвлэгдсэн *Journal of Cleaner Production* 14 /Илүү цэвэр үйлдвэрлэлийн сэтгүүл/ (2006), хуудас 457
- ⁶ MMSD *Breaking New Ground, Mining, Minerals and Sustainable Development, The Report of MMSD Project* /Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжил шинэ тавцанд гарч байна, Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжил төслийн тайлан/, Earthscan Publications Ltd., London and Sterling VA, 2002.
- ⁷ World Gold Council /Дэлхийн Алтны Зөвлөл/, *A touch of gold: Gold mining's importance to lower-income countries* /Чимх алт: Бага орлоготой орнууд дахь алт олборлолтын ач холбогдол/, 2005 оны 5 сар.
- ⁸ MMSD /Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжил/, өмнө дурдсан бүтээлд, хуудас 101.
- ⁹ дээрхтэй адил
- ¹⁰ MMSD /Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжил/, өмнө дурдсан бүтээлд, хуудас 135.
- ¹¹ Moody, Roger, *The risk we run: Mining, communities and political risk insurance* /Бидний хүлээж буй эрсдэл: уул уурхай, ард иргэд ба улс төрийн эрсдлийн даатгал/, International Books, 2005
- ¹² Banktrack зэргийг үз. NGO Comments on the proposed revision of the Equator Principles /Экваторын зарчмуудыг шинэчлэх төсөлд ТББ-уудын гаргасан санал шүүмжлэл/, 2006 оны 4 сар, www.banktrack.org
- ¹³ Moody, өмнө дурдсан бүтээлд.
- ¹⁴ British Geographical Survey, United Kingdom Minerals Yearbook 2004, Balance of trade in minerals and mineral-based products 1999-2003 /Британий газар зүйн судалгаа, Их Британий Ашигт малтмалын 2004 оны ном, Ашигт малтмал, ашигт малтмалаас гаралтай бүтээгдэхүүний худалдааны тэнцэл 1999-2003/
- ¹⁵ Minerals in Britain 'Past production... Future potential', /Британи дахь ашигт малтмалууд 'Өнгөрсөн үйлдвэрлэл... Ирээдүйн чадамж'/, British Geological Survey DTI, 1999, хуудас 1
- ¹⁶ Mintel Precious Metal Jewellery /Минтелийн үнэт металлан эдлэл/, Market Intelligence, 2004 оны 3 сар, хуудас 53

- ¹⁷ Их Британий Туршилт шинжилгээний газар (Assay Office in Great Britain)-аас өгсөн тоо баримт.
- ¹⁸ Mintel, өмнө дурдсан бүтээлд, хуудас 53
- ¹⁹ дээрхтэй адил
- ²⁰ <http://www.signetgroupplc.com>
- ²¹ “Are you looking for the perfect diamond?” /Та төгс очир алмааз хайж байна уу?/, Amnesty International and Global Witness, 2006 оны 2 сар
- ²² Macfarlane, Magnus, Anne Tallontire, Adrienne Martin *Towards an ethical jewellery business* /Үнэт эдлэлийн ёс суртахуунт бизнесийн зүг/, Natural Resources Institute, University of Greenwich /Грийнвичийн Их сургуулийн Байгалийн баялгийн институт/, 2003 оны 7 сар
- ²³ Дэлгэрэнгүй мэдээллийг www.cred.tv-с үзнэ үү.
- ²⁴ ‘Taking an ethical stance’ *Jewellery in Britain* /Ёс суртахуунтай хандах нь, Британи дах үнэт эдлэл сэтгүүл/, 2005 оны 9 сар
- ²⁵ Michael Ross cited in Renner, Michael *The Anatomy of Resource Wars* /Нөөц баялгийн дайны анатоми/, World Watch Paper 162, 2002 10
- ²⁶ Feeneу, Patricia *The Relevance of the OECD Guidelines for Multinational Enterprises to the Mining Sector and the Promotion of Sustainable Development* /Уул уурхайн салбарын үндэстэн дамнасан компаниудад зориулсан ЭЗХАХБ-ын удирдамжийн учир холбогдол ба Тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих асуудал/. Centre for Energy, Petroleum and Mineral Law and Policy /Эрчим хүч, нефть, уул уурхайн хууль тогтоомж ба бодлогын төв/, 2002 Vol.10 Article 6, хуудас 3 <http://www.dundee.ac.uk/cepmlp/journal/html/vol10/article10-6.html>
- ²⁷ Leyland, Jill *A Touch of Gold: Gold’s mining importance to lower-income countries* /Чимх алт: Бага орлоготой орнууд дахь алт олборлолтын ач холбогдол/, World Gold Council, 2005, 9
- ²⁸ Striking a better balance, The Extractive Industries Review /Илүү сайн тэнцвэр тогтоох нь, Олборлох үйлдвэрлэлий тойм/, 2004, 1
- ²⁹ MMSD / Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжил/, өмнө дурдсан бүтээлд, хуудас 172
- ³⁰ Leyland (2005), өмнө дурдсан бүтээлд, хуудас 7
- ³¹ Байгалийн баялаг олборлосноор валютын ханш өсч, дотоодын үйлдвэрлэлийн ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн өрсөлдөх чадвар буурч, импорт нэмэгдэн, экспорт буурах зэргээр улс орны эдийн засагт үзүүлэх нөлөөг энэ нэр томъёогоор илэрхийлдэг.
- ³² Treasury or trouble? Mining in Developing Countries /Эрдэнэс үү, эндэгдэл үү? Хөгжиж байгаа орнууд дахь уул уурхай/, World Bank and International Finance Corporation 2002 оны 7 сар
- ³³ Miranda, Marta, Chambers, David and Coumans, Catherine, *Framework for Responsible Mining: A Guide to Evolving Standards* /Хариуцлагатай уул уурхайн хүрээ: Хувьсан хөгжиж буй стандартуудын тухай заавар/, WWF & CSP2, 2005 оны 10 сар
- ³⁴ A Load too Heavy: child labour in mining and quarrying, World day against Child Labour /Дэндүү хүнд ачаа: Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөр/, 2005 оны 6 сар, <http://www.ilo.org/public/english/standards/ipecc/wdacl/2005/index.htm> дээр байгаа.

- ³⁵ Macfarlane, Magnus, Tallontire, Anne, and Martin, Adrienne, *Towards an ethical jewellery business* /Үнэт эдлэлийн ёс суртахуунт бизнесийн зүг/, Natural Resources Institute, 2003, <http://www.nri.org/NRET/ethicaljewellery.pdf>
- ³⁶ дээрхтэй адил
- ³⁷ MMSD / Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжил/, өмнө дурдсан бүтээлд
- ³⁸ CEAS буюу Перугийн Хамба лам нарын бага хурлын Нийгмийн арга хэмжээний газраас өгсөн мэдээлэл.
- ³⁹ Тус компани хамаагүй бага хэмжээний (3.8 шоо метр) мод огтлох зөвшөөрөлтэй байсан, Ентре Маресийн эсрэг гаргасан нэхэмжлэлийн эрх зүйн баримт бичиг, 2000 оны 10 сар.
- ⁴⁰ FIAN, *Questionable Advice The World Bank's Influence on Mining Laws in Africa* /Эргэлзээтэй зөвлөгөө: Африкийн Уул уурхайн хуулиудад Дэлхийн Банкнаас үзүүлсэн нөлөө/, 2004
- ⁴¹ Moran, Robert, *More Cyanide Uncertainties, Lessons From the Baia Mare, Romania Spill-Water Quality and Politics* /Цианидийн улам бүр тодорхойгүй болж буй байдал, Румыны Байа Маре дахь хорт бодис алдагдалт ба усны чанар, улс төрийн бодлого /, MPC Issue Paper, No.3, Mineral Policy Center /Ашигт малтмалын бодлогын төв/, 2001
- ⁴² *Striking a better balance, Vol.1* /Илүү сайн тэнцвэр тогтоох нь, Боть 1/, The World Bank Group and Extractive Industries.
- ⁴³ *Framework for Responsible Mining* /Хариуцлагатай уул уурхайн хүрээ/, 2005.
- ⁴⁴ дээрхтэй адил
- ⁴⁵ Перугийн CEAS-д байсан мэдээлэл, эдийн засагч Manuel Glave-с авсан.
- ⁴⁶ Stephen, Carolyn and Mike Ahern, *Worker and Community Health Impacts Related to Mining Operations Internationally, A Review of the Literature* /Олон улсын хэмжээнд явуулж буй уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой ажилчид ба ард иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, Ном, сурах бичгүүдийн тойм/, London School of Hygiene and Tropical Medicine and MMSD, No. 25, 2001 11
- ⁴⁷ *Framework for Responsible Mining* /Хариуцлагатай уул уурхайн хүрээ/-г үзнэ үү.
- ⁴⁸ 2004 оны 10 дугаар сард Энэтхэгт болсон Эмэгтэйчүүд ба уул уурхайн олон улсын гуравдугаар бага хурлын тэмдэглэл, төгсгөлийн мэдэгдэл, тунхаглал, тогтоолуудыг үзнэ үү. (www.mmpindia.org/womenmining.htm)
- ⁴⁹ Leite, Carlos, Weidemann, Jens.. *Does Mother Nature Corrupt? Natural resources, Corruption, and Economic Growth* /Эх байгаль авилгад өртдөг үү? Байгалийн баялаг, авилга ба эдийн засгийн өсөлт/, IMF Working Paper /ОУВС-гийн ажлын тайлан/ WP/99/85. Washington DC: International Monetary Fund, 1999.
- ⁵⁰ Boschini, Anne and Jan Petersson, *Resource Curse or not: a question of appropriability* /Нөөцийн хяслан мөн үү, биш үү: зохистой байдлын тухай асуулт/. 2003. Stockholm University, 2003 http://www.ne.su.se/paper/wp03_12.pdf
- ⁵¹ <http://www.pwyp.org>-г үзнэ үү.
- ⁵² Жишээлбэл, “Statement by Sir Mark Moody Stuart on behalf of AngloAmerican” /Англо Американийг төлөөлж Сэр Марк Мүүди Стюартын хэлсэн үг/, 2005 оны 3 сарын 17; “EITI Statement by Rio Tinto” /Рио Тинто компаний ОУИТБС-ын талаар хэлсэн үг/, 2005 оны 3 сарын 10 зэргийг үзнэ үү.
- ⁵³ Renner (2005), өмнө дурдсан бүтээлд

- ⁵⁴ Gobaal Witness ‘Make it work- Why the Kimberley Process must do more to Stop Conflict Diamonds /Үүнийг ажил болгоё- Яагаад Кимберлий Процесс зөрчилдөөнт очир алмаазыг зогсоох талаар илүү ихийг хийх ёстой вэ/, 2005 оны 11 сар; Human Rights Watch ‘the Curse of Gold’ /”Алтны гай”/, 2005 оны 6 сар; Global Witness ‘Same old story- A background story on natural resources in the Democratic Republic of Kongo’ /Мөн адил хуучин түүх- БНАКУ дахь байгалийн баялгийн түүхэн үндэс/, 2004 оны 6 сар’’
- ⁵⁵ International Alert *Conflict Sensitive Business Practice: Guidance for Extractive Industries* /Зөрчилдөөнд өртөмтгий бизнесийн практик: Олборлох үйлдвэрлэлд зориулсан заавар удирдамж/, 2005.
- ⁵⁶ MMSD / Уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжил/ (2002); Moody (2005); *Dirty Metals Mining, Communities and the Environment* /Бохир металл олборлолт, ард иргэд ба байгаль орчин/, Earthworks and Oxfam America, 2004.
- ⁵⁷ дээрхтэй адил, хуудас 325
- ⁵⁸ Roger Moody, *The Lure of Gold-how golden is future?* /Алтны урхи-ирээдүй хэр алтлаг вэ?/ Panos Media Briefing 19, London, Panos Institute, 1996 оны 5 сар
- ⁵⁹ Framework for Responsible Mining /Хариуцлагатай уул уурхайн хүрээ/
- ⁶⁰ ILO Convention 169 /ОУХБ-ын 189-р конвенци/, 1989.
- ⁶¹ *Breaking promises, making profits: Mining in Philippines* /Амлалтаа эвдэж, ашиг олж байна: Филиппин дэх уул уурхай/, Christian Aid and PIPLinks, 2004 оны 12 сар
- ⁶² Жишээлбэл TVI-н өөрийнх нь гаргасан ‘TVI resours development Phils. Inc’ тайлангийн хуудас 21-25-д дурдсаныг үзнэ үү. Үүнийг ДЧХКША-д 2005 оны 12 дугаар сард тус компанитай танилцах үед өгсөн.
- ⁶³ Christian Aid and PIPLinks (2004), өмнө дурдсан бүтээлд
- ⁶⁴ ДЧХКША-н ярилцлагууд, 2005 оны 12 сар.
- ⁶⁵ *Striking a Better balance, The World Bank Group and Extractive Industries* Volume 1 /Илүү сайн тэнцвэр тогтоох нь, Дэлхийн Банкны Групп ба Олборлох салбарууд, Боть 1/, 2003 оны 12 сар, хуудас 21
- ⁶⁶ AngloAmerican and Rio Tinto, Framework for Responsible Mining /Англо Американ, Рио Тинто компаниуд, Хариуцлагатай уул уурхайн хүрээнд дурдсанаар/
- ⁶⁷ Тухайлбал, Smith, Ann, *Migration and HIV: AIDS in Africa* /Шилжин суурьшилт ба ХДХВ: Африк дахь ДОХ/, Scenarios paper for UNAIDS, 2004-г үзнэ үү.
- ⁶⁸ Department of Minerals and Energy /Эрдэс баялаг ба эрчим хүчний газар/, *A Mineral and Mining Policy for South Africa* /Өмнөд Африкийн Ашигт малтмал ба уул уурхайн бодлого/, White Paper, 1998, http://www.polity.org.za/html/govdocs/white_papers/minerals98.html?rebookmark=1
- ⁶⁹ http://ww.miningwatch.ca/index.php/77/2_killed_in_Solola
- ⁷⁰ www.icmm.com
- ⁷¹ <http://www.cyanidecode.org/>
- ⁷² Nilson, Gavin, “What is Wrong with the Global Support Faculty for Small-Scale Mining?”/Бага хэмжээний уурхайн олборлолтыг дэмжих дэлхий нийтийн хөтөлбөр байхад юу нь болохгүй байна вэ?/, удахгүй гарах эх бичгийн хуулбар
- ⁷³ FIAN, өмнө дурдсан бүтээлд
- ⁷⁴ <http://www.corporate-responsibility.org/>

Шударга ёс тогтооцгооё

- 75 2004 оны тоо баримтууд, Гондурас дахь ОУВС-гийн тайлан, 2005 оны 3 сарын 14
- 76 НҮБХХ Хүний хөгжлийн тайлан 2005: Орлого ба хэрэглээний эзлэх хувийн тоо баримтууд: Хамгийн ядуу 10% нь 0.9%, хамгийн ядуу 20% нь 2.7%, хамгийн баян 20% нь 58.9%, хамгийн баян 10% нь 42.2%.
- 77 Transparency International Corruption Perception Index /Авилгын ухамсрын индекс/, 2005
- 78 Alianza Civica, *Analisis de Costos y Beneficios de la Minería en Honduras*, January 2004, Cuadro No. 3, хуудас 6, хуулбар
- 79 Гондурас дахь ОУВС-ийн тайлан, 2005 оны 3 сар 14 ANAMIMH-с авсан тоо баримт, Direccion Ejecutiva de Fomento a la Minería (DEFOMIN)-д дурдсан, хуудас 12
- 80 Civic Alliance for the Reform of the General Law on Mining /Уул уурхайн ерөнхий хуулийг шинэчлэхийн төлөө Иргэний Холбоо/
- 81 Иргэний Холбооны гишүүнд үндэсний бүх Каримтасууд, ТББ-уудын холбоо (ASONOG), Байгаль орчны Омбудсмэний Газар, Хүний эрхийн судалгаа, сурталчилгааны төв(CIPRODEN), Гондурасын хотуудын холбоо (AMHON), Хүний эрхийн үндэсний комисс (CONADEN), Мэдээлэл сурталчилгаа, ард иргэдийн хөгжлийн Гондурасын төв (СЕНПРОДЕН), Уул уурхайн үйл ажиллагаанд хохирсон ард иргэдийн сүлжээ зэрэг байгууллага ордог.
- 82 Олборлолт, экспортын сарын нийт мөнгөн дүнд ноогдуулах татвар (Dictamen, хуудас 20)
- 83 Fair trade or Free Trade? Understanding CAFTA /Шударга худалдаа юу, чөлөөт худалдаа юу? ТАЧХХ-ийг ойлгох нь/, 2004 оны 7 сар http://www.wola.org/economic/briefs_complete_packet_july04.pdf дээр байгаа.
- 84 Daphne Eviatar 'A Toxic Trade Off' /Хорт бодисын зохист харьцаа/ in the Washington Post, 2005 8 14, B01.
- 85 Fair trade or Free Trade? Understanding CAFTA /Шударга худалдаа юу, чөлөөт худалдаа юу? ТАЧХХ-ийг ойлгох нь/, 2004 оны 7 сар, өмнө дурдсан бүтээлд.
- 86 ANAMINH-д хийсэн ярилцлага, 2006 оны 1 сар
- 87 Glamis Gold News release /Гламис Гоулд компаний хэвлэлийн мэдээ/, 2006 оны 2 сарын 13
- 88 Glamis Gold, Pure gold, solid growth, 2004 Annual report /Цэвэр алт ба баттай өсөлт, Гламис Гоулдын 2004 оны жилийн тайлан/, хуудас 47
- 89 дээрхтэй адил
- 90 Francisco Machado Leiva and Claudia Caracmo, *Las Industrias Extractivas: Minería un mal negocio para Honduras*, ASONOG, 2003
- 91 Inter American Development Bank /Америк хоорондын хөгжлийн банк/, 2004
- 92 IMF Country Report No. 05/385 /ОУВС-гийн Орны тайлан/, Honduras: Statistical Annex /Гондурас: Статистикийн хавсралт/, 2005 оны 3 сар, хуудас 21
- 93 дээрхтэй адил, хуудас 22
- 94 IMF Statistical Report /ОУВС-гийн Статистикийн тайлан/, өмнө дурдсан бүтээлд, хуудас 5
- 95 дээрхтэй адил, хуудас 9
- 96 Civic Alliance /Иргэний Холбоо/, өмнө дурдсан бүтээлд, хуудас 20

- 97 ДЧХКША, Гламис компани хоорондын e-мэйл харилцаа
- 98 дээрхтэй адил, хуудас 10
- 99 Энтре Маресийн Эдуардо Виллакортатай ДЧХКША-н хийсэн ярилцлага, 2006 оны 1 сарын 26
- 100 Cuffe, Sandra *Honduras: The Global Investor's Oasis: Cyanide Pools in the Desert* /Гондурас: Дэлхийн хөрөнгө оруулагчдын баян бүрд: Цөл дэх цианидийн цөөрмүүд/, 2004 оны 4 сар
- 101 Cody, Anna (2001), *The Price of Gold: Gold Mining & Human Rights violations in Honduras* /Алтны үнэ: Гондурас дахь алт олборлолт ба хүний эрхийн зөрчлүүд/, Center for Economic and Social Rights /Эдийн засаг, нийгмийн эрхийн төв/ (CESR)
- 102 Caritas Arquidiocesana, *Estudo Tecnico, Calidad de Agua en el Area de Explotacion Minera del Proyecto San Martin, ubicado en el Municipio de San Ignacio, Departamento de Francisco Morazan, Resumen Ejectivo*, Marzo de 2004
- 103 Defomin, Informe de Monitoreo Ambiental, Mina San Martin, Fecha de Inspeccion: del 13 al 16 diciembre del 2005
- 104 ДЧХКША-ийн ярилцлагууд, 2006 оны 1 сар
- 105 DIRECCION EJECUTIVA DE FOMENTO A LA MINERA (DEFOMIN) 2006
- 106 Civic Alliance /Иргэний Холбоо/, өмнө дурдсан бүтээлд, хуудас 14
- 107 дээрхтэй адил, хуудас 15
- 108 Glamis Gold, *Pure Gold, Solid Growth*, 2004 Annual report /Цэвэр алт ба баттай өсөлт, Гламис Гоулдын 2004 оны жилийн тайлан, хуудас 17/-г үзнэ үү.
- 109 дээрхтэй адил, хуудас 11
- 110 *The Price of Gold: Gold Mining and Human Rights Violations in Honduras* /Алтны үнэ: Гондурас дахь алт олборлолт ба хүний эрхийн зөрчлүүд/, (2001) Anna Cody, Center for Economic and Social Rights /Эдийн засаг, нийгмийн эрхийн төв/ (CESR), <http://cesr.org/honduras>
- 111 дээрхтэй адил
- 112 дээрхтэй адил
- 113 дээрхтэй адил
- 114 дээрхтэй адил
- 115 Civic Alliance /Иргэний Холбоо/, өмнө дурдсан бүтээлд, хуудас 13
- 116 <http://ochaonline.un.org/webpage.asp?Page=1983>
- 117 UN resolution 1457 /НҮБ-ын 1457-р тогтоол/, (2003)
- 118 IMF Democratic Republic of the Congo: Selected Issues and Statistical Appendix /ОУВС, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс: сонгосон асуудлууд ба статистик хавсралт/, 2005 оны 10-р сар, хуудас 46
- 119 Global Witness, *Rash and Ruin: The devastating mineral trade of Southern Katanga* /Глобал Витнесс, Яаралт ба сүйрэл: Өмнөд Катанга дахь ашигт малтмалын худалдааны үр дагавар/, 2004 оны 9-р сар
- 120 IMF (ОУВС, 2005), өмнө дурдсан бүтээлд, хуудас 51
- 121 Human Rights Watch 'The Curse of Gold' /Хүний эрхийн манаа, "Алтны гай"/

Шударга ёс тогтооцгооё

- ¹²² Pole Institute report 'Digging Deeper: How the DR Congo's mining policy is failing in the country' /Улам гүнзгий ухах нь: БНАКУ-ын уул уурхайн бодлого дотооддоо хэрхэн уналтад орж байна вэ/, Goma, 2005 оны 12-р сар.
- ¹²³ IMF (ОУВС, 2005), өмнө дурдсан бүтээлд
- ¹²⁴ Human Rights Watch 'The Curse of Gold' /Хүний эрхийн манаа, "Алтны гай"/
- ¹²⁵ ДЧХКША-с гар аргаар олборлогчидтой хийсэн ярилцлага, 2006 оны 1 сар
- ¹²⁶ ДЧХКША-с Монгбуалуд хийсэн ярилцлагууд, 2006 оны 1 сар
- ¹²⁷ Comite de suivie du dossier des travailleurs licenciés et abandonnés par Ashanti Gold Kilo dans les mines d'or de Kilo a Mongbwalu-с бичсэн захидал.
- ¹²⁸ ДЧХКША-с Монгбуалуд хийсэн ярилцлагууд, 2006 оны 1 сар
- ¹²⁹ ДЧХКША-с Монгбуалуд хийсэн ярилцлагууд, 2005 оны 9 сар
- ¹³⁰ ДЧХКША, АГА хоорондын e-мэйл харилцаа, 2006 оны 4 сар
- ¹³¹ ДЧХКША, АГА хоорондын e-мэйл харилцаа, 2006 оны 4 сар